

# БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛСАН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ТУРШЛАГА СУДЛАХ СУРГАЛТ

2011 оны 6 сарын 27-ноос 7 сарын 1,

2014 оны 2 сарын 10-14-ны өдрүүд



# UIН.МН СУДАЛГААНЫ САН



## Сургалтын тухай

Азийн сан нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Монгол Улсад Авлигатай тэмцэхэд дэмжлэг үзүүлэх төслийг 2006-2011 онд, Монгол Улсад Засаглал, ил тод байдлыг дэмжих хөтөлбөрийг 2012-2014 онд хэрэгжүүлсэн. Тус төсөл авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн хэвшлийг авлигын эсрэг хүчин чармайлтад татан оролцуулах зэрэг олон чиглэлээр ажиллаж ирсэн. Энэ хүрээнд авлигын гэмт хэргийг үр дүнтэй мөрдөн шалгах, прокурорын хяналт тавих, шүүхээр амжилттай шийдвэрлэх ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагуудын ажлын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий Прокурорын газар, Нийслэлийн Прокурорын газар, Улсын Дээд шүүх болон бусад шүүхүүд, Шүүхийн Ерөнхий Зөвлөлтэй хамтран ажилласан билээ. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд тус сан Сингапур улсын авлигатай тэмцсэн туршлагаас судлах сургалтыг Сингапурын Гадаад харилцааны яам, Төрийн албаны коллежтой хамтран 2 удаа зохион байгуулсан. Тус сан сургалтаас олж авсан мэдлэг мэдээллийг Авлигатай тэмцэх чиглэлээр ажиллаж буй хамтрагч байгууллагуудын ажилтан, албан хаагч наортай хуваалцах зорилгоор сургалтын материал, тайлан болон холбогдох уулзалт, хэлэлцүүлгийн материалыг бэлтгэв.

## Сингапур Улс

Сингапур Улс нь 5 сая орчим хүн амтай, арлын орон юм. Газар нутгийн хувьд ердөө 712.4 км<sup>2</sup> бөгөөд дэлхийн хамгийн их хүн амын нягтралтай улсуудын нэг юм. Сингапурын хүн ам ихэвчлэн Хятад, Энэтхэг болон Малайчууд байдаг. Тиймээс олон янзын ёс заншил, итгэл үнэмшилтэй хүмүүс амьдардаг. Малай (үндэсний хэл), Англи (захиргааны хэл), Хятад болон Тамил хэл гэсэн албан ёсны 4 хэлтэй. Тусгаар тогтолцоо зарласнаас хойш буюу 1965-1999 онд Сингапурын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) жилд дунджаар 8.6 хувиар өссөн байдаг. Гэвч сүүлийн 10 жилийн хугацаанд, ялангуяа 1997 оны Азийн санхүүгийн хямрал, 2001 оны АНУ-д болсон террорист халдлага, 2003 оны SARS өвчин, мөн дэлхий нийтийн санхүүгийн хямрал зэрэг нь дээрх өсөлт буурахад нөлөөлжээ.

Сингапурыг анх 1819 оноос Англичууд худалдааны боомт хэлбэрээр ашиглаж байгаад, улмаар 1824 онд Английн колони болсон байна. Газар зүйн ашигтай байрлал нь томоохон худалдааны төв болох цаашдын хөгжилд нь нөлөөлсөн байна. 1942 онд Сингапур Японы эзэнт гүрний мэдэлд орсноор энэ хөгжил удааширсан. Энэ үе Сингапурын түүхэн дэх хамгийн хүнд хэцүү цаг үед тооцогддог. Дэлхийн 2-р дайны дараа Сингапур дахин Английн мэдэлд очсон. 1965 оны 8 дугаар сарын 9-ний өдөр Сингапур Улс тусгаар тогтносон. Сингапур Улсад тухайн үед олон хүн ам, газар зүйн таатай нөхцөл болон хөрш орнуудаас өөр зүйл байсангүй. Цэвэр усны хомсдол, ажилгүйчүүд гээд тулгамдсан асуудал олон байв.

Сингапур нь Английн Вэстминстерийн тогтолцоонд тулгуурласан Парламентын засаглалтай. Засаглалын хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалаас бүрддэг. Сингапурын Засгийн газар хар тамхитай холбоотой асуудалд маш хатуу хяналттай. Мөн хориглосон цэгүүдэд тамхи татах, хог хаяхад 500-1000 амдолларын торгууль ногдуулдаг. Түүнчлэн бохь зажилах хориотой.

**UH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## Сингапурын туршлага

Авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар улс орны удирдагчид сайтар ойлголттой байх ёстой. Тэд удирдагч хүний хувьд хүсэл эрмэлзлэлтэй, бусдын төлөө гэх итгэл үнэмшилтэй, үндсэрхэг, прагматик, хувши хичээх үзэлгүй байх учиртай. Сингапурын Засгийн эрхийг барьж буй намын хувьд цэвэр, хээл хахуулиас ангид байх нь түүний удирдах б зарчмын нэг бөгөөд үнэнч шударга байхыг хүсэх бус, харин заавал биелүүлэх шаардлага тавьдаг. Тиймээс авлигатай амжилттай тэмцэх үндэс суурь бол улс төрийн хүсэл зориг юм.

“Эхлээд бид өөрсдөө жишиг тогтоосон. Хэрэв сайд нар авлигад өртсөн бол хувийн туслах нь үүнийг мэдэж л таарна. Тиймээс зөвхөн авлигагүй биш, бас эдийн засаг, санхүүгийн хувьд арвич хямгач байх жишиг тогтоохыг зорьсон. Бид засгийн газрын зардлыг танахын тулд маш энгийн байдлаар үйл ажиллагааг явуулсан. Ямар ч гарздалгүй, ямар нэг үрэлгэн зугаа цэнгэлгүй, том оффисын байргүй эхэлсэн. Бид ийм жишигийг тогтоосноор бусад нь дагалдсан” Ерөнхий сайд Ли Куан Ию

Төр засгийн хэтийн зорилго, бодлого, хууль тогтоомж хэр сайн байхаас үл хамааран тэдгээрийг бодит үйл ажиллагаа болгох ёстой гол арга хэрэгсэл бол Засгийн газар юм. Гэвч төрийн үйлчилгээний шат бүрт авлига бүгшсаар байгаа нөхцөлд Засгийн газар оршин тогтоно боломжгүй гэдгийг улс төрчид бүрэн хүлээн зөвшөөрдөг. Тийм ч учраас авлигын боломжуудыг таслан зогсоохын тулд хуулийн болон захиргааны бүх арга хэмжээ, боломжтой бүх үйл ажиллагааг явуулж, авлигын хэрэгт сэжиглэгдсэн, түүнд холбогдсон этгээдүүдийг илрүүлэх, хүндээр шийтгэх үйл явцыг түргэтгэх шаардлагатай байдаг.

“Томоохон албан тушаалтнууд авлигад өртөх боломж нээлттэй, өндөр түвшний стандартын шаардлага сүл байгаа уед засаг захиргааны шударга байдал супарч, улмаар нуран унах боломжтой. Улс төрийн манлайллын үнэнч шударга байдал нь тухайн нийгэм дэвшилттэйгээр хөгжих буй, нэгэн хэвийн зогсонги байгаа эсвэл ухарч буй эсэхийг тодорхойлох ихээхэн чухал хүчин зүйл байdag бөгөөд улс төрчдийн авлигын асуудал нь аль нэг улсыг бүтээн босгох эсвэл сүйрүүлэхийг шийддэг гол зүйл юм” Страйтс Таймс сонины нийтлэл, 1997 оны 1 сарын 19

Сингапур улс тусгаар тогтоно үедээ авлигатай ихээхэн автсан улс орон байсан бол өнөөдөр авлигын хувьд хамгийн бага хэмээн үнэлэгдэх орнуудын нэг болоод байна. Тухайлбал, Транспаренси Интернейшнл байгууллагын судалгаагаар хамгийн бага авлигатай улс орнуудын жагсаалтад 4 дүгээр байрт, мөн улс төр, эдийн засгийн эрсдлийн судалгаа хийгдэх болсоноос хойш Азийн орнуудын дунд 1 дүгээрт жагсаж байна. Бид авлигыг хянах гол бүтэц болох **4A**-ийн зарчмыг хэрэгжүүлсэн. Эдгээр нь үр нөлөөтэй Anti-Corruption agency буюу Авлигатай тэмцэх байгууллага, Acts буюу хууль тогтоомж, Adjudication буюу шүүн таслах үйл явц, Administration буюу захиргааны хяналт зохицуулалт юм.

## Авлигатай тэмцэх байгууллага

Бид үйл ажиллагаа нь огт үр дүнд хүрээгүй Авлигатай тэмцэх байгууллагын үнс нурам дундаас Авлигын хэргийг мөрдөн шалгах товчоог дахин байгуулсан. Зүгээр нэг байгууллагыг дахин байгуулаагүй. Сэтгэл зүйн давуу талуудыг ашиглан хүрээлэл болон төсөөлөл бий болгож мэргэжлийн нууцлаг байдлыг үүсгэсэн. Түүнчлэн хуулиудыг илүү чанд хатуу болгож, Авлигатай тэмцэх газрын даргын эрхийг Үндсэн хуулийн түвшинд хангаж өгсөн. Авлигыг мөрдөн шалгах газарт эрх мэдэл өгч, үйл ажиллагаагаа ямар нэг айдасгүй явуулах боломжийг хангасан. Ямар нэгэн саад тогтороос зайлсхийхийн тулд шууд Ерөнхий сайдын удирдлагад өгсөн. Энэ нь амжилтын гол үндэс байсан. “Том загас” барих хандлагыг хэрэгжүүлэх, Сайд нар болон тодорхой тооны өндөр албан тушаалын этгээдүүдтэй хамаарах үйл ажиллагааг явуулсан. Бурханыг ч гэсэн мөрдөн шалгах ёстой гэсэн зарчим хэрэгжсэн.

- Ажилтнууд Авлигын хэргийг мөрдөн шалгах байгууллагад үнэнч байж, түүний нэр хүндийг өндөрт өргөнө;
- Ажилтнууд өөрсдийн үйл хөдлөлийг бүрэн чигч шударга, хараат бус, зүй ёстойгоор авч явна;
- Ажилтнууд чиг үүргээ бусдаас айж эмээх, эсвэл бусдад найр тавихгүйгээр хэрэгжүүлнэ;
- Ажилтнууд авлигын хэргийг нягт нямбай, хурдан шуурхай шалгаж шийдвэрлэнэ;
- Өөрсдийн нь хараат бус байдалд нөлөөлж болзошгүй нөхцөлд авлигын хэргийг шалгахаас татгалзана;
- Ажилтан зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд албаны асуудлыг хэнтэй ч ярилцахгүй;
- Ажилтнууд ямар ч мэдээлэгчийн нэр, хаягийг ил болгохгүй;
- Ажилтнууд өөрсдийн албан тушаалыг өөрт ямар нэг давуу тал олоход ашиглахгүй;

Сингапурын Авлигын хэргийг мөрдөн шалгах  
товчооны ажилтны ёс зүйн дүрэм

Авлигаас урьдчилан сэргийлэх хуулийн дагуу Ерөнхийлөгч нь “Авлигын хэргийг мөрдөн шалгах товчооны даргыг томилно. Мөн тус газрын Дэд дарга болон шаардлагатай гэж үзвэл бусад удирдах ажилтнууд, мөрдөгч нарыг өөрөө томилж болно. Сингапур Улс төрийн албан хаагчийн 1-10 зэрэглэлтэй бөгөөд энэхүү ангиллын дагуу хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь боломж олгосон хамгаалалтыг Эрүүгийн хуулиар тогтоосон байдаг. Мөрдөн шалгах товчооны ажилтанд тусгайлан олгогдсон эрх дарх, хамгаалалт байхгүй боловч зэрэглэл 1-д хамаарах төрийн албан хаагчийн хувьд Эрүүгийн хуулийн 172-190-р зүйлд заасны дагуу дараах болон бусад эрхтэй байдаг. Үүнд:

- Эрх бүхий төрийн албан хаагчийн тушаал зааврыг дагахгүй байх, дуудахад нь очигоос татгалзах, зайлсхийх;
- Эрх бүхий этгээдэд баримт бичиг гарган өгөхгүй байх, мэдээлэл өгөхгүй байх;
- Тангараглах, баталгаа гаргах, баримт бичигт гарын үсэг зурахаас татгалзах;
- Эрх бүхий төрийн албан хаагч хууль ёсны дагуу эд хөрөнгө хураах, худалдан борлуулах үйл ажиллагааг saatuuлах;
- Төрийн албан хаагчийн чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг saatuuлах;
- Чиг үүргээ хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчид туслахаас татгалзах.

“Сингапур улсыг авлигаас ангид байлгахын тулд би боломжтой бүх зүйлийг хийх болно. Ямар ч хэлбэрийн авлигыг үл тэвчих ёстай гэдгийг хүн бүр заавал мэдэж байх ёстой. Бүх сайд нар, парламентын гишүүд, бүх төрийн албан хаагчид бусаддаа сайн үлгэр жишээ болоосой гэж би хүсч байна. Ардын үйл хэргийн намын гишүүд болон бүх сайд нар надад, харин Ерөнхий сайд Ерөнхийлөгчид гэр булийнхээ өмч хөрөнгийг мэдүүлдэг. Хэрэв эдгээр албан тушаалтнууд өмч хөрөнгөө хууль бусаар олж авсан гэх ямар нэг сэжиг таамаг байвал товчоо мөрдөн шалгах болно. Хэрэв өмч хөрөнгөө мэдүүлээгүй, эсвэл яаж олж авснаа тайлбарлаж чадахгүй бол авлигын хэрэгт хариуцлагад татах болно.” Ерөнхий сайд Го Чок Тонг, 1993 онд Парламентад хэлсэн үгнээс

Авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо нь тэргүүлэх зэрэглэлийн мөрдөн байцаах байгууллага байх, шуурхай, баталгаатай үйл ажиллагаар дамжуулан авлигатай тэмцэх зорилготой. Тус байгууллага үйл ажиллагааны үр дүнг байнга сайжруулах, тагнуулын үйл ажиллагааны үр дунд урьдчилан идэвхтэй үйл ажиллагаа явуулж байх, инновацийн үйл ажиллагаа болон хүний нөөцийн хөтөлбөрөөр дамжуулан туслалцаа дэмжлэг үзүүлэх, Авлигыг эрсдэл өндөртэй, ашиг хонжоо багатай зүйл болгох өргөн хүрээний З стратегийн зорилтод тэмүүлсэн. Тухайлбал 2002-2003 онд явуулсан судалгаагаар тус байгууллагыг оролцогчдын 48% нь чанд хатуу буюу хэт чанга, 9,5% боломжийн, 3% нь хэт сул гэж дүгнэж байв. Мөн 2002 онд явуулсан судалгаагаар олон нийтийн 69,9 хувь нь Авлигын хэргийг мөрдөн шалгах товчоог шударга, хараат бус байгууллага мөн гэж үзсэн бол 2001 онд албан хаагчдын дунд явуулсан судалгаагаар тэдний 83% нь хамт ажиллагсдаа шударга, хараат бус гэж үзсэн. Тус товчооны гомдлын үнэлгээний хороог товчооны дарга даргалдаг бөгөөд 7 хоног бүр хуралдаж, мэдээллийг цааш нь шалгах эсэхээ шийдвэрлэдэг. 2014 оны байдлаар нийт хүлээн авч буй мэдээллийн 50 орчим хувь нь нэр хаяггүй мэдээлэл ирсэн байна.

## Үр нөлөөтэй хууль тогтоомж

Үр нөлөөтэй хууль тогтоомж гэж авлигын гэмт үйлдлийг маш ойлгомжтой тодорхойлсон, болзошгүй гэмт хэргээс зайлсхийхэд нөлөө үзүүлэхүйц хэмжээний ял шийтгэл бүхий, мөрдөн шалгах, шийдвэрлэх ажиллагааг амар хялбар нөхцөл байдлыг бүрдүүлсэн байхыг ойлгоно. Энэ төрлийн гэмт хэрэг хоёр талын хүсэл зориг нийлдэг учраас зарим онцлог нөхцөл байдлыг заавал тооцох шаардлагатай:

- Аливаа шан харамж, давуу байдал олж авахыг авлигад тооцно;
- Гэм буруугүйгээ нотлох үүрэг авсан гэх талд илүү оногдоно;
- Шан харамж, давуу байдлыг олж авсан этгээд хариу давуу байдал олгох эрх мэдэлтэй, эсвэл боломжтой байсан эсэхээс хамаарч гэм буруутайд тооцогдоно;
- Өмч хөрөнгө нь орлоготойгоо нийцэхгүй бол үүнийг нэмэлт нотлох баримтад тооцно;
- Сэжигтэн этгээд, түүний гэр булийн гишүүдийн хөрөнгө орлого болон Сингапураас гадагш шилжүүлсэн хөрөнгө мөнгөний талаар мэдүүлэг өгөхийг прокурор ямар ч этгээдээс шаардах эрхтэй;
- Прокурор мөрдөн шалгагдаж буй этгээдийн орлогын талаарх мэдээллийг татварын байцаагчаас авах эрхтэй.

Ял шийтгэл нь урьдчилан сэргийлэх нөлөөтэй байх ёстой. Тухайлбал 100000 хүртэлх сингапур долларын тортгууль эсвэл 5 жил хүртэл хугацаагаар хорих ялыг оногдуулах. Гэмт хэрэгт Парламентын гишүүн эсвэл төрийн худалдан авалт, гэрээний асуудал хариуцсан албан хаагч холбогдсон бол хорих хугацааг 7 жил хүртэл нэмэгдүүлдэг.

## Үр дүнтэй шүүн таслах үйл ажиллагаа

Шүүн таслах үйл ажиллагаа үр дүнтэй байхын тулд шүүх бие даасан, хараат бус, ил тод, нээлттэй байх гэсэн үндсэн нөхцлийг хангасан байх учиртай. Өөрөөр хэлбэл чанд хатуу, таамаглах боломжтой, найдвартай тогтолцоо буюу “хууль ёс” оршиж байх ёстой. Үр дүнтэй шүүн таслах үйл ажиллагаа нь үр дүнтэй шүүхийн тогтолцоо болон ял шийтгэлийн системээс бүрдэнэ. Ялын бодлого нь шүүх хэрхэн үйл ажиллагаа явуулж, хэргүүдийг хэрхэн шүүн таслахыг тодорхойлно. Сингапурын ялын бодлогын үндэс нь урьдчилан сэргийлэх явдал бөгөөд олон нийтийн хэв журам, сахилга батыг хангахад голлон чиглэх ёстой. Эрүүгийн эрх зүйн тогтолцоо нь рецидив гэмт хэргийн эсрэг тэмцэх ёстой. Ялангуяа байнга өөрчлөгдж буй эрүүгийн гэмт хэргийн нөхцлөөс хамааран ял шийтгэлийн жишиг хязгаарыг байнга хянан үзэж, шинэчилж байх ёстой.

Сингапур улс 1992-1999 онд шүүх эрх мэдлийн өргөн хүрээний шинэтгэл хийж, 1000 гаруй санаачилгыг хэрэгжүүлсэн. Үүнд удаан хүлээгдсэн олон тооны

хэргүүдийг шөнийн шүүхээр түргэвчлэн шийдэх, шүүхийн худалдааны тоо болон бүтээмжийг нэмэгдүүлэх, шүүхэд хэрэг шийдэх дүрэм журмыг өөрчилж ажиллагааг түргэвчлэх, цахимжуулах зэрэг ажлууд хийгдсэн. Мөн шүүхийн 10 зарчмыг сайтар мөрдүүлж чадсан:

1. Шүүгчийг сонгон шалгаруулах, албан тушаал дэвшүүлэхэд ил тод, нээлттэй байдлыг хангах;
2. Хангалттай цалин хангамж өгөх;
3. Бие даасан боловч үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх чадвартай шүүх;
4. Хэрэг удирдах зохистой систем;
5. Ажлын гүйцэтгэлд тулгуурласан шүүгчийн онооны картыг нэвтрүүлэх;
6. Шүүхийн үйл ажиллагаанд тогтвортой бөгөөд объектив шалгууруудыг ашиглах;
7. Ёс зүйн маш тодорхой хэм хэмжээ, чиглэл удирдамжийг мөрдүүлэх;
8. Нийтлэг алсын хараа, манлайллыг жишиг болгох;
9. Шүүхийн үйл ажиллагааг бүх цагт ил тод байлгах;
10. Чадварлаг хөгжих байгаа бусад байгууллагаас суралцах;

### **Сингапур улсын шүүх болон шүүх засаглал**

Тус улсын Үндсэн хуулийн 93 дугаар зүйл нь Сингапур улсын шүүхийн дээд эрх мэдлийг Дээд шүүх болон анхан шатны шүүхүүдэд олгосон байдаг. Шүүх байгууллага нь Ерөнхийлөгчөөс томилсон Дээд шүүхийн дарга, давж заалдах шатны болон бусад шүүгчдээс бүрддэг. Шүүх нь гүйцэтгэх засаглал болон хууль тогтоох засаглалаас бүрэн утгаараа бие даасан, хараат бус байдаг бөгөөд үүнийг Үндсэн хуулиар баталгаажуулсан байдаг.

- Дээд шүүх нь давж заалдах болон High Court (Өндөр) шүүхээс бүрдэнэ. Энэ хоёр шүүхийн үйл ажиллагаа нь Дээд шүүхийн үйл ажиллагааны тухай хуулиар зохицуулагддаг. Давж заалдах шүүх. Давж заалдах шүүхэд Дээд шүүхийн дарга болон давж заалдах шатны шүүгчид хэрэг шийдвэрлэнэ. Өмнө нь Англи улсын шүүхэд давж заалддаг хуультай байсныг Шүүх засаглалын хорооноос 1994 онд өөрчилсөөр Дээд шүүх нь Сингапур улсын шүүхийн давж заалдах хамгийн эцсийн шат болсон. Давж заалдах шүүх нь High Court-оос шийдвэрлэсэн бүх төрлийн иргэний болон эрүүгийн хэргийн шийдвэр, тогтоолыг хүлээн авч хянан шийдвэрлэдэг. High Court (Өндөр шүүх). Дээд шүүхийн шүүгч болон шүүхийн бүрэн эрхт төлөөлөгч нар High Court (Өндөр шүүх)-д хэрэг хянан шийдвэрлэнэ. High Court (Өндөр шүүх) нь бүх төрлийн иргэний болон эрүүгийн хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэхээс гадна Subordinate буюу (Анхан шатны шүүх)-ийн шийдвэрлэсэн хэргүүдийг давж заалдах шатны журмаар хүлээн авч хянан шийдвэрлэдэг.

- Анхан шатны шүүх. Анхан шатны шүүх нь дүүргийн болон магистратын шүүхээс бүрдэх бөгөөд дүүргийн шүүгч болон магистратууд хэрэг шийдвэрлэнэ. Эдгээр шүүгчдийг Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн санал болгосноор Ерөнхийлөгч томилдог. Дүүргийн шүүхэд 10 хүртэл жилийн хорих ял оногдуулах гэмт хэрэг, 250,000 сингапур доллараас ихгүй нэхэмжлэлтэй иргэний хэргийг шийдвэрлэдэг. Харин магистратын шүүхэд 3 жил хүртэл хорих ял оногдуулах гэмт хэрэг, 60,000 доллараас ихгүй нэхэмжлэлтэй иргэний хэргийг шийдвэрлэнэ. Мөн тус шүүх нь High Court (Өндөр шүүх)-ээр шийдэгдэх зарим хэргийн урьдчилсан ажиллагааг гүйцэтгэдэг.
- Дээр дурдсанаас гадна гэр бүлийн, насанд хүрээгүйчүүдийн, коронерын гэх мэт тусгай шүүхүүд ажилладаг бөгөөд тэдгээр нь анхан шатны шүүхийн бүрэлдэхүүнд багтаж байдаг. Гэр бүлийн шүүх нь Гэр бүл салалт, хүүхэд үрчлэх, асран хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэл болон гэр бүлийн бусад маргааныг хүлээн авах бөгөөд энэ шүүхэд дүүргийн шүүгч ажиллана. Насанд хүрээгүйчүүдийн шүүхэд 16-аасдоо шансны хүүхдүүд, өсвөр насныхны үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэдэг. Коронерын шүүх нь гэнэтийн болон жам бус үхэл, хүчирхийлэл, гадны нөлөөтэй, эсхүл шалтгаан нөхцөл нь тодорхойгүй амь насаа алдсан хэргүүдийг хүлээн авна. Жижиг нэхэмжлэлийн шүүхэд худалдаа, үйлчилгээтэй холбоотой 20.000 хүртэл долларын нэхэмжлэлийг хүлээн авдаг. Тус шүүхэд Дээд шүүхийн ерөнхий шүүгчээс санал болгосны дагуу Ерөнхийлөгчөөс томилогдсон тусгай шүүгч хэрэг шийдвэрлэнэ.

### Үр дүнтэй захиргааны үйл ажиллагаа

Байгууллагын түвшинд авлига бий болох үндсэн шалтгаан бол эрх мэдлийн төвлөрөл буюу монополчлогдсон эрх мэдэл юм. Лорд Актоны хэлснээр “Эрх мэдэл авлигыг бий болгодог ба хэмжээгүй эрх мэдэл бол хэмжээгүй авлигын үндэс” гэжээ. Тиймээс аливаад үзэмжээр хандах нөхцөл бүрдүүлсэн, хэвийн хэмжээнээс хэтэрсэн эрх мэдэл нь өөрийн дураар асуудлыг шийдвэрлэх боломж олгодог учраас үүнээс байгууллага урьдчилан сэргийлэх шаардлагатай.

- Эрх мэдлээ урвуулан ашигласан, хууль бус үйлдэл, эс үйлдэлд ямар нэг хариуцлага хүлээлгэдэггүй байх нь авлига даамжрах шалтгаан болдог. Өөрөөр хэлбэл албан тушаалтны хүлээх үүрэг хариуцлага, ажлын байрны тодорхойлолт тодорхойгүй, удирдлагаас тавих хяналт сул, “хариуцлага, шийтгэлээс эмээх хүчин зүйл” дутмаг, баригдах магадлал бага байгаа үед л энэ нөхцөл байдал үүснэ.

Тиймээс байгууллагад авлигаас сэргийлэхийн тулд хэн, хэзээ, ямар хэмжээгээр, ямар хүрээнд эрх мэдэл хэрэгжүүлэхийг дүрэм, журмаар маш тодорхой болгох, практик болж тогтсон албан бус жишгийг өөрчлөн албажуулах шаардлагатай. Мөн цөөн тооны хүмүүсээс хэт хамааралтай байх нь эрх мэдэл төвлөрөх эхлэл болдог.

- Байгууллагын мэдээлэл хаалттай байх нь дур зоргоороо аашлах, зүй бус үйлдлийн халхавч болдог. Тиймээс өөрийн хувийн эрх ашигт нийцүүлэн мэдээллийг ашиглахаас сэргийлж мэдээллийн орц, гарц, хөдөлгөөнд хамтын хяналт тавих шаардлагатай.

Авлигыг анхан шатнаас нь бага жижиг гэлгүйгээр хянах хэрэгтэй. Тухайлбал, бэлэг авах, дайлуулах, үзвэр үйлчилгээнд уригдах, ажил хэргийн холбоотой хүнтэй ахан дүүсийн харьцаатай байх, санхүүгийн дэмжлэг авах, ажлаас гадуур нэмэлт орлого олох нөхцөл боломжуудыг байнга хязгаарлах ёстой. Харин үүнийг хэрэгжүүлэх механизм нь дотоод хяналтын систем буюу мониторинг, дотоод аудит юм.

### **Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа**

Сингапурт эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагааны болон нотолгооны журмыг тус улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Нотолгооны хуулиар зохицуулдаг. Авлигаас урьдчилан сэргийлэх хуулийн дагуу цагдан хорих шаардлагатай, эсвэл сэжигтэн этгээдийн талаар гомдол мэдүүлсэн, мэдээлэл хүлээн авсан, эсвэл гэмт хэрэгт холбогдсон байж болох хангалттай сэжиг бүхий тохиолдолд сэжигтэн этгээдийг зөвшөөрөлгүйгээр баривчилж болно. Мөн сэжигтэн этгээдийг баривчлахдаа үзлэг нэгжлэг хийж гэмт хэргийн нотолгоо байж болзошгүй гэж үзсэн эд зүйлсийг хураан авах эрхтэй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 36(2) дугаар зүйлд зааснаар цагдан хорих хугацаа нь 24 цаг байна.

Түүнчлэн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан гэрч байлцуулах, тухайн хэргийн талаар мэдэж буй этгээдийг асуух, өгсөн мэдүүлгийг бичгээр гаргуулан авах зэрэг эрхтэй. Өөрийн эсрэг мэдүүлэг өгөхөөс бусдаар ямар ч этгээд үнэн зөв мэдүүлэг өгөх ёстой.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 122 дугаар зүйлд зааснаар түрүүч болон түүнээс дээш албан тушаал бүхий мөрдөн байцаагч “урт мэдэгдэл” гэгддэг мэдэгдлийг сэжигтнээс гаргуулан авах эрхтэй байдаг. Тухайн мэдэгдэл нь гэрч болон сэжигтэн этгээдээс үнэн зөв мэдээлэл авах, мэдүүлгээс буцахаас сэргийлэх, мөн тухайн мэдүүлгийг айлган сүрдүүлэх эсвэл хууран мэхлэх замаар гаргуулж авсан эсэхийг шүүхэд тогтооход чухал ач холбогдолтой. Тус хуулийн 122(6)-д заасны дагуу сэжигтэн этгээдэд гэмт хэрэгт холбогдсон, түүнийг мөрдөн шалгаж буйг нь анх мэдэгдсэнээр “анхааруулах мэдэгдэл”-ийг гаргуулан авдаг. Тухайн нөхцөл байдалд мэдэж байсан, хэлэх ёстой байсан мэдээлэл, баримт фактыг анхааруулах мэдэгдлийн дагуу хэлэхгүй байх нь тухайн хэргийг шүүхээр шийдвэрлэх, гэм буруутай эсэхийг тогтооход сөрөг нөлөөг үзүүлдэг.

### АНХААРУУЛАХ МЭДЭГДЭЛ

“Та .....  
..... хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж/холбоотой

байгаа талаар мэдээлэл ирээд байна.

Дээрх хэрэгтэй холбоотойгоор таньд мэдэгдэх зүйл байна уу? Хэрэв шүүхэд таныг хамгаалах ямар нэг мэдээлэл, нотлох баримт байгаа бол энэ талаараа одоо хэлэхийг танд зөвлөж байна. Хэрэв та тухайн баримтыг шүүхэд мэдээлэхээр хадгалж байгаа бол тухайн үед уг баримтыг нотлох баримт гэж авч үзэхгүй байх магадлалтай. Хэрэв ямар нэг баримтыг мэдээлэхийг хүсэж буй бол бичгээр гаргаж өгнө үү.

Авлигаас урьдчилан сэргийлэх хуулийн 24(1) –д зааснаар шүүгч болон товчооны даргад нэгжлэг хийх зөвшөөрөл олгох эрх олгогдсон байдаг. Зүйл 24(2) нь товчооны түрүүчээс дээш цол бүхий ажилтнуудад нэгжлэг хийх зөвшөөрөл хүлээх хугацаанд тухайн объектод өөрчлөлт гарах магадлалтай тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр нэгжлэг хийх эрхийг олгосон байдаг. Дээрх хуулийн 26 дугаар зүйл нь нэгжлэг хийхэд саад учруулах тохиолдолд 10000 хүртэл долларын тorgууль ноогдуулах, нэг жил хүртэлх хугацаагаар хорих шийтгэлийг дангаар нь буюу хослуулан ноогдуулахаар заасан байдаг. Үүнд: Барилга, байшинд нэвтрүүлэхээс татгалзах, хүч хэрэглэн саад учруулах, бусад хэлбэрээр саатуулах, албан үүргээ биелүүлэх талаарх хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх, шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзах, үл тоомсорлох зэрэг багтана.

Хуулийн 18-р зүйлд зааснаар тухайн хэрэгт хамаарах мэдээлэл, баримтыг олж авахын тулд ямар ч этгээдийн банкны данс, хувьцааны данс, худалдан авалтын данс, зардлын данс болон бусад бүх төрлийн данс, банкин дахь хадгаламжийн хайрцаг зэргийг шалгах, нэгжих зөвшөөрлийг товчооны ажилтанд прокурор олгоно. Шаардсаны дагуу мэдээллийг гарган өгөөгүй этгээдэд 2000 хүртэл долларын тorgууль ноогдуулах, нэг жил хүртэлх хугацаагаар хорих шийтгэлийг дангаар нь буюу хослуулан ноогдуулахаар заасан байдаг.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт холбогдсон төрийн байгууллагын ажилтан, албан хаагчтай холбоотой ямар нэг мэдээлэл, нотолгоог тухайн этгээдийн гэр булийн гишүүд эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу байгууллагын банкны мэдээллээс олж авах боломжтой гэж үзвэл тэдгээрийн банкны дансыг шалгах, банкинд нэвтрэн орж баримтыг шалгах, хамаарах баримтыг хуулбарлан авах зөвшөөрлийг прокурор товчооны дарга болон мөрдөн шалгагчид олгоно.

Түүнчлэн хуулийн 21(1)-д зааснаар мөрдөн байцаалтын явцад дараах мэдээлэл өгөхийг прокурор шаардах эрхтэй:

- Тухайн этгээдээс эхнэр, хүүхдийн эзэмшилд буй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн жагсаалт болон тэдгээр хөрөнгийг анх хэрхэн худалдан авсан,

бэлгэнд авсан, өвлөн авсан эсвэл бусад ямар байдлаар олж авсан болохыг дурдсан мэдэгдэл гарган өгөх;

- Тодорхой хугацааны туршид тухайн этгээдээс болон түүний эхнэр, хүүхдээс Сингапураас гадагш гүйвуулсан, шилжүүлсэн мөнгө, хөрөнгийн талаар бичгээр мэдэгдэл гарган өгөх;
- Тухайн этгээд, түүний гэр бүл, хүүхдүүдтэй холбоо бүхий бүх мэдээлэл, болон тухайн баримтуудын баталгаажсан хуулбарыг татварын байцаагчаас гаргуулан авах;
- Бусад байгууллага, төрийн алба, түүний салбар эсвэл тэдгээрийн дарга, ерөнхийлөгч, захидал, менежер зэргээс тухайн этгээдэд хамаарах бүх мэдээлэл, баримтыг гарган өгөхийг шаардах.

**Шүүн таслах ажиллагааны журам** нь эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зохицуулагддаг. Ямар нэгэн гэмт хэргийг зохих шатны шүүхээр шийдвэрлэхийн өмнө урьдчилсан шүүх ажиллагаа явагдана. Урьдчилсан шүүх хуралдаанд холбогдгчийг баривчилж эсвэл зарлан дуудаж шүүхэд авчрах бөгөөд шүүх прокурорын яллах дүгнэлттэй танилцдаг. Хэрэв энэ үед мөрдөн байцаалт бүрэн хийгдсэн, яллах дүгнэлтийг хүлээн авсан бол шүүх холбогдогч этгээдээс гэм буруутай эсэхийг асууж шүүх ажиллагааг үргэлжлүүлнэ. Харин нэмэлт ажиллагаа шаардлагатай бол хэргийг мөрдөн байцаалтад буцааж, сэжигтнийг батлан даалтанд гаргаж болно.

Хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор шүүхийн өмнөх хурлыг (шүүхийн танхимд бус) явуулдаг мөрдөн байцаалтын явцын талаар мэдээлэл өгөх, зарим асуудлыг нарийвчлан баримт болон хуулийн хүрээнд судлах, шүүх хуралдааны товыг тогтоох, гэрчүүдийн нэrsийн жагсаалт солилцох, мэдүүлэг танилцуулах, дүгнэлт, баримт материал шүүхэд гаргаж өгөх боломж олгодог. 1990-ээд оноос шүүхийн өмнөх шатны хуралдааныг хийх болсон нь Сингапур улсад эрүүгийн хэргийн шүүх ажиллагааг хэрэгжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн. Энэ нь талууд асуудлыг илүү энгийн байдлаар ярилцаж, хэлэлцэх боломж олгосон учраас хэргийг хурдан шийдэж, хүлээгдэж буй хэргийн тоог ихээхэн бууруулсан. Мөн яллагч болон өмгөөлөгч тал шүүгчийн оролцоогүйгээр уулзаж (урьдчилсан хурлаас өмнө) зөрүүтэй асуудлыг нарийвчлах, ял шийтгэлийн хэмжээ, хэлбэр зэрэг дээр тохиолцох боломжийг Ерөнхий прокурорын газраас эрүүгийн хэргийн менежментийн шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлж эхэлсэн.

Сэжигтнийг цагдаагийн газарт, эсвэл шүүх дээр цагдан хорьж болно. Тухайн этгээд яллагдаагүй, мөн зөвшөөрөлгүйгээр баривчлагдсан тохиолдолд цагдаагийн газар цагдан хорино. Батлан даалтад байх хугацаандаа холбогдогч нь тодорхой гэрч, нотолгоо гарган ирвэл цагдан хорих тогтоолыг цуцалж болно.

**Ял шийтгэл.** Хуулиар тогтоосон ихэнх ялыг шийтгэх нь хорих, торгох болон саваадах ял байдаг. Ямар ч тохиолдолд 1 гэмт хэргийн төлөө ялын төрөл давхардуулахыг хориглоно. Зарим тохиолдолд тухайн ялыг эдэлсэний дараа

цагдаагийн хяналтад байх хугацааг тогтоож өгдөг. Үрьдчилан сэргийлэх цагдан хорих арга хэмжээг нэг талаар олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүднээс авдаг. Хүн амины болон мансууруулах бодис худалдаалах зэрэг ноцтой гэмт хэрэгт Сингапур улс цаазаар авах ял оноодог.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар шүүх өөрийн үзэмжээр гэмт хэргээс учирсан хохирлыг төлөх, хохиролгүй болгох шийдвэрийг гаргаж болно. Гэхдээ энэхүү нөхөн төлбөрийг шийтгэл гэж үзэх ёсгүй. Харин гэмт хэргээс учирсан хохирлыг барагдуулах нь түүнд хамаарах ял шийтгэлээс зайлсхийх үндэслэл болохгүй.

### **Авлигын ба мөнгө угаах гэмт хэрэг**

Авлига өгөх болон авах замаар олсон орлогыг хууль ёсны болгох зорилгоор “мөнгө угаах” гэмт хэрэг үйлдэгддэг. Хэлбэрийн хувьд байршуулах буюу хурамч бичиг баримт ашиглан мөнгийг гадаад (оффшор) болон дотоодын банкуудад байршуулах, далдлах буюу мөнгийг эх үүсвэрээс нь хол газар байршуулах, (ингэхдээ нууц данс phantom account, хууль ёсны бизнес эрхэлдэг боловч хууль бус мөнгийг дамжуулан байршуулдаг компаниудыг ашигладаг), нийлүүлэх буюу хууль ёсны бизнесээр дамжуулан зах зээлд байршуулах гэсэн төрөлтэй. Ингэхдээ санхүүгийн хурамч бичиг баримт, дутуу үнэлэх арга болон хурамч төлбөрүүдийг ашигладаг.

НҮБ-ын Авлигын эсрэг конвенц батлагдсанаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа хөгжих байна. Туршлагаас хараход энэ нь хөрөнгө хураах чиглэлээр үүсэх бүх асуудлыг шийдэх арга зам биш юм. Заримдаа албан бус сувгуудыг ашиглах нь дээр байдаг. Энэ зөвхөн мөрдөн байцаагчийн эрх үүрэг биш бөгөөд засгийн газар, бусад байгууллагууд идэвхтэй хамтрах ёстой гэдгийг мартаж болохгүй. Ихэнх тохиолдолд гадаад харилцааны яамдаар дамжсан засгийн газар хоорондын харилцаа байдаг. Энэ үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дараах алхам авч хэрэгжүүлэхийг зөвлөдөг:

- Шүүхийн байгууллагыг энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх чиглэлээр туршлагажуулах;
- Валют шилжүүлгийн тайлан, сэжигтэй санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл болон сэжигтэй шилжүүлгийн тайланг архивлах чиг үргийг санхүүгийн зохицуулах байгууллагад өгөх;
- Хувь хүний талаарх мэдээлэл (овог нэр гэх мэт), оршин суугаа хаяг болон бусад тодорхойлт, данс нээсэн этгээдийн талаарх мэдээлэл, шилжүүлгийг хийж буй жинхэнэ эзэн, ашиг хүртэж буй жинхэнэ эзэн гэх мэт мэдээллийг санхүүгийн тайлангуудад тусгадаг байх шаардлагыг хэрэгжүүлэх;
- Төв банк, цагдаа, авлигатай тэмцэх газар, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх газар, вальютын хороо, үнэт цаасны хороо, сангийн яам, татварын байгууллагын оролцоотой дагалдах бүтцийг бий болгох;

- Түүнчлэн санхүүгийн тагнуулын албыг зохицуулах хорооны дэргэд байгуулах нь үр дүнтэй. Уг алба нь бүх тагнуулын байгууллагатай адил мэдээлэлд дүн шинжилгээ хийж, вальют шилжүүлгийн тайлан, сэжигтэй шилжүүлгийн тайлан, мэдээлэгчийн зэрэг бусад эх сурвалжийн мэдээллийг цуглуулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хууль сахиулах байгууллагууд болон холбогдох агентлагуудад өгч нэмэлт нотлох баримт олж авах чиг үүрэг хэрэгжүүлдэг байх учиртай.

Сингапурын хувьд сүүдрийн эдийн засгаас орлого олсон банк, корпораци болон хувь хүмүүст хатуу чанд шийтгэл оногдуулах практик хэрэгжүүлдэг. Тухайлбал санхүүгийн байгууллагуудын хувьд мөнгө угаах гэмт хэргээс олсон ашгийг 10 дахин нэмэгдүүлэн торгох болон 1 сая ам.доллараар торгох, сэжиг бүхий шилжүүлгийг мэдээлээгүй хувь хүнийг дээд тал нь 20,000 ам.доллараар торгох зэрэг хариуцлага оногдуулдаг.

Энэ төрлийн гэмт хэрэг дээр мөрдөн шалгах ямар арга барил хэрэглэх вэ? гэдэг асуудал чухал. Мөнгө угаах гэмт хэрэг олон үе шаттай үйлдэгддэг тул “хальслах” арга барилыг хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл: “мөнгөний алхам бүрийг мөшгих” шаардлага тулгарна. Энэ явцад банк, санхүүгийн байгууллагууд дахь олон төрлийн данс, явуулсан болон хүлээн авсан мөнгөн гүйвуулга, алт, үнэт чулуу гэх мэт уламжлалт үнэт зүйлс, хувьцаа, үнэт цаас, клубийн гишүүнчлэл, тээврийн хэрэгсэл гэх мэттэй холбоотой их хэмжээний шалгах мэдээлэл гарч ирдэг.

Иймээс олон төрлийн мэдээлэл хөтлөх, баримтжуулах нь маш чухал ач холбогдолтой. Жишээ нь банкны бүх гүйлгээ компьютероор хийгддэг, компьютерын мэдээлэл нь арилашгүй нотолгоо болон үлддэг тул сайн нотолгоо болж чаддаг. Харин мөрдөн шалгах үйл ажиллагаа мухардалд орвол тагнуулын ажиллагаа хэрэглэж болно. Хэлбэрийн хувьд ил болон нууц мөрдлөгө байж болно. Тухайлбал хэрэгт холбогдогчдод мэдэгдэлгүйгээр түүний хамаарал бүхий хүмүүсийг албан ёсоор мэдэгдэж эсвэл мэдэгдэлгүйгээр шалгах, (ингэхдээ гүйцэтгэх ажиллагаа хэрэглэхгүй), эсвэл холбогдогчдод мэдэгдэх эсвэл мэдэгдэлгүйгээр гүйцэтгэх ажиллагаа хэрэглэн шалгах гэсэн хувилбарууд байж болдог.

Компьютер болон бусад төхөөрөмжийн санах ойд хадгалагдсан мэдээлэл нь шүүхийн өмнө нотлох баримт болох боломжтой бөгөөд хууль сахиулах байгууллага нь түүнийг устгаж болохгүй. Сүлжээний санах ой, зөөврийн компьютер, цахим шуудан, хувийн цахим төхөөрөмж, дундын хэрэглээний санах ой, ухаалаг гар утас зэрэг мэдээлэл олж болох эх сурвалж олон бий. Дансын аргаар үйлдэгдсэн авлигын гэмт хэрэг ч байсан гэсэн “хэргийн газарт байнга очиж бай” гэдэг дүрэм мөрдөгддөг.

## Улсын Дээд шүүхийн шүүгч Б.Бат-Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Сингапур Улсад хамрагдсан сургалт

2011 оны 6 сарын 26-наас 7 сарын 3-ны өдрүүд

Сургалтад оролцогчид:

Б.Бат-Эрдэнэ, Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч

Д.Дамдин-Од, Нийслэлийн шүүхийн шүүгч

Х.Батбаяр, Баянгол дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч

Д.Цогтсайхан, Чингэлтэй дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч

С.Соёмбо-Эрдэнэ, Сүхбаатар дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч

Б.Баатар, Баянзүрх дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч

Ё.Цогтзандан, Хан-Уул дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч

Ж.Эрдэнэчимэг, Сонгино-Хайрхан дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч

Б.Энхжин, Азийн сангийн Засаглалын хөтөлбөрийн менежер

А.Баянмөнх, Азийн сангийн Засаглалын хөтөлбөрийн ахлах ажилтан

ИН.МН  
СУДАЛГААНЫ САН

## Сургалт болон танилцах уулзалтын тэмдэглэлээс:

- Сингапурын авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо нь 82 албан хаагч, түүнээс 57 мөрдөн байцаагчтай. Сингапурын туршлагаас харахад том бүтэц, их төсөвтэй байх нь амжилтын гол үндэс биш. Жишээ нь төсвөөр нь харьцуулахад: Хонг-Конг төсвийнхөө 0.40%, Макао 0.45%, Австрали 0.06%, Сингапур хамгийн бага буюу 0.03% хувийг зарцуулдаг байна.
- Аливаа улс орны авлигын эсрэг ажлын үр дүнг З үндсэн үзүүлэлтээр харуулдаг.
  - о Хэргийг мөрдөн шалгахаас эхлэн шийдэх хүртэл хэр хурдан шийдвэрлэж байна. (Сингапурын мөрдөн шалгах товчоо хэргийг дунджаар 1 сар орчмын хугацаанд мөрдөн шалгаж дуусдаг.)
  - о Хэдэн хэргийг шийдвэрлэсэн
  - о Хэр үр дүнтэй, чанартай шийдвэрлэсэн
- Сингапур /түүнчлэн Хонг-Конг-д/ авлигын хэргийн мэдээллийг нэр хаяггүйгээр хүлээн авдаг. Нийт хүлээн авдаг гомдол мэдээллийн 80 орчим хувь нь нэр хаяггүй мэдээлэл байдаг. Энэ нь иргэдээс дэлгэрэнгүй, маш тодорхой мэдээлэл өгөх боломжийг бий болгодог бөгөөд авлигын товчоо нь асуудлыг нууц байдлаар лавшуулан сайтар шалгаж тогтоодог байна.
- Сингапурын шүүх тогтолцоонд хэрэгждэг нэг онцлог зарчим бол авлигын хэрэгт холбогдсон албан тушаалтаны гэм буруутайг прокурор нотлох биш харин гэм буруутан өөрийн гэм буруугүйг нотлох үүрэгтэй байдаг. Тийм ч учраас гэм буруутайд тооцогдсон эсэхээс үл хамааран эх үүсвэрийг нь тайлбарлаж чадахгүй байгаа эд хөрөнгийг шууд улсын орлого болгох зохицуулалт үйлчилдэг.
- Сингапурт байгууллага, агентлагын түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх маш тодорхой менежментын болон дүрэм журмын шинжтэй механизмыг бий болгож хэрэгжүүлж чадсан.
- Тухайлбал, Авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо нь эрүүгийн хэрэг болгож чадахгүй, нотлох баримт хангалтгүй хэргээ орхидоггүй. Захиргааны хариуцлагын арга хэмжээ авахуулахаар цааш нь ажиллагаа хийдэг нь их үр дүн өгдөг. Жишээ нь холбогдох журмын дагуу сингапурын цагдаагийн албан хаагч нь албаны харилцаатай, эсвэл хэргийг нь шалгаж байгаа этгээд, буюу түүнтэй хамаарал бүхий этгээдтэй олон нийтийн газар, энгийн байдлаар уулзахыг хориглосон байдаг. Хэрэв цагдаагийн албан хаагч сэжигтэнтэй уулзаж байгаа /жишээ нь цуг хоолонд орж байгаа нь фото зургаар/ нотлогдож байвал түүнийг журам зөрчсөн үндэслэлээр захиргааны арга хэмжээ авахуулах хүсэлт удирдлагад нь хүргүүлж, шийдвэрлүүлдэг байна.
- Түүнчлэн цагдаагийн албан хаагч өдрийн ажлынхаа бүрэн тэмдэглэл хөтөлх үүрэг хүлээдэг. Хэрэв ажилтан авлигын хэрэгт холбогдоод гэм буруутай үйлдэл хийгээгүй гэдгээ тэмдэглэлийн дэвтррийн мэдээллээрээ нотолж чадахгүй бол буруутайд тооцож захиргааны арга хэмжээ авах үндэслэл болдог.
- Сингапур улс нотолгооны бие даасан хуультай. Мэдүүлгийн бодитой байдлыг хангахын тулд өмнө нь хэлсэн зүйлээсээ буцах, мэдэж байснаа хэлээгүй бол тэр шинэ мэдүүлгийг нь дараа нь шүүхэд хүлээж авахгүй гэдэг анхааруулгыг Анхааруулах хуудсаар өгч, гарын үсэг зуруулж авдаг. Энэ нь

мэдүүлгээс буцах гэх мэт асуудлыг гаргадаггүй.

- Гадаадад байршсан авлигын орлогыг буцаан авах талаар Сингапур сайн ажилладаг.
- Түүнчлэн мөрдөн байцаалтын өмнө болон хойно сэжигтэн, яллагдагчид эрүүл мэндийн үзлэг хийгддэг.

### **Сингапурын сургамж**

- Сайн, цэвэр засаглал болон системийг эхнээс нь бий болгох нь авлигад автаж, эмх замбараагүй болсон орчныг цэвэрлэснээс хавьгүй илүү үр дүнтэй. Авлигатай тэмцэх байгууллага нь Засгийн газар биднийг ямар байгаасай хэмээн хүсэж буйн адил л үр дүнтэй байх болно.
- Улстөрийн хүсэл зориг нь авлигатай тэмцэх үйл ажиллагааны гол үндэс суурь, үр дүнд хүргэх үндсэн хөдөлгөгч хүч байдаг. Авлигын эсрэг хөдөлгөөнийг үр дүнтэй, тогтвортой байлгахад түлхэц болдог.
- Улс төрийн хүсэл зоригийг компаниудын хүсэл зориг мөн дэмжих хэрэгтэй бөгөөд үүн дээр нэмэгдээд Авлигатай тэмцэх байгууллагын эрс шийдэмгийг үйл ажиллагаа мөн дэмжлэг болж өгдөг.
- Төрийн манлайлал бүхий авлигын эсрэг санаачилга нь хүчирхэг манлайлалтай тохиолдолд илүү үр дүнд хүрдэг.
- Соёл болон уламжлалын шалтгаантай авлигын асуудлыг засах боломжгүй, даван туулахад төвөгтэй мэтээр ойлгох нь буруу.
- Улс төрийн манлайллагч нар болон төрийн бусад аппаратын идэвхтэй үүрэг роль нь хараат бус бие даасан байгууллагыг бий болгоход ихээхэн үүрэгтэйн зэрэгцээ хараат бус байгууллага гэж юу болохыг тодорхойлохыг шаарддаг. Гэхдээ хязгааргүй хараат байдал гэж үгүй.
- Зөвхөн бүтэц тогтолцоо, үйл явц амжилтын үндэс болж чадахгүй;
  - Гол нь зорилгodoо нийцэж байх;
  - Үйл ажиллагаа явуулах зөв орчин бүрдэх;
  - Бодит үр дүн, чанартай хэрэгжүүлэх нь чухал.
- Тогтолцоог засварлахын зэрэгцээ зүрх сэтгэл, сэтгэл зүй, хандлагыг засварлах шаардлагатай.
- Энгийн, гоёл чимэглэлгүй, үндсэндээ хэрэгжилтэд суурилсан хандлагыг бид ашигласан.
- Энгийн хялбар байж, бүрэн гүйцэд, чанартай гүйцэтгэ.
- Тодорхой зорилгodoо төвлөрч, нэгдмэл зорилготой байснаар үйл ажиллагаа амжилтанд хүрнэ.
- Амжилт нь амжилтыг бий болгодог бөгөөд нэг амжилт дараагийн амжилтын суурь болдог.
- Олон нийтийн дэмжлэг ихээхэн чухал бөгөөд авлигын эсрэг идэвхтэй үйл ажиллагаа энэхүү дэмжлэгийг бий болгоно. Үүний тулд:
  - Арьс өнгө, шашин болон амьжиргааны түвшнээс үл хамааран
  - Шударга, нягт байдлаар ямар нэгэн айдасгүй гүйцэтгэх нь чухал
- Тогтвортой үргэлжлэх алхамууд л авлигыг хянах боломжийг хангадаг.
- Сингапурын авлигатай тэмцэх санаачлагын гарал үсэл нь үндэсний хэмжээний хүсэл зоригын илэрхийлэл бөгөөд үйл ажиллагаанд тулгуурласнаараа ялгардаг.

## **БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛСАД ХИЙСЭН АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА СЭДЭВТ СУРГАЛТЫН ТАЙЛАН**

2011.9.13

Монгол Улсын Дээд шүүхийн шүүгч Б.Бат-Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчид 2011 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөс 7 дугаар сарын 2-ны өдрүүдэд Сингапур Улсын Төрийн албаны коллежид авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх, үр дүнтэй шийдвэрлэх чиглэлээр сургалтад хамрагдаж, Сингапурын Дээд шүүх, Прокурорын газар, Авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо зэрэг байгууллагуудад зочиллоо. Сургалтад хамрагдсаны дагуу Сингапур улсын амжилтын үндэс болсон үйл ажиллагаа болон Монгол Улсад хэрэгжүүлэх зүйлийн санал, зөвлөмжийг дараахь байдлаар танилцуулж байна.

### **Нэг. Сингапурын туршлага, амжилтын үндэс**

Сингапур улс нь 1965 оны 8 дугаар сарын 09-ний өдөр тусгаар тогтносон бөгөөд тухайн үед авлигад ихээхэн автагдсан орон байжээ. Харин өнөөдрийн байдлаар Сингапур улс нь олон улсын Транспаренси Интернейшнл байгууллагын дүгнэлтээр дэлхийд хамгийн бага авлигатай орнуудын жагсаалтын 4 дүгээрт, Улс төр, эдийн засгийн эрсдлийн судалгаа хийгдэх болсноос хойш Азийн орнуудын дунд 1 дүгээрт бичигдэх амжилтанд хүрсэн байна.

Дээрх амжилтад:

- Сингапур улсыг энэхүү амжилтад хүрэхэд ямар “ид шид” нөлөөлсөн бэ?
- Үйл ажиллагаа, систем болон үйл явц нь хавьгүй сайн байсан уу?
- Хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлсэний үр дүн үү?
- Бодлого нь хэрэгжих боломжтой байсных уу эсвэл зөв бодлого гарган хэрэгжүүлснийх үү?
- Үйл ажиллагааны хувьд ноу-хау сайтай учраас ийм амжилтад хүрч байна уу?
- Үйл ажиллагааны орчноос шалгаалсан уу ?
- Дэлхий дээрх хамгийн авлига багатай 4 дэх, Ази тив дэх 1 дэх улс болохын тулд ямар зам туулсан бэ?
- Амжилтад хүргэсэн хамгийн том хүчин зүйл, дархлаа нь юу байсан бэ?
- Сингапур улсын туршлага дээр сууринсан загвар бусад оронд ямар хэмжээнд хэрэгжих боломжтой вэ? гэсэн асуултууд гарч ирдэг.

Сингапур улсын амжилтын үндэс нь улс төрийн хүсэл зоригтойгоор засаглалын дараах 4 зарчмыг баримтлан, авлигыг хянах үйл ажиллагааг үр дүнтэй, тууштай хэрэгжүүлсэн явдал юм:

- a/ манлайлал бол түлхүүр;
- b/ өөрчлөлтийг мэдэрч цаг үетэйгээ хөл нийлүүлэх;
- c/ ажлыг урамшуул, урамшууллын төлөө ажиллах;
- d/ хүн бүрт хувь хүртээ, бүгдэд боломж олго.

Авлигатай тэмцэх ажлын 4 үндсэн тулгуур байдаг. Эдгээр нь:

- ANTI CORRUPTION AGENCY – Үр дүнтэй Авлигатай тэмцэх байгууллага
- ADJUDICATION – Үр дүнтэй шүүн таслах үйл явц
- ADMINISTRATION - Үр дүнтэй захиргаа
- ACTS – Үр дүнтэй хууль тогтоомж

**ANTI CORRUPTION AGENCY** (hatchet man which takes action) Шуурхай, эргэлзээгүй ажиллагааг эрхэмлэсэн Сингапурын авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо нь тус улсын Ерөнхий сайдын удирдлагад байдаг бөгөөд нийт 82 албан хаагч, түүнээс 57 мөрдөн байцаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Сингапурын туршлагаас харахад том бүтэц, их төсөвтэй байх нь амжилтын гол үндэс биш. Жишээ нь төсвөөр нь харьцуулахад: Хонг-Конг төсвийнхөө 0.40%, Макао 0.45%, Австрали 0.06%, Сингапур хамгийн бага буюу 0.03% хувийг зарцуулдаг байна. 100,000 хүнд ноогдох албан хаагчийн тоог харьцуулахад /1999-2004 оны байдлаар/: Сингапур – 1,97, Хонг-Конг – 19,80, Австрали – 1,88, Макао – 17,62 хувьтай байна.

Сингапур улс үйл ажиллагаа нь огт үр дунд хүрээгүй Авлигатай тэмцэх газрын үнсэн дээр дахин Авлигыг мөрдөн шалгах товчоог байгуулсан. Ингэхдээ зүгээр нэг байгууллагыг дахин байгуулаагүй ба нөхцөл байдлыг авч үзэн, байр суурийг нь дараах байдлаар тогтоосон:

- Авлигын хэргийг мөрдөн шалгах товчооны захирлын эрхийг Үндсэн хуулийн төвшинд хангаж өгсөн;
  - Авлигын хэргийг мөрдөн шалгах товчоонд эрх мэдэл өгч, үйл ажиллагаагаа ямар нэгэн айдасгүй явуулах боломжийг хангасан;
  - Ямар нэгэн саад тогтороос зайлсхийхийн тулд шууд Ерөнхий сайдын удирдлагад хамруулсан. /Энэ нь авлигын хэргийг мөрдөн шалгах товчоог оролдоно гэдэг нь “ЭЗНИЙГ” нь оролдож байна гэсэн үг. Нэгэн жишээ дурьдахад Сингапурын томоохон сайд авлигын хэрэгт холбогдоноыхоо дараа тэрээр Ерөнхий сайдтай уулзах хүсэлт гаргахад Ерөнхий сайд шүүхийн шийдвэр гарсны дараа уулзая гэсэн хариуг өгсөн байдаг. Харин уг сайд хэрэг хянан шийдвэрлэхээс өмнө өөрийн амия егүүтгэсэн.
  - Ёс зүйн хувьд тус байгууллагыг дэмжиж өгснөөр үйл ажиллагаа явуулах орчныг бүрдүүлж өгсөн. /Энэ нь амжилтын гол үндэс/;
  - Хуулийг илүү чангатгаж өгсөн;
- Түүнчлэн авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо нь улс төрчид, сайд болон өндөр албан тушаалын этгээдүүд холбогдсон нэргүй мэдээлэл ирсэн тохиолдолд заавал шалгадаг;
- “Бурханыг ч гэсэн мөрдөн шалга” гэдэг зарчим үйлчилдэг;
  - Шударга хүн шударга баталгааны кейс гэсэн зарчмыг хэрэгжүүлдэг.

**ACTS** Үр дүнтэй хууль тогтоомжийг боловсруулан парламентаар батлуулсан. Ингэхдээ хууль тогтоомждоо Авлига гэж юуг ойлгох вэ? гэдгийг өргөн хүрээнд маш ойлгомжтой тодорхойлж, гаргасан хууль тогтоомжийг амьдралд шударгаар яштал хэрэгжүүлж, хээл хахуультай холбоотой хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааг хөнгөвчилсөнөөр хэрэгжилтийг хялбаршуулах, хууль тогтоомжийн цоорхойг арилгах, шинэчилж байхын тулд байнга эргэн авч үздэг болсон.

Сингапур улс нь Үндсэн хууль, Авлигаас урьдчилан сэргийлэх хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Нотолгооны тухай хууль, Эд хөрөнгө хураах зэрэг хуулиудын хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг байна.

Сингапур улсын Эрүүгийн хуульд тухайн этгээдэд давуу тал боломж олгох эрх бүхий этгээд биш байсан ч гэсэн хүлээн авсан л бол, эд хөрөнгө нь орлоготойгоо нийцэхгүй хэмжээнд буй бол эдгээрийг авлига хэмээн үзэж гэм буруутайд тооцдог. Мөн төрийн албан хаагчийг мөрдөн шалгахад туслалцаа үзүүлэх хэн бүхэнд түүний өөрийн, гэр бүл болон хүүхдүүдийн хөрөнгө орлого, Сингапураас гадагш шилжүүлсэн хөрөнгийн талаар мэдүүлэг өгөхийг прокурорын зүгээс шаардах, прокурор мөрдөн шалгаж буй хэн бүхний талаарх мэдээллийг татварын байцаагчаас авах эрхтэй, мөрдөн шалгагдаж буй хэн бүхэн заавал мэдүүлэг өгч байхаар хуульд заасан.

Авлигын гэмт хэргийн субъектыг өргөн хүрээнд авч үздэг. Жишээ нь Сингапурын шуудангийн нэгэн компанийн шуудан зөөгч зарим үйлчлүүлэгчээс мөнгө авсан нь тогтоогдсон учир авлига авсан гэм буруутайд тооцсон байна. Учир нь уг шуудан зөөгч хүн бүрт тэгш үйлчлэх ёстой байтал мөнгө авснаараа бусдад давуу тал олгож байна хэмээн үзсэн.

Ял шийтгэлийн хувьд:

- 100.000 хүртэлх долларын торгууль эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих ялыг дангаар болон хослуулан ногдуулах;
- Тухайн хэрэг нь Засгийн газрын гэрээ болон парламентын гишүүн хамаарлтай бол хорих хугацааг 7 жил хүртэл нэмэгдүүлж болно;
- Авсан хахуулийн хэмжээтэй ижил тэнцүү мөнгийг гаргуулж улсын орлого болгодог.

Сүүлийн үед Сингапур улс гадаад улсад байршуулсан авлигыг улсын орлого болгох тал дээр түлхүү ажиллаж байгаа бөгөөд энэ талаархи хууль тогтоомжийг боловсронгуй болгох, олон улстай хамтран ажиллах гэрээ байгуулахад анхаарч ажиллаж байгаа болно.

Сингапурын хууль тогтоомжийг <http://statutes.agc.gov.sg/> хаягаар олж авч болно.

**ADMINISTRATION** буюу Үр дүнтэй удирдлага, захиргааны үйл ажиллагаа буюу сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлсэн. Энэ зарчмыг хэрэгжүүлэхэд улс төрийн хүсэл эрмэлзэл их ач холбогдолтой байдаг. Сингапур улсын засгийн эрх барьж буй намын хувьд цэвэр, хээл хахуулиас ангид байх нь тэдний удирдах зургаан зарчмын нэг болдог.

Эдгээр улс төрийн хүсэл зориг, тодорхойлолт болон удирдах зарчмууд нь:

- Авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар улс орны тэргүүлэгч нар /үүсгэн байгуулагч эцэг болсон хүмүүс/ нь сайтар ойлголттой байх;
- Бусдын төлөө, үндсэрхэг болон прагматик байх;
- Хувия хичээсэн бус байх.

Засгийн газрын гол баримтлах зарчмууд:

- Авлигыг хянах нь тухайн улсын үндэсний хөгжилд чухал ач хобгдолтойг ухамсарлах;
- Төрийн санаачилгаар, төр засгийн бүх түвшинд хэрэгжүүлэх;
- Сайд нар болон тодорхой тооны өндөр албан тушаалтнуудад хамаарах тодорхой үйл ажиллагааг явуулах;
- Авлигатай тэмцэхэд дээрээс доош чиглэсэн байх нь амжилтад хүрэх илүү боломжтой.

**ADJUDICATION** буюу Үр дүнтэй шүүн таслах, шийдвэрлэх ажиллагаа

Үр дүнтэй шүүн таслах ажиллагааны хамгийн гол асуудал томилгооны асуудал гэж үздэг. Сингапур улс шүүгчийг засгийн газраас өргөн мэдүүлснээр Ерөнхийлөгч бүх насаар нь томилдог байна. Шүүхийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг засгийн газраас шаардлагатай хэмжээгээр нь баталж өгдөг.

Сингапур улсын анхан шатны шүүх 79 шүүгчтэй ба жилд 400,000 хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг. Үүнээс 150,000 нь эвийн шүүхээр шийдвэрлэгддэг байна. Шүүх нь дотроо иргэн, эрүү, гэр бүл, хөдөлмөр, эвийн шүүх, татварын, гэх мэт мэргэшсэн шүүгч нарын баг ажилладаг. Талууд эвлэрээгүй нөхцөлд өргөдөл гомдол, нэхэмжлэлийг эвийн шүүх болон бусад харьяа шүүхэд шилжүүлдэг.

Сингапур улс шүүхийн үйл ажиллагаа тасралтгүй байх боломжийг хангах үүднээс шөнийн шүүхийг ажлуулж байна.

1990 оноос эхлээд шүүхийн өмнөх шатны хуралдааныг хийх болсон нь Сингапур улсад эрүүгийн хуулийг хэрэгжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн бөгөөд талуудын хоорондын шууд хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг бий болгосноор шүүхээр шийдэх хэргийн тоог бууруулсан байна. Мөн шүүхийн хувьд цаг, хөрөнгө хэмнэх боломж олгосон гэж үздэг байна. Энэ системийн хүрээнд прокурорын хяналт болон хамгаалалт нь тухайн хэрэг дээрээ төвлөрөн хэргийг нарийвчлан авч үзэж, шүүх хуралдаанаас өмнө хэргийг хүлээн зөвшөөрүүлэх явдал ихэссэн байна. Хэргийг

шүүх хуралдаанаас өмнө талуудын эрх ашигт нийцүүлэн шийдэж байгаа тул шүүх хуралдааны тоо буурсан байна.

Сингапурын шүүх тогтолцоонд хэрэгждэг нэг онцлог зарчим бол авлигын хэрэгт холбогдсон албан тушаалтны гэм буруутайг прокурор нотлох биш харин гэм буруутан өөрийн гэм буруугүй нотлох үүрэгтэй байдаг. Тийм ч учраас гэм буруутайд тооцогдсон эсэхээс үл хамааран эх үүсвэрийг нь тайлбарлаж чадахгүй байгаа эд хөрөнгийг шууд улсын орлого болгох зохицуулалт үйлчилдэг. Сингапур улсын шүүхэд гэм буруугаа хүлээвэл шууд ял шийтгэл оноодог. Гэм буруугүй гэдгээ нотлоно гэвэл шүүх хуралдаан болох өдрөө товлодог. Сингапур улсын шүүх ариун гурвал буюу үр дүнтэй хууль, үр дүнтэй хэрэгжилт, үр дүнтэй шүүн таслах үйл ажиллагаа гэсэн зарчмыг баримталж үйл ажиллагаа явуулж байна. Үр дүнтэй шүүн таслах үйл ажиллагаа нь үр дүнтэй шүүхийн систем, үр дүнтэй ял шийтгэлийн системээс бүрдэнэ.

Сингапурт байгууллага, агентлагын түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх маш тодорхой менежментын болон дүрэм журмын шинжтэй механизмыг бий болгож хэрэгжүүлж чадсан. Тухайлбал, Авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо нь эрүүгийн хэрэг болгож чадахгүй, нотлох баримт хангалтгүй хэргээ орхидоггүй. Захиргааны хариуцлагын арга хэмжээ авахуулахаар цааш нь ажиллагаа хийдэг нь их үр дүн өгсөн. Жишээ нь холбогдох журмын дагуу Сингапурын цагдаагийн албан хаагч нь албаны харилцаатай, эсвэл хэргийг нь шалгаж байгаа этгээд, буюу түүнтэй хамаарал бүхий этгээдтэй олон нийтийн газар, энгийн байдлаар уулзахыг хориглосон байдаг. Хэрэв цагдаагийн албан хаагч сэжигтэнтэй уулзаж байгаа, /жишээ нь цуг хоолонд орж байгаа нь фото зургаар баримтжсан/ нотлогдож байвал түүнийг журам зөрчсөн хэмээн захиргааны арга хэмжээ авахуулах хүсэлт удирдлагад нь хүргүүлж, шийдвэрлүүлдэг байна.

Түүнчлэн цагдаагийн албан хаагч өдрийн ажлынхаа талаар бүрэн тэмдэглэл хөтлөх үүрэг хүлээдэг. Хэрэв ажилтан авлигын хэрэгт холбогдоод гэм буруутай үйлдэл хийгээгүйгээ тэмдэглэлийн дэвтрийн мэдээллээрээ нотолж чадахгүй бол буруутайд тооцож захиргааны арга хэмжээ авах үндэслэлтэй болдог.

Сингапур улс нотолгооны бие даасан хуультай. Мэдүүлгийн бодитой байдлыг хангахын тулд өмнө нь хэлсэн зүйлээсээ буцах, мэдэж байснаа хэлээгүй бол тэр шинэ мэдүүлгийг нь дараа нь шүүхэд хүлээж авахгүй гэдэг анхааруултыг Анхааруулах хуудасаар өгч, гарын үсэг зуруулж авдаг. Энэ нь мэдүүлгээс буцах гэх мэт асуудлыг гаргадаггүй давуу талтай байдаг.

## **Хоёр. Санал, зөвлөмж**

Сургалтад оролцогчдоос дараах зүйлийг Монгол Улсад авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгож байна. Үүнд:

1. Шүүхээс шийдсэн авлигын хэрэг маргааны талаар олон нийтэд болон шаардлагатай бол тухайн салбарын буюу хариуцсан байгууллага, түүний удирдлагад зориуд мэдээлж, хүргүүлдэг байх;
2. Авлигын эсрэг конвенцид Монгол улс нэгэнт нэгдсэн учраас конвенцийг шууд хэрэглэх боломжийг судлаж хэрэгжүүлэх. Ингэснээр хууль тогтоогчид

- яваандаа үндэсний хууль тогтоомжийг конвенцид нийцүүлэх шаардлагатай болно;
3. Авлигын хэргийн мэдээллийг нэр хаяггүйгээр хүлээн авдаг эрх зүйн орчныг бий болгох;
  4. Томоохон албан тушаалтны буюу том хэргийг шийдвэрлэх тактикийг боловсруулж хэрэгжүүлэх;
  5. Авлига, албан тушаалын гэмт хэргийг зөвхөн нэг байгууллага шалгаж, шийдвэрлэдэг байх хэрэгтэй байна. Манай улсад Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба гэх мэт тусдаа бүтэц байх шаардлагагүй;
  6. Хуулинд төсвийн тодорхой хувийг авлигын эсрэг үйл ажиллагаанд зарцуулдаг байхаар хуулинд өөрчлөлт оруулах;
  7. Эрүүгийн хуулинд өөрчлөлт оруулж, шан харамжийг авлигын гэмт хэрэг гэж үзэж хуульчлах;
  8. Авлигатай тэмцэх газар тодорхой нэг албан тушаалтныг шалгах шийдвэр гаргаж, албан бичиг явуулахдаа хувийг нь ерөнхий сайд эсвэл харьяалах сайдад нь илгээдэг байх. Энэ нь тухайн салбарыг хариуцсан удирдах албан тушаалтанд мэдээлэл өгөхөөс гадна тэдний хариуцлагыг нэмэгдүүлэх, бусад доод албан тушаалтнууд хариуцлагаас зайлсхийх боломжийг бууруулах үр нөлөөтэй байна;
  9. Сингапурын төрийн ямар ч албан тушаалтанд халдашгүй байдал гэж байдаггүй. Халдашгүй байдал гэдэг нь албан тушаалтан гэмт хэргээс зайлсхийх халхавч болж байгаа тул энэ байдлыг өөрчлөх хууль тогтоомжийг шийдвэрлэх нь зүйтэй. Халдашгүй байдлын тухай асуулт төлөөлөгчид асуухад Сингапурын шүүгч, прокурорууд огт ойлгохгүй байсныг дурдах нь зүйтэй;
  10. Авлигын гэмт хэргийн субъектийг тодорхой болгох шаардлагатай. Албан тушаалын гэмт хэргийн субъектийг өргөн утгаар нь томьёолж оруулах. Өнөөгийн хуулиар субъектэд УИХ-ын гишүүд хамаардаггүй. Авлигын үйлдлийг бүх мэргэжил, салбар хамаарах байдаар томьёолох;
  11. Авлига, албан тушаалын гэмт хэргийн ялын бодлого чанга байх нь зүйтэй (Сингапурын туршлагаас харахад асуудлын амин сүнс нь ялын бодлого байдаг);
  12. Гадаадад байршсан авлигаас олсон хууль бус орлогыг буцаан авах талаар холбогдох судалгаа хийж арга хэмжээ авах;
  13. Авлигаас сэргийлэх захиргааны журам зөрчсөн албан хаагчийн асуудлыг захиргааны журмаар хянан шийдвэрлүүлэх эрх зүйн боломжийг бий болгох. Манайд эрүүгийн хариуцлагаас мултарсан бол өөр хариуцлага хүлээлгэх зохицуулалт байдаггүй. Тиймээс энэ тогтолцоог бий болгох;
  14. Шүүхийн байгууллагад авлига байгаа талаар хардлага сэрглэг байдаг. Үүнийг багасгах, шүүхийн нэр хүндийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
  15. Шүүхийн үйл ажиллагаа тасралтгүй байх боломжийг хангах үүднээс шөнийн шүүхийг ажиллуулах;

16. Эвлэрүүлэн зуучлах албыг бүх шүүхэд бий болгох;
17. Мэдүүлэгтэй холбоотойгоор анхааруулах хуудас болон мөрдөн байцаалтын өмнө болон хойно эрүүл мэндийн үзлэг хийдэг зэрэг ач холбогдолтой практикийг хэрэг бүртгэх мөрдөн байцаах байгууллагатай хамтран ярилцаж, хэрэгжүүлж үзэх;
18. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлд заасан нотлох баримтад орлогоос давсан хэмжээний хөрөнгийн талаарх нотолгоог туслах чанарын нотолгоо болгох заалтыг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;
19. Нотолгооны тухай хууль боловсруулах;
20. Бэлтгэл шүүх хурал гэдэг практикийг Монголд нэвтрүүлэх талаар судлах, холбогдох хуульд өөрчлөлт оруулах;
21. Зөвшөөрөл, лиценз олгодог албан тушаалд тодорхой хугацаагаар ажиллуулдаг практикийг хэрэглэх, холбогдох хууль тогтоомжид нь өөрчлөлт оруулах;
22. Авлигад өртөх магадлалтай албан тушаалтан өдрийн тэмдэглэл хөтөлдөг практикийг туршин хэрэглэж үзэх;
23. Эрүүгийн хуулинд шүүгдэгч хохирлыг төлж барагдуулсан, гэм буруугаа хүлээвэл хүнд, хөнгөн хэргийг бүгдийг нь хялбаршуулсан журмаар /шүүх хурлыг/ шүүгч дангаар шийддэг болох. Ингэхийн тулд мөрдөн шалгах ажиллагааг чанартай сайн явуулах талаар ЭБШХ-д тусгах;
24. Шүүгдэгч нь хүнд гэмт хэрэг үйлдсэн боловч хохирлоо нөхөн төлсөн үед оногдуулах хорих ялыг тэнсэн хянан харгалзах заалтыг Эрүүгийн хуульд оруулах;
25. Онц хүнд хэргийн гэмт хэрэгтэн болон цагдан хорих арга хэмжээг сунгах үед заавал шүүх хуралдаанд оролцуулахгүйгээр видео, техник хэрэгсэл ашиглан хийдэг Сингапурын туршлага /технологын шүүх/-ыг шүүхэд нэвтрүүлэх. Мөн энэ асуудлыг гэрчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж болно;
26. Авлигатай тэмцэх улс төрийн хүсэл зоригийг төрийн албан хаагчаас авахуулаад иргэдэд төлөвшүүлэх талаар АТГ өргөн цар хүрээтэй ажил явуулах.

**СУДАЛГААНЫ САН**

## **АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА СЭДЭВТ СУРГАЛТ**

2014 оны 2 дугаар сарын 10- 14  
Бүгд Найрамдах Сингапур Улс

**Сургалтад оролцогчид:**

С.Нямжав, Монгол Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн танхимиийн тэргүүн

Б.Энхбаатар, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Сургалтын албаны дарга

Ш.Баярбилэг, Нийслэлийн Прокурорын газрын Мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор

Н.Бадамцэцэг, Нийслэлийн Прокурорын газрын Мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор

П.Болд, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөн байцаагч

Д.Золжаргал, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч

Басанта Покхарел, АНУ-ын Азийн Сангийн Төслийн удирдагч

А.Баянмөнх, АНУ-ын Азийн сангийн Засаглалын хөтөлбөрийн менежер



### Хичээл болон уулзалтын тэмдэглэлээс:

- Ерөнхий сайдад мэдээлдэг тайлагнадаг тогтолцоог Монголд хэрэгжүүлэх боломжтой. Ерөнхий сайдын харьяанд байдаг учраас илүү, эрх мэдэлтэй, үр нөлөөтэй байдаг.
- Авлигын эсрэг ажлыг дээрээс, эрх мэдэл, албан тушаалтай хүмүүсээс шат шатандаа хэрэгжүүлж эхэлбэл илүү үр дүнтэй. Улс орны хувьд ард иргэдээс шахалт үзүүлсэн авлигын санаачлага үр дүнд хүрсэн тохиолдол маш цөөн. Энэ бол улс төрийн хүсэл зориг юм. Үндсэндээ энэ бол итгэл үнэмшилийн асуудал.
- Эхлээд том загасаа шарах ёстой. Өөрийнхөөсөө эхлэх хэрэгтэй. Тэгээд дээрээсээ системтэйгээр доод шатнуудад үргэлжлэх ёстой.
- Ер нь бол итгэл үнэмшил, эр зоригтой байх ёстой. Тэгж байж л өөрчлөлт хийж чадна. Тэгснээр бусдаас адил зүйл хийх ёс зүйн эрх хэмжээ олж авдаг юм.
- Ихэнх улсуудад улс төрчид, эсвэл төрийн албан хаагчид өөрийнхөө талын хүнийг оролдохоос айдаг. Засгийг унагах аюултай гэж айдаг. Ийм эргэлзэх зүйлгүйтгээр шийдвэрлэж чаддаг байх ёстой. Жишээ нь Ликваню өөрийнхөө сайд нарыг широнд явуулж чадсан байдаг.
- Сингапурт олон нийтийг соён гэгээрүүлэх компанийт ажил хэзээ ч хийж байгаагүй.
- Авлигын хэргийн тодорхойлолт, томьёолол маш тодорхой байх ёстой.
- Сингапураас сайн хуультай улсууд бий. Гэхдээ сингапур хамгийн сайн хэрэгжүүлж чаддагаараа онцлог юм.
- Хог ачигчид баярласнаа илэрхийлж мөнгө өглөө гэж бодьё. 1960-д онд шууданч болон хог ачигчид ямар нэг мөнгө, эд зүйл өгсөн айл өрхүүдэд хариуцлага тооцож эхэлсэн. Энэ бол хортой үр дагавартай учраас үүний эсрэг арга хэмжээ авсан. Учир нь бусад хүмүүсээс манай хогийг авсангүй гэдэг гомдлууд их ирсэн учраас. Энэ үйлчилгээ бол ялгаварлалгүйгээр нийтэд хүрэх ёстой зүйл юм. Ресторанд ч гэсэн адил. Цайны мөнгө өгдөг хүнд сайн үйлчлээд, өгдөггүйд нь тааруу үйлчлэх магадлалтай. Нийгэмд учруулж байгаа хор хохирол нь гол шалгуур нь юм.
- Нотлоход яагаад хэцүү вэ? Аль аль нь тохиролцож, хоёулаа давуу байдал олж байгаа учраас хоёулаа сэтгэл ханамжтай үлддэг учраас тэр. Мөрдлөг эхлэхэд аль аль дургүй байдаг. Ийм нөхцөлд гарах хэдэн арга бий. Эсрэг мэдүүлэг өгнө гэвэл авлига өгсөн биш харин гэрчээр тооцож хариуцлагаас чөлөөлөх амлалт өгөх зохицуулалт бий. Олон улс оронд ийм арга бий. Гэхдээ ийм саналыг Прокурор гаргах эрхтэй. Гэхдээ ийм саналыг хариуцлага тооцох гэсэн зорилготой этгээдээ санах хэрэгтэй. Төрийн албан хаагчид хариуцлага тооцох нь чухал учраас өгсөн иргэнд энэ саналыг тавих нь зохимжтой.

- Reverse burden of proof гэх аргыг ихэнх улсуудад хэрэглэдэг. Энэ нь яллагч буруутайг нотлох биш харин сэжигтэн этгээд гэм буруугүй гэдгээ нотлох тогтолцоо юм. Жишээ нь замын цагдаа жолоочийг зогсоогоод үнэмлэхтэй эсэхээ нотлож харуулахыг шаарддаг зарчим бүх улсад адил байдаг. Яг үүнтэй адилаар авлигын хэрэгт ч мөн адил тухайн этгээд буруугүй болохоо нотлох үүрэг хүлээдэг. Хэрэв авлигачыг нотлох үүрэг нь прокурорт байгаад байх юм бол нийгэм хохирсон хэвээр байх болно. Яагаад гэвэл хэрэгтний үйлдлийг нотлоход маш хэцүү.
- Нотлогдохгүй байхад байгууллагад нь мэдэгдэж, захиргааны хариуцлага тооцуулах ямар үндэслэл байна вэ? Цагдаа, жолоочийн жишээн дээр үзье. Цагдаа жолоочоос авлига авсныг мэдээж нотолж чадахгүй. Өгч авсныг нотолж чадахгүй учраас шүүхээр шийдэж чадахгүй. Гэхдээ цагдаа жолоочид хариуцлага тооцох ёстой байсан мөртлөө зүгээр явуулсан факт нь байгаа учраас, ажлаа хийгээгүй гэдэг үндэслэлээр нь хариуцлага тооцуулахаар арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай.
- Захиргааны хариуцлага тооцуулах санаачлагыг авлигын товчооноос төрийн албаны байгууллагад тавьдаг.
- Сингапурт ямар ч дархан эрх, хамгаалалт гэж ойлголт байдаггүй. Тийм ойлголт байхгүй. Албан тушаалтан хэрэгт шалгагдаж байгаа бол заавал ажлаас нь чөлөөлж мөрдөн шалгадаг.
- Авлигатай тэмцэхэд мөрдөн шалгах, яллах, шүүх З байгууллага чадварлаг, үр нөлөөтэй байж үр дүнд хүрнэ. Их хэмжээний хэргийг шийдвэрлэхийн тулд шөнийн шүүх ажиллуулдаг байсан. Book: Judicial Led reforms.
- Үр дүнтэй захиргааны байгууллагад хяналт шалгالت маш сайн байдаг. Өмнө нь бид хэзээ ч авлиын эсрэг албан соён гэгээрүүлэх ажил хийж байгаагүй. Бид шууд амьдрал, практик дээр л зааж сургадаг. Жишээ нь шууд төрийн албанд чиг үүрэг, хариуцлагыг нь хэлж, сануулж өгдөг. 70-80 онуудад төрийн алба, захиргааны байгууллагуудтай маш сайн тулж ажилласан. Тэрнээс хойш төрийн алба маш сайн цэвэрлэгдсэн.
- Захиргааны бүтэц зохион байгуулалт, түүний үйл ажиллагаа маш үр дүнтэй, ямар нэг цоорхойгүй учраас авлига гарах боломж олгодоггүй. Чиг үүргийг маш тодорхой заадаг. Гэхдээ боломжтой зүйлийг л ажил үүрэгт нь оруулах ёстой. Дагаж мөрдөх дүрэм журмыг маш тодорхой зааж өгдөг.
- Мэдээллийн хяналт, орц гарцыг маш сайн хянадаг.
- Жижиг шан харамж, хээл хахуульд анхаарал тавихгүй байх нь цааш том авлига үүсэх үндэс болдог. Зочломтгой байдал. Янз бүрийн давуу байдал, үзвэр, хандив гэх мэт нь ноцтой авлига руу халтирах үндэс болно.
- Нэг жишээ: Хураамж авдаг маш ажилдаа сайн албан хаагч байсан. Сайн ажилтан байсан учраас түүнийг шалгадаггүй байсан. Амралтаа ч авдаггүй ажилдаг хүн байсан. Харин тэрээр иргэдээс 100 доллар авдаг. Харин байгууллагад тушаадаг баримт дээр 80 гэж бичдэг байсан. Олон жил үргэлжилж, тэтгэвэрт гарах үед нь мэдсэн. Шинэ ажилтан ажил авсны дараа

орлогын зөрүү гарснаар баригдсан байдаг.

- Aesop гэж грекийн зохиолчийн шударга ёсны агуулгатай хүүхдийн үлгэрүүд байдаг.
- Зочломтгой байдал, авлига хоёрын хооронд маш бага ялгаа байдаг. Гол нь авлигын сэдэл байна уу. Тэр зүйлийг авсанаараа эрт орой хэзээ нэгэн цагт хариу нэхэх, эсвэл нөгөө тал нь өгөхөд хүрэх эсэхээ, ямар нэг хүлээлттэй байх эсэхээ л бодох ёстой. Хэрэв тийм зүйл байгаа бол энэ авлига болно.
- ADB/OECD болон UNCAC-ийн загвар, төлөвлөгөөнүүд хамгийн үр дүнтэй. Юуг хийх гэдэг нь чухал биш. Харин яаж хийх нь чухал. Яагаад гэвэл Сингапурын загварыг хэрэгжүүлэхийн тулд дээрх олон улсын загварын шаардлагыг мөн адил хангах болно гэсэн үг.
- Хариуцлагатай, цэвэр төрийн албатай байх нь хүчтэй авлигын эсрэг байгууллагад найдахаас илүү үр дүнтэй.
- Улс төрийн буюу удирдагчийн хүсэл зориг хамгийн чухал.
- Авлигын эсрэг байгууллага бие даасан, хараат бус байх ёстой гэж их яригддаг. Гэвч бодит амьдрал дээр ямар ч авлигын эсрэг байгууллага бие даасан байж чадахгүй. Энэ байгууллага заавал төр, засгийн дэмжлэг авч, хамтарч ажилласнаар л амжилт олно. Болохгүй бүх зүйлийг залруулах арга хэмжээ авч, хариуцлага тооцож байж л үр дүнд хүрнэ.

**Ардын Үйл хэргийн Намын уулзалт:** Тус 1969 оноос хойш төрийн эрхийг дангаараа барьж ирсэн. Нам ямар ч өмч хөрөнгө эзэмшихгүй гэсэн бодлоготой. Одоогийн байр нь орон сууцны хорооноос байгууллагатай хувааж түрээслэдэг байр. Сингапурт 23 бүртгэлтэй улс төрийн нам байдгаас зөвхөн 1 нь байраа өмчилдөг.

Намын гишүүн 17-аас дээш насны, гишүүнчлэлд парламентын гишүүн болон намын бусад гишүүдийн санал болгосноор намд оруулдаг. Намын гишүүний жилийн хураамж 9 доллар байна. Парламентын гишүүн болсон намын гишүүн орлогынхоо 10-аас доошгүй хувийг намд хандивлах үүрэгтэй байдаг.

Нам өөрөө авлигаас ангид байх ёстой гэсэн зарчмыг мөрдөж ирсэн. 2 жил тутамд удирдах зөвлөл сонгогддог. Намд цалинтай 18 орон тооны албан хаагчтай. Бусад нь сайн дурын ажилтнууд.

Нийт намын гишүүдийн тоог 60 оноос хойш олон нийтэд мэдэгдээгүй. Олон нийтэд сууринласан биш, харин кадрт сууринласан нам учраас тэр юм. Парламентад хувийн бизнестэй намын гишүүд байдаг. Гэхдээ эдгээр хүмүүс намд орохосоо өмнө бизнестэй байсан хүмүүс юм. Зөвхөн итгэл даасан, шалгуур хангасан хүмүүсийг намд элсүүлдэг.

**Авлигын хэргийг шалгах товчооны уулзалт:** Дэлхийн нийтээр 4 хүн тутмын 1 нь авлига өгдөг гэх судалгаа бий. Мөрдөн байцаах тасаг байгууллагын 60

хувийг эзэлдэг. Одоогоор 150 ажилтантай. Төсөв 20-25 сая доллар буюу 0.07 хувь.

Санхүүгийн гүйлгээтэй холбоотой асуудлыг дагнан судалж, шалгадаг мэргэшсэн мөрдөх баг ажиллуулдаг. Мэдээллийн технологийн баг ажилладаг. Устгасан зүйлийг сэргээх. Мөн гүйцэтгэх ажиллагааны хэлтэстэй.

Нийт мэдээллийн 50 орчим хувь нь нэр, усгүй байдаг. Тийм учраас цөөнгүй хэрэг цааш явж чаддаггүй. Жилд 800-900 гомдол авч, тэдгээрээс 200-300 хэрэгт 175 хүн шүүхээр шийдэгдсэн. Хэргээр тоолох боломжгүй.

Авлигын хэрэг шүүхэд амжилт олохооргүй, нотлогдохгүй бол прокуророос тухайн хүний талаар байгууллагад нь сахилгын сануулга, мэдэгдэл хүргүүлдэг. Энэ нь тухайн этгээдэд сануулга болж өгдөг.

7 хоног бүр ирсэн бүх мэдээллийг шалгаад мөрдөх эсэхийг хороогоор шийддэг. Томхон хэрэг дээр багаар ажилладаг. Ингэснээр ганц мөрдөн байцаагчийг сэжиглэхээс сэргийлдэг.

**Ерөнхий Прокурорын газар дахь уулзалт:** Авлигын хэргийг хариуцаж ажилладаг прокурор байдаг. Хувийн хэвшлийн хүн хэрэгт холбогдовол үйлдэл болон гэмт санаа бодолтой байсан гэдгийг нь нотлох хэрэгтэй болдог. Харин төрийн албан хаагчийн хувьд хуулийн өөр заалт бий. Төрийн албан хаагчийн хувьд авлигын харилцаанд орсон гэдгийг нь л нотлоход хангалттай. Харин эргээд албан хаагч тухайн үйлдэл нь авлигатай хамааралгүй гэдгээ хариу нотлох үүрэгтэй. (Section 9 Prevention of Corruption Act).

Нэг хэсэг мэдээлэл нэр хаягтай ирдэг. Гэхдээ жил бүр их хэмжээний нэр хаяггүй мэдээлэл ирдэг. Мэдээж худал мэдээлэл, гүтгэлэг ирдэг. Шүүхээс мэдээлэл өгөгчийн нэр хаягийг тодорхой болгохыг хүсэх боломжтой. Гэхдээ ингэж шалгаж явсан практик тохиолдол байхгүй. Гэхдээ сайн судалж, шалгадаг. Салбараар нь сонгож шалгалт явуулдаг. Мөн гүйцэтгэх ажиллагааны арга байна. Гэхдээ ийм мэдээллийг шүүхэд нотолгоо болгодоггүй. Харин жинхэнэ мөрдлөгийг цааш үргэлжлүүлэх, сэжим олж өгөх арга зам болдог.

Мэдээлэл өгсний урамшил гэж байхгүй. Биечлэн ирсэн нөхцөлд зөвхөн гэрчийг хамгаалах л ёстой.

Америк шиг дуугүй байх эрхгүй. Гэхдээ өөртөө хохирол учруулах зүйл хэлэхгүй байх эрхтэй. Гэхдээ хуулиар авлигын хэрэгт холбогдсон бол мэдэж байгаа бүх зүйлээ хэлэх ёстой гэсэн зохицуулалт бий.

Авлигын хэрэг дээр ялангуяа хэрэгтэн этгээд буруугүй гэдгээ л байнга хэлдэг. Үндсэндээ Сингапурт яллах талын нотолгоог л цуглувалдаг гэж ойлгож болно.

Өмнө нь мөрдөгч нар хэргээ дуусгаад бүрэн хүлээлгэж өгөөд бид дутуу бол гүйцээх, сайжруулах, эсвэл хэрэгсэхгүй болгох зөвлөгөө өгдөг байсан. Гэхдээ одоо прокурорууд үйл ажиллагааны эхнээс нь оролцдог болж байгаа. Гол нь үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх байдлаар.

Мөрдөн байцаагч бичгээр хүсэлт гаргах шаардлагагүй. Гол санаа нь прокурорыг мөрдөн байцаагчийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд бэлэн байлгах явдал юм. Энэ нь янз бурийн асуудал байдаг. Амаар тодруулж асуух зүйлүүд ч байдаг. Ямар ч асуудлууд байж болдог.

Мөрдөн байцаалтын хугацаа байхгүй. Шалтгааныг нь харж хугацааг тодорхойлж шийддэг. Хэргийн ноцтой байдлаас шалтгаалж янз янзын хугацаагаар шийдэгддэг.

Сингапурт нийтдээ 150 прокурор, авлигаар мэргэшсэн 8-10 прокурор ажилладаг. Прокурорын гаргаж байгаа шийдвэр дор хаяж нэг дээд шатны прокурорын хяналттайгаар баталгааждаг. Томхон хэрэг дээр Ерөнхий прокурор хүртэл өөрөө хянаагдаг.

Авлигын болон прокурорын харилцаа өмнө нь тааруу, зөрчилтэй байсан. Цагдаа нар прокурорт хүндэтгэлтэй ханддаг байсан бол. Авлигынхан адил зиндаатай юм шиг байхыг оролддог байсан. Гэхдээ үүнийг залруулахын тулд удирдах ажилтнуудыг уулзуулдаг болсон. Одоо илүү тусгайлан ярилцдаг, учир шалтгаанаа ярилцдаг болсон. Харилцааг сайжруулахын тулд ажлын харилцааг ахлах, удирдах ажилтнуудын хооронд бий болгох хэрэгтэй.

**Анхан шатны шүүх дэх уулзалт:** Шүүх ирсэн хэрэг дээр нэмж яллах, ялласан хэмжээнээс хэтрүүлэх эрх байхгүй. Зөвхөн ялласан хүрээнд гэм буруутай эсэхийг тогтоож, зохих ял шийтгэлийг оногдуулдаг.

Төрийн албан хаагч хэн нэгэнд хариу ямар ч шан харамж, давуу байдал олж авалгүйгээр тусласан бол гэмт хэрэгт тооцох уу? Гэмт санаа байгаагүй бол буруугүй. Гэхдээ төрийн албан хаагчийн хувьд бусдад давуу байдал олгохгүй байх дүрэм журамтай байдаг. Үүнийгээ зөрчсөн утгаараа захирааны хариуцлага хүлээх үндэслэл болно.

Шүүгчийн хараат бус байдлыг хангах зорилгоор бусад төрийн албан хаагчдаас илүү хангамж нөхцөл бий юу? Манай хамгийн гол шалгуур бол анх аваадаа шалгалт, үнэлгээг маш сайн хийдэг. Хоёрт цалин урамшуулал гайгүй сайн өгдөг. Мөн хэрэг хуваарилалтыг маш сайн нарийвчлан зохион байгуулдаг.

Анхан шатанд бараг бүх хэргийг 1 шүүгч дангаараа шийддэг. Харин давж заалдах шатанд л 3 шүүгч, эсвэл 5 шүүгч шийддэг. Авлигын болон эдийн засгийн гэмт хэргийг шийддэг 8 шүүгчтэй баг байдаг. Салбараар баг болдог. Жишээ нь гэр бүлийн гэх мэт.

Хэрэв гэм буруутай буруугүйг тогтоогоод шүүх ажиллагааг цааш үргэлжлүүлэхэд бэлэн бол шууд өдөрт нь шийдвэрлэдэг. Үгүй бол прокурорт ял оноох хуралд бэлтгэх 14 хоног хүртэлх хугацаа өгдөг. Энэ бэлтгэлд прокурор тухайн гэмт хэрэгтэй холбоотой өмнөх шийдвэрүүдийг судалж бэлдэх боломжийг өгдөг.

Шүүх прокурорт даалгавар өгөх, хэргийг дахин буцаадаггүй. Учир нь хоёр талын оруулж ирсэн баримт нотолгоонд л тулгуурлаж эцэслэж шийддэг adversarial system учраас тэр. Эх газрын эрх зүйн системд *inquisitorial* гэж нэрлэгддэг.

2014 оны 02 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

## **Бүгд Найрамдах Сингапур Улсад сургалтанд хамрагдсан тухай илтгэх хуудас**

Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/13 дугаар тушаалаар тус газрын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөн байцаагч, ахлах комиссар П.Болд, мөрдөн байцаагч, комиссар Д.Золжаргал бил 2014 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2014 оны 02 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд албан томилолтоор АНУ-ын Азийн сангийн санхүүжилтээр Бүгд Найрамдах Сингапур Улсын Төрийн албаны коллежоос зохион байгуулсан “Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх Олон Улсын туршлага” сэдэвт сертификатын сургалтанд суралцлаа.

### **Сургалтын бүрэлдэхүүнд:**

Монгол Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн танхимиийн тэргүүн шүүгч С.Нямжав, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Сургалтын албаны дарга Б.Энхбаатар, Нийслэлийн Прокурорын газрын Мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Ш.Баярбилэг, Н.Бадамцэцэг, АНУ-ын Азийн Сангийн Төслийн удирдагч Басанта Покхарел, төслийн мэргэжилтэн Н.Баянмөнх, орчуулагч З.Базаргүр нарын нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр Сингапур Улсын Төрийн албаны коллежид болсон сургалтанд оролцлоо.

### **Сургалтын зорилго:**

Монгол Улсын авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлж буй Авлигатай тэмцэх газар, прокурор, шүүх байгууллагын ажилтнуудын төлөөллийг Бүгд Найрамдах Сингапур Улсын авлигатай тэмцэх эрх зүйн тогтолцоо, Засгийн газар, Улс төрийн нам, Шүүх, Прокурор, Аудит, Авлигатай тэмцэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, авлигатай тэмцэж ирсэн үйл ажиллагаа, түүний үр дүнтэй танилцаж, Монгол Улсад хэрэгжүүлж болохуйц туршлагыг судлах, суралцаж олж авсан шинэ мэдээллийг Монгол улсын шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газрын алба хаагчдад танилцуулга, сургалт явуулахад чиглэгдсэн болно.

### **Сургалтын хөтөлбөрийн талаар:**

Сургалтанд доорх сэдвүүдээр багш нар илтгэл танилцуулга хийж оролцогчдын асуултад хариулт өгөх зарчмаар явагдлаа. Үүнд:

Сингапур Улсын Төрийн албаны коллежи дээр

- Сингапур Улсын сайн засаглал, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай

тэмцэх хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, авлигын үйлдэлд тавих хяналт сэдвээр Сингапур Улсын Авлигын хэргийг мөрдөн шалгах товчооны дарга асан Chua Cher Yak;

- Авлигагүй орчныг бэхжүүлэхэд Сингапурын Ерөнхий аудиторын газрын үүрэг сэдвээр Ерөнхий аудитор асан Төрийн албаны коллежийн сургагч Teo Chi Khiang;
- Сингапур Улсын Ард түмний үйл хэргийн намын байраар зочилж Сингапур Улсын түүхэн хөгжил, авлигатай тэмцэх ажилд улс төрийн намын нөлөө сэдвээр Ард түмний үйл ажиллагааны намын гишүүн, парламентийн гишүүн, Chua Chu Kang;
- Сингапур Улсын Авлигын хэргийг мөрдөн шалгах товчооны байраар зочилж Сингапур Улсын Авлигын хэргийг мөрдөн шалгах товчооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар уг товчооны Үйл ажиллагаа хариуцсан захирал Ko Tek Khin;
- Сингапур Улсын Прокурорын газраар зочилж тус улсын эрх зүйн орчин, прокурорын байгууллагын авлигын хэргийг хянан шалгах үйл ажиллагаа сэдвээр Ерөнхий Прокурорын байгууллагын Авлигын гэмт хэрэгт хяналт тавих ажил хариуцсан прокурор G.Kannan;
- Сингапур Улсын анхан шатны шүүхээр зочилж тус улсын шүүхийн тогтолцооны талаар ойлголт сэдвээр Анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч Сон Зье Виан нар тус тус сургалт явуулсан.

### [Сургалтаар:](#)

Сингапур Улс нь 1945 онд Японы дараангуйлалаас чөлөөлөгдөж Их Британийн мэдэлд шилжсэн бөгөөд тухайн үед Малайз Улсын нэг хэсэг хэмээн тооцогдож Малайзын Парламентед нэг суудалтай байсан байна. Их Британийн удирдлагад байх үед Сингапур Улс нь ихээхэн хэмжээний авлигад автаж нийгмийн бүхий л түвшинд авлига гүнзгий тархсан байжээ. 1951 онд их хэмжээний мансууруулах бодисыг зөөвөрлөх явцад дээрэмдсэн хэрэг гарч энэхүү хэргийг цагдаагийн байгууллагын ажилтнуудтай нэр холбогдоор Авлигатай тэмцэх бие даасан байгууллагыг байгуулах үндэс болж 1952 онд 5 ажилтантай байгуулагдаж байсан. 1965 онд Сингапур Улс нь Их Британиас төрийн эрх мэдлээ хүлээн авснаар бие даан улс төрийн үйл ажиллагаа явуулах тусгаар тогтносон улс болох эхний алхам тавигдсан байна. 1969 онд болсон бүх нийтийн сонгуулиас Сингадур Улсын иргэд Малайз Улсын парламентаас гарч бие даасан тусгаар улс байх шийдвэр гаргаж өөрийн парламентийг байгуулсан байна.

1969 онд тусгаар тогнолоо жинхэнэ утгаар нь олж авснаар төрийн эрх мэдлийг Сингапурын Ард түмний үйл ажиллагааны нам сонгуулийн үр дүнд авч авлигатай тэмцэх тэмцлийг эхлүүлсэн байна.

### [Улс төрийн нам:](#)

Сингапур Улсад төрийн 23 нам бүртгэлтэй байдаг бөгөөд хамгийн сүүлийн сонгуулиар 10 нам идэвхитэй үйл ажиллагаа явуулж сонгуульд оролцон параламентэд суудалтай болсон байна. Гэвч 1969 оноос хойш өнөөдрийг хүртэл тус улсын төрийн эрхийг “Ард түмний үйл ажиллагааны нам” тасралтгүй барьж байна. Энэ нам үүсгэн байгуулагдсан цагаасаа Сингапур улсын тусгаар тогтнол, авлигагүй, хөгжилтэй улсыг байгуулахын төлөө ажиллаж сонгууль бүрт ялалт байгуулсаар ирсэн байна. Улс төрийн намуудын тухай хуулиар нам өмч хөрөнгөтэй байхыг хориглоогүй боловч Сингапур улсад үйл ажиллагаа явуулж байгаа улс төрийн намууд нь өөрийн гэсэн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөтэй болохыг хүсээгүй бөгөөд намын байр, түүн доторх эд хөрөнгийг олон нийтийн байгууллагаас түрээслэн үйл ажиллагаа явуулсаар ирсэн байна. Түүнчлэн нам аж ахуйн үйл ажиллагаа явуулж ашиг орлого олдоггүй байна. Намын үйл ажиллагааны санхүүжилт нь хуулийн дагуу улсаас өгч бус санхүүжилт болон гишүүдийн татвар, иргэн, аж ахуйн нэгжээс өгч буй хандиваас бүрддэг байна.

Сингапурын авлигатай тэмцэж үр дүнд хүрсэн нь сайн Авлигатай тэмцэх байгууллага, сайн хууль, сайн шүүн таслах ажиллагаа, сайн засаглал бүрдсэнтэй холбоотой. Үүнийг нэг үгээр хэлбэл улс төрчид, улс төрийн намын удирдлага авлигатай тэмцэх улс төрийн хүсэл зоригтой байсан түүнийгээ хэрэгжүүлж чадсанд оршдог байна. Улс төрчид түүн дотроо Засгийн газар авлигатай тэмцэх хүсэл зориггүй, улс төрчид засгийн газрын гишүүд нь авлигад идэгдсэн түүнд нэр холбогдсон бол тэд иргэдэд авлигатай тэмц гэж хэлэх эрхгүй юм. Иргэд тэдэнд чи өөрөө өхлээд авлигатайгаа тэмц дараа нь надад хэл гэсэн байдлаар хандаж эхэлдэг.

Улс төрчид зөвхөн авлигатай тэмцэнэ гэж ярих биш тэр ярьж байгаагаа хэрэгжүүлэх чадвар байх хэрэгтэй. Хүсэл зоригтоо байнга сэдэлжүүлж байх ёстой. Улс төрийн хүсэл зориг нь улс төрийн манлайлалаас гарах бөгөөд авлигатай тэмцэнэ гэж амнаас гаргаж байгаа уг бүрээ зөв үйлдлээр хэрэгжүүлж байх ёстой гэжээ.

Засгийн газар, улс төрийн намууд улс орныхоо төлөө сайн үйлдлийг хийж хүсэл тэмүүлэлтэй, шударга, үндэсэрхэг хүмүүсийг олж, тэднээр намаа бэхжүүлж байх ёстой. Засгийн эрх барьж буй намын хувьд цэвэр, авлигаас ангид байх нь тэдний удирдах зургаан зарчмын нэг байдаг бөгөөд зөвхөн үнэнч шударга байхыг хүсэж бус, түүнийг заавал биелүүлэх шаардлагыг бий болгодог байна.

Засгийн газрын зүгээс авлигын боломжуудыг бууруулахын тулд хууль зүйн болон захирагааны бүх арга хэмжээг боломжит бүх үйл ажиллагааг явуулан авлигад нэр холбогдож буй этгээдүүдийг илрүүлэх, тэднийг хүндээр шийтгэх үйл явцад анхаарал хандуулдаг байна.

Улс төрчдийн авлига нь улс орныг бүтээн босгох эсхүл сүйрэлд хүргэдэг гэдэгт бат итгэсэн байдаг байна.

Үндэсний хөгжлийн бодлого гаргаж хэрэгжүүлэх хэрэгтэй бөгөөд, уг бодлогыг хэрэгжүүлэх төрийн алба хаагчид нь авлигад идэгдсэн байж болохгүй тул

тэднийг мөн авлигаас ангижруулах ёстай. Авлигатай улс орноос хүссэн хүсээгүй гадаадын хөрөнгө оруулалт зайгаа барьж зугтдаг. Авлигатай тэмцэх стратеги нь дээрээсээ доошоо чиглэсэн байх ёстай. Ингэж байж үр дүнд хүрнэ.

Засгийн газрыг тэргүүлж байгаа болон улс төрийн намын тэргүүн өөрөө цэвэр ёс суртахуунтай, шударга байж авлигатай үр дүнтэй тэмцэж чадна. Гол удирдагч нар өөрсдөө авлигад идэгдсэн бол үйл ажиллагаа нь үр дүнд хүрэхгүй нурж унана, мөн иргэдийн дэмжлэгийг ч авч чадахгүй.

Засгийн газраас албан тушаал дэвшүүлэх хүний болон цалинг нэмэгдүүлэхдээ Авлигын хэргийг мөрдөн шалгах товчооны хар дансанд орсон хүнийг албан тушаал дэвшүүлдэггүй, цалинг нь нэмэгдүүлдэггүй байна.

Сайн, цэвэр засаглал болон системийг эхнээс нь бий болгох нь Авлигатай тэмцэх газарт авлигад автсан, эмх амбараагүй засаглалыг цэвэрлэснээс хавьгүй илүү үр дүнтэй.

Улс төрийн хүсэл зориг нь авлигатай тэмцэх үйл ажиллагааны гол суурь, үр дүнд хүргэх гол хөдөлгөгч хүч байдаг тогтвортой улс төр нь авлигын эсрэг хөдөлгөөнийг үр дүнтэй тогтвортой байлгахад түлхэц болдог. Энэ хүсэл дээр хувийн хэвшлийнхэний хүсэл зориг болон авлигатай тэмцэх байгууллагын эрс шийдэмгийн үйл ажиллагаа дэмжлэг болж өгдөг. Олон нийтийн дэмжлэгийг үйл ажиллагаандaa авах, үйл ажиллагаагаа аль болох урт удаан хугацаанд тогтвортой явуулах нь авлигыг тогтвортой хянаж таслан зогсоход ач холбогдолтой.

Засгийн газарт томилогдож байгаа намын гишүүд нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн нэр дээрхи бизнесийн үйл ажиллагааг зогсоо хуулийн заалттай байдаг байна.

Үйл ажиллагааг явуулж гаж тогтолцоог засахын зэрэгцээ зүрх сэтгэл оюун санаагаа засаж явах шаардлагатай.

#### [Авлигаас урьдчилан сэргийлэх мөрдөн шалгах товчоо:](#)

Сингапурын Улсын Авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо нь Засгийн газрын бүтцэд Ерөнхий сайдын шууд удирдлагад багтдаг бөгөөд 2012 оноос өмнө 88 албан хаагчтай болсон байна. Тэдний 57 нь мөрдөн байцаагч 9 мөрдөн байцаалтад туслах ажилтан, 22 захиргааны ажилтантай байсан бол, 2012 онд энэ орон тоог 156 ажилтантай болгож нэмэгдүүлсэн байна. Нийт ажилтнуудынх нь 60 хувийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий алба хаагчид эзэлдэг байна.

Байгууллагын жилийн төсөв 20-22 сая Сингапур доллар байдаг ба энэ нь улсын нийт төсвийн 0,06-0,07 хувийг эзэлдэг байна.

Байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим нь мөрдөн шалгах чиг үүргийг давамгай хэрэгжүүлдэг, учир нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа нь тийм ч үр дүнтэй бус, жишээ нь: зам хөндлөн гарцгүй газраар

гарч болохгүй, жолоо барихдаа гар утсаар ярьж болохгүй гэж хичнээн олон анхааруулаад иргэдийн дийлэнх нь энэ анхааруулгыг биелүүлдэггүй бол уг зөрчлийг гаргасан хүмүүст хариуцлага хүлээлгэж өндөр торгууль ногдуулаад эхлэхээр тэд хүссэн хүсээгүй зөрчил гаргахаа больдог. Үүний нэгэн адил авлига битгий ав, өг гэж хичнээн хэлээд үр дүнд хүрэхгүй тул авлига өгч, авч байгаа этгээдүүдийг мөрдөн шалгаж тэдэнд хатуу чанга хуулийн хариуцлага хүлээлгэснээр авлига буурах үндэс болдог. Ер нь бол нэг хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж 10 хүнийг айлгах, 10 хүнд хариуцлага хүлээлгэж 100 хүнийг айлгах нь хамгийн үр дүнтэй урьдчилан сэргийлэх арга гэж тайлбарлаж байлаа.

Зөвхөн авлигатай тэмцэх газрын алба хаагчид гэлтгүй төрийн алба хаагчид өөрийгөө хянаж шалгадаг тогтолцоонд сайн дураараа элсдэг байх ёстой. Энэ нь нэг нь нөгөөгөө хянаж мэдээлнэ гэсэн үг. Авлигатай тэмцэх ажлыг дээд түвшний албан тушаалтнууд дунд илүү хүчтэй явуулах ёстой. Дээд түвшний алба хаагчдаас хэдий олон хүнд хариуцлага хүлээлгэж чадна, доод түвшний алба хаагчид түүнийг харж өөрсдөө авлигаас сайн дураар татгалзаж, авлигад өртөхөөс зайлсхийж эхэлдэг.

Хэрэв эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын хэргийг шүүхээр бүрэн нотлож чадаагүй тохиолдолд тэдний Засгийн газарт ажиллах эрхийг нь улс төрийн намын удирдлага өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэж тэдний улс төрийн карьеерийг төгсгөл болгож чаддаг байна.

Авлигатай шударгаар тэмцэх нэг чадвар нь чиний найз, хамаатан, хамтран ажилладаг хэн ч бай хууль зөрчсөн бол түүнд хариуцлагыг шударгаар хүлээлгэхэд оршдог байна.

Анх л авлигатай тэмцэх ажлыг эхлэхдээ Сингапурын Авлигын хэргийг мөрдөн шалгах товчооны ажилтнуудад амьдралын хатуу чанга хэв маягийг тогтоож өгсөн бөгөөд энэ байгууллагад ажиллах шударга ажилтнуудыг бусад хууль сахиулах байгууллагуудаас сонгож авах, авлигатай тэмцэх ажлаа хаанаас эхлэх вэ гэсэн шаардлагууд гарч байсан байна. Учир нь тухайн үед хууль сахиулах чиг үүрэг бүхий цагдаагийн байгууллага авлигад мөн л идэгдсэн байсан тул шударга ажилтан олж ажилуулахад хүндрэлтэй байснаас гадна, олдсон шударга ажилтнууд нь авлигатай тэмцэх газарт ирж ажиллахаас эмээх, авлигатай тэмцэх газрын ажилтнуудад тавьсан амьдралын хатуу чанд хэв маягаас татгалзах тохиолдол гарч байсан.

Сингапурын Авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо нь ажилтнуудаа сонгон шалгаруулахдаа нээлттэй зар өгөх байдлаар ажил орохыг хүссэн хүмүүсийн материалуудыг хүлээн авч, ирүүлсэн материалыг хянаж шигшилт явуулж, сонгогдсон хүмүүсийг ярилцлагад оруулдаг байна. Ярилцлагад тэнцсэн хүсэлт гаргагч нараас авлагатай холбоотой энгийн хэргийн даалгавар өгч илтгэл тавиулдаг ба тухайн илтгэлд хэрхэн хандаж байг мөн үнэлдэг байна. Илтгэлээс

шалгарсан хүмүүсийн ар гэрийн байдал, хөрөнгө орлого, ашиг сонирхлын зэрчил зэрэг тухайн хүний бүхий л түүхэд шалгалт явуулж эцсийн шалгаруулалтад сайн үнэлэгдсэн хүнийг ажилтнаар авдаг байна.

Байгууллагын ажилтнуудыг албан үүргээ шударгаар гүйцэтгэж байгааг хэрхэн хянадаг талаар асуухад байгууллагын бүхий л үйл ажиллагаа хяналт өндөртэй ажилтнууд өөрийгөө болон бие биенээ хянаж мэдээлэх зарчмаар явагддаг тул шударга бус ажиллах нөхцөл байдаггүй гэж тайлбарласан болно.

Авлигатай тэмцэх газар түүний ажилтнуудыг хэн хянах вэ гэдэг асуудал мэдээж тулгарна. АТГ-ын ажилтнууд нь төрийн албан хаагчдын дайсан нь болдог тул тэдний үйл ажиллагааг төрийн бусад албан хаагчид болон иргэд сайн хянаж байдаг. АТГ-ын алба хаагч нэг л алдаа гаргавал түүнийг АТГ түүний удирдлага хамгаалах шаардлага байдаггүй. АТГ-ын ажилтан гэмт хэрэг битгийн хэл ёс зүйн зэрчил гаргасан тохиолдолд ч түүнийхээ хариуцлагыг хүлээдэг байх ёстай. Хэрэв ажилтанд хариуцлага хүлээлгэхгүй өнгөрвөл иргэд болон бусад төрийн албан хаагч нарын дунд сөрөг ойлголт төрж иргэд авлигатай тэмцэх тэмцэлд итгэл алдрах эхлэл бий болно.

Сингапурын Авлигатай тэмцэх газар ажилтнуудаа худал яриаг илрүүлэх төхөөрөмжид оруулж үр дүнг Засгийн газартaa тайлагнадаг, энэ аргаар өнгөрсөн жил 2 ажилтнаа ажлаас чөлөөлсөн байна.

Сингапурын авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо нь Хонгконгийн Авлигатай тэмцэх газрын адил ажилтнуудынхаа шударга байдлыг шалгахдаа ажилтанд хахууль санал болгох, давуу байдал, хөнгөлөлт амлах, үзвэр үйлчилгээ, хоолонд урих зэргээр саналыг зохиомлоор тавьж урхидах арга хэрэглэж тухайн ажилтан гадны ямар нэг нөлөөлөлд автах эсэх, шударга бус зан үйл гаргах эсэхийг нь шалгадаг эсэхийг асуухад өмнө нь энэ шалгалтыг хийдэг байсан, гэхдээ дараа нь энэ шалгалтыг явуулахаа больсон. Учир нь манай хуулиар хахууль өгч байгаа болон авч байгаа 2 тал 2-уулаа хариуцлага хүлээх шаардлагатай болдог тул өгөх гэж зохиомол урхи бий болгож байгаа этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх вэ гэдэг маргааныг дагуулж эхэлсэн. Маргаантай асуудлууд гарах болсон тул больсон гэж хариулсан болно.

Мөн Авлигын хэргийг мөрдөн шалгах товчооны албан хаагч гэмт хэрэг, зөрчилд холбогдов тухайн хэргийг Авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо өөрсдөө шалгаж шийдвэрлэдэг, харин авлигын эсрэг хуулиар тогтоосон гэмт хэргээс бусад гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд тухайн хэргийг шалгах эрх бүхий Цагдаагийн байгуулагад шилжүүлдэг байна.

Үг товчооны Мөрдөн шалгах хэлтэс нь Тусгай үйл ажиллагааны хэсэг, Санхүүгийн хэсэг, Цахим тоног төхөөрөмжийн хэсэг, Мөрдөн шалгах хэсэг гэсэн хэсгүүдэд хуваагдан үйл ажиллагаа явуулдаг байна.

Тусгай үйл ажиллагааны хэсэг нь нэгжлэг, үзлэг, болон гүйцэтгэх ажлын арга хэмжээ явуулах чиг үүрэг бүхий мөрдөгчид, Санхүүгийн хэсэг нь санхүүгийн гүйлгээ, орлого зарлага хөрөнгийн гүйлгээг шалгах санхүүч мөрдөгчид, Цахим тоног төхөөрөмжийн хэсэг нь цахим төхөөрөмж дэх файл болон устгагдсан гэмтсэн файлуудыг сэргээх мэргэшсэн комьютерийн мэргэжил бүхий мөрдөгчид, Мөрдөн шалгах хэсэг байцаалт мэдүүлэг авах чиглэл бүхий мөрдөгч нараас бүрддэг байна.

Авлигын гэмт хэрэг нь ихэвчлэн үндэстэн дамнасан санхүүгийн гүйлгээтэй холбогдсон байдаг, цахим байдлаар мөнгөн гүйлгээ шилжиж байдаг тул санхүүгийн гүйлгээг унших болон цахим төхөөрөмжтэй харьцах чадвартай мэргэжлийн хэсгүүдийг байгуулан үйл ажиллагаа явуулах зайлшгүй шаардлага гарсан бөгөөд ингэж байгуулан ажиллуулсан нь үр дүнгээ өгсөн байна.

Аливаа төрийн хаагчийн хэргийг шүүхээр бүрэн нотлож чадаагүй, эсхүл тухайн төрийн албан хаагч авлигын шинжтэй зөрчилд холбогдсон тохиолдолд тэдний асуудлыг Авлигын хэргийг мөрдөн шалгах товчооноос Төрийн албаны зөвлөлд материалын хамт хүргүүлж, Төрийн албаны зөвлөл уг төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэдэг байна. Хариуцлага нь зөвхөн ажлаас халах арга хэмжээ биш, хуульд заасан бусад төрлийн хариуцлагыг хүлээлгэдэг байна.

Аливаа төрийн албан хаагч нэг л удаа хууль бус зүйлд холбогдсон бол тэрээр цаашид хууль бус үйлдэлд холбогдох нь улам хурдцтай гүйнзгийлдэг. Ээлжийн амралтаяв гээд байхад амардаггүй, урт хугацаагаар илүү цагаар ажилладаг, өөр албан тушаалд шилжүүлье гэхэд шилждэггүй тэгсэн мөртлөө байгууллага дээрээ сайн ажилтан гэдэг нэр зүүсэн ажилтнуудыг сайтар хянаж байх шаардлагатай.

### Прокурорын байгууллага:

Сингапурын прокурорын газар нь Иргэний хэлтэс, Олон улсын харилцааны хэлтэс, Эрх зүйн болон хуулийн шинэтгэлийн хэлтэс, Эрүүгийн хэргийн хэлтэс, Эдийн засгийн гэмт хэрэг болон удирдлагын хэлтэс, Улсын яллагчийн хэлтэс, Байгууллагын үйл ажиллагааны хэлтэс, Мэдээллийн хэлтэс гэсэн бүтэцтэй байна.

Сингапурын Авлигаас урьдчилан сэргийлэх хуулийн 241-р зүйлд төрийн байгууллага болон хувийн хэвшил дэх авлигыг эрүүжүүлсэн. Энэ хуульд авлига гэж юу болохыг маш тодорхой тайлбарласан ба авлига авах, өгөх, авахаар шаардах, өгөхөөр амлах, мөнгөн бусаар шагнал, урамшуулал авах, өгөх, зээлийг төлөх, зээл авах, зээл өгөх, ажлын байр санал болгох, секс үйлчилгээ авах, секс үйлчилгээ үзүүлэх, үзвэр үйлчилгээ, хөнгөлөлт авах, үзүүлэх, төлбөрийг нь өмнөөс нь төлөх, үүргийн гүйцэтгэлийг шилжүүлэн авах, хураамжаас чөлөөлөх, бизнесийн даваа тал олж авах, өгөх зэрэг үйлдлийг төрийн албан тушаалтан болон хувийн сектор дахь этгээд үйлдсэн бол гэмт хэрэг гэж хуульчилсан.

Авлигыг ганц төрийн алба гэтгүй хувийн хэвшилд мөн хамааруулан хуульчилсан нь хувийн секторыг цэвэр, эрүүл байлагх зорилготой бөгөөд бизнесийн өртөг нэмэгдэх, инфляци үүсэхээс сэргийлэхээс гадна авлигаас болж гадаадын хөрөнгө оруулалт Сингапур Улсаас дайжин зугтхааас сэргийлэх зорилгыг агуулдаг байна.

Учир нь Сингапур Улс нь газар нутаг жижиг өөрийн гэсэн байгалийн баялаггүй улс бөгөөд улсын нийт худалдааны 90 хувийг импорт, 10 хувийг нь экспорт эзэлдэг байна.

Төрийн албан хаагчийн хувьд мөнгө болон давуу байдлыг олж авсан, шаардснаар авлига авсан нь нотлогдоо гэж үздэг байна. Харин уг хэрэгт холбогдсон албан хаагч өөрөө тухайн мөнгө болон давуу байдал нь авлига биш гэдгийг шүүх дээр нотлох үүргийг хүлээдэг байна.

Прокурорт цагдаагийн байгууллага болон Авлигын хэргийг мөрдөн шалгах товчооны мөрдөн шалгаж байгаа эрүүгийн хэрэгт хөндлөнгөөс хяналт тавих, түүнд оролцох эрх хуулиар олгогдоогүй бөгөөд харин саханаас авлигын хэрэгт дагнасан 8-10 прокурорыг томилон ажиллуулж тэднээс 1 прокурор авлигатай тэмцэх байгууллага дээр байнга сууж ажиллах болсон байна. Уг прокурор нь авлигатай тэмцэх газарт шалгагдаж байгаа эрүүгийн хэрэгт хууль зүйн талаас нь зөвлөгөө өгөх, мөрдөн байцаалтын үйл ажиллагаатай холбоотой хууль зүйн зөвлөгөө өгөх, стратегийн талын зөвлөгөөг өгөх байдлаар ажилладаг бөгөөд эрүүгийн хэргийн бүхий л материалыг хянаж, хийгдэж буй ажиллагаанд хяналт тавьдаггүй байна.

Сингапур Улсын хуулиар Гүйцэтгэх ажлын арга хэмжээгээр олж авсан баримтыг шүүхэд нотлох баримт болгон ашигладаггүй бөгөөд уг баримтыг зөвхөн мөрдөгч нар хэргийн талаар чиг баримжaa авахад л хэрэглэдэг байна.

Сингапурт сүүлийн үед бэлэн мөнгийг хээл хахуульд өгч авах нь эрсдэл ихээр дагуулах болсонтой холбоотойгоор төрийн албан хаагчдадекс үйлчилгээ үзүүлэх, төрийн албан хаагчидекс үйлчилгээ авах байдал нэмэгдсэн байна. Энэ нь тухайн хэргийг нотлоход нилээдгүй хүндрэл тулгарах болсон хэдий ч ийм төрлийн хэд хэдэн хэргийг шүүхээр шийдвэрлүүлсэн байна.

Зарим тохиолдолд авлигын хэргийн эцсийн хувь заяаг ерөнхий прокурор шийдвэрлэдэг бөгөөд тэрээр тухайн эрүүгийн хэрэг олон нийтийн хүсэл сонирхолд нийцэх байна уу гэдэгт анхаарал хандуулан зарим хэрэгт өөрөө эцсийн шийдвэрийг гаргаж яллах ажиллагааг шууд зогсоодог байна.

Сингапур Улс эдийн засгийн хувьд улам хүрээгээ тэлж даяарчлагдаж байгаа одоо үед үндэстэн дамнасан авлига, эдийн засгийн гэмт хэргүүд гарч, уг хэргийг мөрдөн шалгах, түүнийг яллах шинэ асуудал тулгарч ирж байна. Иймд зайлшгүй олон улсын хамтын ажиллагааг сайжруулах шаардлага тулгарч байна.

## Шүүхийн байгууллага:

Сингапурын анхан шатны шүүх нь эрүүгийн, иргэний, гэр бүлийн хэргүүдийг шийдвэрлэдэг бөгөөд анхан шатны шүүхэд эрүүгийн хэргийн 99 хувь нь шийдвэрлэгддэг байна.

Шүүх авлигын хэргийг шийдвэрлэхдээ тухайн авлига авсан, өгсөн үйлдэлд аль тал нь илүү давуу эрхтэй оролцсон этгээдэд нь илүү хүнд ял оногдуулах зарчим баримтладаг бөгөөд гол төлөв төрийн албан тушаалтныг нь илүүтэй шийтгэдэг байна.

Шүүхээс авлигын гэмт хэрэгт оногдуулдаг ялын дээд хэмжээ хамгийн хүнддээ 7 жилийн хорих ял оногдуулахаар хуульчилсан байдаг байна.

Авлигын хэрэг нь цагдан хорих хэрэг байвал Авлигын хэргийг мөрдөн шалгах товчооны мөрдөгч товчооны захирлаар батлуулан тухайн этгээдийг цагдан хорих эрхтэй байдаг бөгөөд цагдан хорих хугацаа 24 цаг байдаг ба энэ хугацаанд түүнийг авлига авсан, өгсөн үйлдлийг нотлосон баримт олж чадаагүй бол тухайн этгээдийг цааш үргэлжлүүлэн хорьдоггүй байна.

Шүүх хуралдаанаар авлигын гэмт хэрэгт гэм буруутай нь тогтоогдсон этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тохиолддолд түүнд оногдуулах ялыг хөнгөрүүлдэг бөгөөд харин гэм буруугаа хүлээн зөвшөөрөгүй тохиолдолд түүнд оногдуулах ялын хэмжээний талаар шүүх хурлыг гэм буруугийн шүүх хурал болсноос хойш 10-14 хоногийн дараа дахин товлож оногдуулах ялыг хэлэлцдэг байна.

Түүнчлэн шүүхэд хэрэг шилжсэн үед гэм буруугийн шүүх хуралдааныг явуулахаас өмнө прокурор, яллагдагч этгээдийг оролцуулсан анхны шүүх хурал болдог бөгөөд энэ хуралд шүүгч оролцохгүй байж мөн болдог байна. Энэ хурлаар яллагдагч этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тэд ялын хэмжээн дээр тохиолцож яллагдагч ялыг зөвшөөрснөөс шүүхийн ажиллагаа шууд дуусгавар болдог байна. Сингапурт ихэнх хэрэг энэ шатанд шийдвэрлэгддэг байна.

## Сургалтын үр дүн, цаашид хэрэгжүүлвэл зохих саналууд:

1. Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөх, түүнд хяналт тавих, эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэн шүүхээр шийдвэрлүүлэх талаарх Сингапур Улсын Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий прокурор, Улсын шүүхийн байгууллагын талаар Мөрдөн шалгах хэлтсийн албан хаагчдад тодорхой ойлголт өгөх зорилгоор сургалтыг АНУ-ын Азийн сантай хамтран зохион байгуулах;
2. Прокурор, шүүхийн байгууллагатай хамтран авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөх, хянах, шийдвэрлэхдээ баримтлах стандартыг

боловсруулан мөрдөх, цаашид бусад Мөрдөн байцаах, прокурор, шүүхийн байгууллагуудтай нэгдсэн сүлжээ байгуулж, харилцан мэдээлэл солилцох ажлыг цахим байдлаар хэрэгжүүлж цаг хугацааг хэмнэх;

3. Авлига, албан тушаалын гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэл, нотлох баримтыг үнэлэх ойлгох, чадамж, итгэл үнэмшил, өөр өөр байгаа тул шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн талаар дэлгэрэнгүй судалгааг хийж, зохих санал боловсруулан Улсын Дээд шүүхэд хүргүүлэн жишиг тогтоосон тайлбар, зөвлөмж гаргуулах;
4. Сингапур Улсын Авлигатай тэмцэх газрын Мөрдөн Шалгах хэлтэст мөрдөн байцаагчаар Санхүүнагтлан бодох чиглэлээр мэргэжилээзэмшсэн санхүүгийн мөрдөгч, компьютер цахим төхөөрөмжийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн комьютерийн тусгай мэргэжилтэн мөрдөгч ажилтнуудыг шалгаруулан авч, тэднийг шалгагдаж буй хэргүүдэд ажлын хэсэгт оруулж авлигын гэмт хэргийн улмаас олсон мэнгийг мөрдөх чиглэлээр санхүүгийн болон банкны гүйлгээний баримтуудад үзлэг хийх, сэжигтэй гүйлгээг олж илрүүлэн үзлэг хийх бэхжүүлэх, цахим төхөөрөмж дэх нуугдмал файлыг илрүүлж үзлэг хийх, устгагдсан болон гэмтсэн файлуудыг сэргээх, цахим шууданд үзлэг хийж бэхжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий мөрдөгч нарыг ажиллуулах;
5. Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын Мөрдөн Шалгах хэлтэст мөрдөн байцаагчаар Санхүүнагтлан бодох чиглэлээр мэргэжилээзэмшсэн санхүүгийн мөрдөгч, компьютер цахим төхөөрөмжийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн комьютерийн тусгай мэргэжилтэн мөрдөгч ажилтнуудыг шалгаруулан авч, тэднийг шалгагдаж буй хэргүүдэд ажлын хэсэгт оруулж авлигын гэмт хэргийн улмаас олсон мэнгийг мөрдөх чиглэлээр санхүүгийн болон банкны гүйлгээний баримтуудад үзлэг хийх, сэжигтэй гүйлгээг олж илрүүлэн үзлэг хийх бэхжүүлэх, цахим төхөөрөмж дэх нуугдмал файлыг илрүүлж үзлэг хийх, устгагдсан болон гэмтсэн файлуудыг сэргээх, цахим шууданд үзлэг хийж бэхжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий мөрдөгч нарыг ажиллуулах;
6. Шинээр боловсруулагдаж байгаа Улс төрийн намуудын тухай хуулийн төсөлд намын гишүүнчлэл, намын санхүүжилт болон бусад заалтуудад тодорхой саналаа гаргаж хууль санаачлагчид хүргүүлэх;
7. Шинээр боловсруулагдаж байгаа гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль болон Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдэд холбогдох саналаа гаргаж хууль санаачлагчид хүргүүлэх;

Илтгэх хуудас бичсэн:

МӨРДӨН ШАЛГАХ ХЭЛТСИЙН  
АХЛАХ МӨРДӨН БАЙЦААГЧ,  
АХЛАХ КОМИССАР

П.БОЛД

МӨРДӨН БАЙЦААГЧ,  
КОМИССАР

Д.ЗОЛЖАРГАЛ

Сургалтын дараах тайлан уулзалтын тэмдэглэл:

## **“АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА” СЭДЭВТ УУЛЗАЛТ СЕМИНАР**

Сингапур Улсын туршлага

Улаанбаатар зочид буудал, Хөх асар танхим  
2014 оны 3-р сарын 24, Даваа гараг

### **ХУРЛЫН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ:**

**А.Баянмөнх, АНУ-ын Азийн сангийн төслийн менежер:**

Илтгэгч нарт баярлалаа, хөтөлбөрийн дагуу шүүхээс авч хэрэгжүүлж байгаа ажлуудын талаар Улсын Дээд шүүхийн шүүгч Д.Эрдэнэбалсүрэн мэдээлэл өгөх болно.

Д.Эрдэнэбалсүрэн, Улсын Дээд шүүхийн шүүгч: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе, би энэ уулзалтад ямар нэгэн илтгэл тавихгүй, ерөнхий мэдээлэл өгөх байгаа. Авлига албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд Азийн сангийн энэхүү асуудлын хүрээнд зохион байгуулж байгаа ажлуудад Дээд шүүх идэвхтэй оролцож ирснийг та бүгд мэдэж байгаа. Өнгөрсөн жилийн хугацаанд зохион байгуулгасан уулзалт, семинар, судалгаанд УДШ идэвхтэй оролцсон.

Дээд шүүхийн хувьд энэхүү сэдвээр юу хийж байгааг танилцуулья. 2011 оны ерөнхий шүүгчийн захирамжаар авлига албан тушаалын гэмт хэргээр дагнан ажиллах 15 шүүгч томилсон байгаа. Эдгээр хүмүүсийг тодорхой сургалтад хамруулж мэргэшүүлсэн юм. Шийдвэрлэсэн хэргүүдийг авч үзвэл эдгээр шүүгчид 2011 оноос 2013 оны хооронд нийт 102 хүнд холбогдох 51 хэргээс 44 хэргийг буюу 80 гаруй % шийдвэрлэсэн гэсэн мэдээ байгаа. Үүнээс үүдээд эдгээр шүүгч нарыг мэргэшүүлж авлига албан тушаалын хэргээр дагнан ажиллуулсан нь зохих үр дүнгээ өгсөн гэж бодож байна. Нөгөөтэйгүүр шүүгч нарыг нэр цохood энэ шүүн таслах ажлыг зохицуул гэх нь бас одоогийн шинэчлэлийн хуулийн агуулгаар харахаар зарим талаар бэрхшээлтэй талууд ажиглагдаж байгаа. Тухайлбал, энэ эрх зүйн шинэтгэлтэй холбогдоод шүүгч нарын шилжилт хөдөлгөөн нилээн өндөр байгаагаас харахад эдгээр 15 шүүгчийн 6 нь анхан шатны шүүхэд ажиллахаа болжсон, албан тушаал өөрчлөгдсөн, өөр ажилд шилжсэн. Тэгэхээр нөгөө захирамжин дээрээ нэрийг нь өөрчлөөд явах бас практик талаасаа бэрхшээлтэй байгаа. Нөгөөтэйгүүр, шүүхийн шинэчлэсэн хуулийн дагуу хууль зүйн агуулгын хувьд бол шүүгчийн хараат бус байдлын талаар бол бүх хуульч, шүүгч нар мэдэж байгаа, ялангуяа шүүхийн дотоод хараат бус байдлын талаар ерөнхий шүүгч нарын хоорондын харилцааны талаар бол тодорхой зохицуулалт орсон

байгаа. Тухайлбал, ерөнхий шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шүүн таслах ажиллагаандaa шүүгч нарын ажилд нөлөөлөх, нэр зааж хэрэг хуваарилах энэ талаар зөвлөгөө өгөх гэсэн зүйлийг хязгаарласан, энэ заалтын агуулга шинж чанартай зөрчилдсөн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг цаашид авч хэрэгжүүлэх. Хамгийн гол нь сүүлийн жилүүдэд авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэхэд ахиц гарж байгаа, авлигын талаарх индекс, пунктууд буурч байгаа зэрэг бол амжилттай ажиллаж байгаа. Энэ нь хууль сахиулах байгууллага, авлигатай тэмцэх мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны үр дүнтэй ажиллагаа гэж хэлж болно.

Ерөнхий утгаар харахад бол яг суурь хуулийн өөрчлөлт буюу эрүүгийн хуулийн өөрчлөлтгүйгээр урт хугацаанд үр дүнтэй тэмцэж чадна гэдэг дээр бол логикийн хувьд зөрчилтэй байгаа. УДШ-ээс юун дээр анхаарч байна гэхээр тодорхой төрлийн хэргийг шийдвэрлэх талаар амжилт гаргахын тулд эрх зүйн хуулийн өөрчлөлт буюу /criminal justice reform/ эрүүгийн эрх зүйн системийн шинэчлэл тогтолцоог бүхлээр шинэчлэх асуудал яригдаж байгаа. Үүнд ихээхэн ач холбогдол өгч байгаа. Хууль зүйн яамнаас боловсруулж байгаа хуулийн төсөлд УДШ урьд өмнөхөөс илүү анхаарал хандуулж идэвхтэй ажиллаж байгаа. Мөн дээд шүүхийн эрүүгийн танхим дээр энэхүү төслүүдийг хэлэлцэж, санал нэгтгэж энэ тал дээр нилээн идэвхтэй ажиллаж байгаа. Яагаад энэ талаар нуршаад байна вэ гэхээр өмнө энэ авлигатай тэмцэх талаар үр дүн гаргахын тулд өмнө нь хийсэн судалгаан дээр гарсан бэрхшээлтэй зүйлүүдийг шийдвэрлэх гол арга замуудын шинэчлэлийн хуулийн төсөл, энэний үзэл баримтлал дээр бол нилээн ярьж байгаа. Гэмт хэргийн тухай хууль дээр бол авлига албан тушаалын гэмт хэргийг томьёолоход бол АТГ-ын саналыг нилээн харгалзсан. Сая хүмүүс ярьсан байцаан шийтгэх ажиллагааны өөрчлөлт бол нилээн тулгуур шинж чанартай.

Судалгааны дунд яригдсан шүүн таслах ажиллагаанд хууль хэрэглэх талаар гарч байгаа алдаа дутагдлыг суурь хуулийн шинэчлэлээр бүгдийг шийдвэрлэх боломжтой болж байгаа. Шүүх дээр нэгэнт эрүүгийн хэрэг ирсэн бол шүүхээс эцэслэн шийдвэрлэдэг энэ чиглэлээр өөрчлөлт хийгдэнэ, тэгэхээр хэрэг удааширдаг, мөрдөн байцаалтад буцдаг гэсэн асуудлууд ерөнхийдөө байхгүй болно гэсэн төсөөлөл байгаа. Хууль хэрэглээний асуудлаар бол шүүхийн тухай хууль, байцаан шийдвэрлэх хуулийн өөрчлөлт бас нилээн яригдана. Хамгийн гол нь улсын дээд шүүх тодорхой хэргийг шийдвэрлэх явцад жишиг шийдвэр гарч байгаа, энэ шийдвэрээ бол анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх явцад бол нэгдсэн байдлаар хэрэглэх жишгийг хэрэгжүүлэх нь дээд шүүхийн ажиллагааны үндсэн чиглэл байх болно гэсэн ийм товч санаа хэлэх гэсэн юм. Баярлалаа

**А.Баянмөнх:** Баярлалаа, Азийн сангийн зүгээс “Монгол улсад Авлигатай тэмцэхэд дэмжлэг үзүүлэх” төслийг 2006 оноос 2011 он хүртэл хэрэгжүүлсэн. Тухайн үед АТГ-аас хэдэн хэрэг мөрдөн шалгаад, хэдэн шийдэгдэж байгаа талаар зөвшөөрөгдсөн мэдээлэл аваад ажиллаж байсан. Эндээс харахад багагүй хэрэг хэрэгсэхгүй болдог, байгууллагууд хоорондоо ойлголцлоггүй, зүйлчлэл өөр

өөр байдаг. Яг адилхан хэрэг хийчээд байхад өөр өөр шийтгэл авсан байх тохиолдууд нилээн гардаг гэж харагдаж байсан. Үүнээс үндэслээд ер нь энэ З байгууллагууд хоорондоо маш сайн ойлголцдог байх хэрэгтэй юм байна, энэ дээр юу хийж болох вэ гээд албан бус ажлын хэсэг 2 ч удаа байгуулсан. Өмнөх төсөл дуусахын өмнөхөн УДШ-ийн Эрдэнэчuluун дарга ахлаад ажлын хэсэг байгуулаад хэд хэд уулзаж байсан. “Засаглал ил тод байдлыг дэмжих” АНУ-ын ОУХА-н санхүүжилттэй энэ төслийн хүрээнд ажлын хэсэг дахин байгуулаад 2 дахь уулзалтан дээрээ бид энэ судалгааг хийхээр тохирсон. Тэгээд өнгөрсөн хавар, зун судлаач Галдаа ахлаад З хүний бүрэлдэхүүнтэй энэхүү судалгааг хийсэн байгаа. Гарсан зөвлөмжийг 4 байгууллагын удирдлагуудад албан ёсоор хүргүүлсэн. Зарим байгууллагуудаас тодорхой саналууд ирсэн. Судалгааны дүнг нарийвчилсан байдлаар өнгөрсөн 9 сард танилцуулсан.

Бидний Сингапур улсад хийсэн аялал бол Сингапур хэрхэн авлигатай амжилттай тэмцэж чадаж байгаатай танилцах байсан. Энэхүү сургалтыг бид 2 дахь удаагаа зохион байгууллаа. Эхний удаад 16 шүүгч нараас 8 шүүгч нар яг ижил сургалтад хамрагдсан юм. Сая Эрдэнэбалсурэн шүүгчийн хэлснээс хархад эдгээр шүүгч нар маань үр дүнтэй сайн ажилласан гэсэн мэдээлэл авлаа. 2 дахь удаагийн Сингапурын сургалтад оролцогчдын хувьд өнөөдөр сурч мэдсэн зүйлээ та бүхэнтэй хуваалцлаа. Та бүхнийг чөлөөтэй санал бодлоо солилцоосой гэж хүсэж байна.

**Э.Амарбат, АТГ, Мөрдөн шалгах албаны дарга:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Яригдсан асуудалтай холбоотой саналаа хэлье, саналаас гадна манай байгууллагатай холбогдолтой товч мэдээлэл өгье. Сингапур улсын авлигатай тэмцэх тогтолцоо, байгууллагуудын хэрэгжүүлж буй ажлыг сонсоход бол манайд үгүйлэгдэж буй зохицуулалт гэхээр юм бараг байхгүй байх шиг байна. Харьцангуй бас эрх зүйн зохицуулалтын хувьд нилээн гайгүй тусгаад өгсөн ч хэрэгжих процессын хувьд арга, хандлага нь арай өөр байгаад асуудлын гол нь байгаа байх гэж би хардаг. Тиймээс бид асуудлыг өөр дээрээ тусгаж авч үйл ажиллагаандаа анхаарах ёстой юм болов уу гэж бодож байна.

Сингапурын Чуа Чер Як гээд Авлигатай тэмцэх газрын даргаар ажиллаж байсан энэ хүнтэй уулзахад ярьж хэлж байсан хураангуйг нь бидэнд бас тараагаад өгсөн байна, үүнээс харахад бид гол нь өөрсдийнхөө хандлагыг өөрчлөх хэрэгтэй юм байна гэж харагдаж байна. Зарим нэг жишээ хэлье. Манай дээр шалгасан зарим хэргүүд үнэхээр шийдэгдэггүй уддаг, үл ойлгогдох байдлаар шийдэгддэг, хэрхэн шийдэгдсэн нь мэдэгддэгүй ийм нөхцөл байдал байгаад л байгаа.

Аль 2010 онд Замын-Үүдийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бараа, уг барааг хилээр нэвтрүүлэхдээ гаалийн болон мэргэжлийн хяналтын байцаагч нарт хахууль өгж байсан тов тодорхой хэрэг одоо хүртэл шийдэгдэхгүй бүтэн 4 жил болж байгаа, одоог болтол шийдэгдээгүй шүүх дээр байгаа сургтай. Энэ хооронд тэр хэрэг прокурор дээр нэг, хоёр жил дарагдсан юмнууд ч байдаг. Яасан гэхээр мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, шийдээгүй байсан байна гээд

сум дундын прокурор дээр гацаасан, аймаг дундын прокурорын газар мэдэхгүй сууж байх жишээтэй.

Газар орон нутгийн байдал бас нөлөөлдөг. Жишээ нь Замын-Үүдэд оршин суудаг иргэдийн нийт 80-90 % нь ачаа тээврийн үйл ажиллагаа явуулж ахуйгаа залгуулж байдаг бусад нь төрийн албан хаагчид байдаг, ямар нэгэн үйлдвэрлэл явуулдаг тийм юм бол байхгүй. Тэр утгаараа тэдгээр гаалийн байцаагч нарыг мэдээлдэг, ховлодог, төрийн байгууллагатай хамтарч ажилладаг тийм ойлголт бол байхгүй, яагаад гэвэл ахуйгасаа салчих гээд байдаг. Тэнд ажиллаж амьдарч байгаа шүүгч прокурорын маань шийдвэрлэж чаддагүй удаадаг байна. Хилээр оруулсан тэр зүйл нь бол химиин хортой бодис байгаа. Химиин хортой бодис нь хүлээн авагч компанид 4 жил битүүмжлэгдсэн байгаа, нөгөө бодис нь шороо болсон, ашиглалтын хугацаа нь дууссан, нөгөө байгууллага нь одоо бид нар хэнтэй хариуцлага тооцох вэ гэдэг. Тэр байгууллага нь манай дээр ирээд бид хохиролоо хэнээр барагдуулах юм бэ гэдэг. Танай байгууллага очиж битүүмжилсэн танай байгууллагатай ярих юм уу, шийдэж чаддаггүй шүүх, прокурорынхонд ярих уу гээд явдаг. Үнэндээ бараг энэ асуудлыг одоо шийдэх нь ач холбогдолгүй болчихсон.

Хамгийн сүүлийн жишээг хэлэхэд, саяхан Нийслэлийн гааль дээр солонгосоос 1000 хос гутал солонгос хүний нэр дээр билүү орж ирсэн байгаа, татвараа төлөөгүй гараад явсан. Гарахын тулд гаалийн байцаагч нарт хахууль өгсөн. Манайд байгаа мэдээллийн дагуу шалгахаар тэр 1000 хос гутлыг хууль бусаар оруулж ирсэн, гаалийн байцаагч нартай ойрхон харилцаанд орсон гэдэг нь утас холбоо харилцаагаар тогтоогдсон, гаалийн байцаагч нарт хахууль өгсөн дансаар шилжүүлсэн гэдэг нь тогтоогдсон, хахууль өгсөн гэдэг бүх уялдаа холбоогоор тогтоогдсон. Манайхаас гарцаа байхгүй хахууль авсан байнаа гээд шилжүүлсэн, гэтэл хэрэг яж шийдэгдсэн нь бид нарт мэдэгдэхгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгосон байх жишээтэй.

Хэрэгсэхгүй болгосон асуудлаа бид мэддэггүй, прокурор дээр хэргийг хэрэгсэхгүй болгосон л бол дараа дараагийн арга хэмжээг авдаггүй, хэрэгсэхгүй болгосноо бидэнд мэдэгддэггүй болохоор бид цаашаа нөгөө байгууллага албан тушаалтан хариуцлага тооцож чаддаггүй. Бидний өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд байгаа юм болов уу гэж бодож байна. Сүүлийн үед бол шүүх асуудлуудыг сайн шийдвэрлэж байгаа, олны анхаарал татсан, хохирол ихтэй, олон хэргүүдийг манай шүүхүүд шийдэж чадаж байгаа. Цаашдаа ч мөн нилээн ахицтай, нийгэмд хүрсэн ийм шийдвэрүүд гарах байх гэж бодож байна. Манай байгууллагын хувьд бол оны эхэнд хууль хяналтын байгууллагуудын албан хаагчдын үйлдсэн авлигын гэмт хэргийг хянан шалгах харьяаллыг бидэнд өгсөнд бид талархалтай байгаа. Хууль тогтоох эрх бүхий субъектууд нь энэ байдлаа илэрхийлж байгаа. Транспэренси Интэрнэйшлээс гаргадаг авлигын индексийг бид энэ оны сүүл гэхэд бид илүү ахиулах болно гээд амлалт аваад байгаа.

Миний хэлэх гэж буй санаа бол бидэнд хууль хангалттай байгаа, илүү боловсронгуй болж байгаа, үйл ажиллагаандаа илүү анхаарах ёстой юм биш үү. Энэ талаар байгууллагууд санаачлагатай байж, харилцан мэдээлэл солилцож, нягт ажиллавал илүү үр дүнтэй байх болов уу. Баярлалаа.

**Б.Галдаа:** Өнөөдрийн уулзалтад оролцож байгаадаа таатай байна. Чухал сэдэв хөндөж байна гэж бодож байна. Сингапурын сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнийг харахад бол яг энэ ажлын гогцоог барьж ажилладаг муу талаасаа ярихын бол санал зөрөлддөг, бие биенээсээ алдаагаа хайдаг энэ субъектууд явж газар дээр нь Азийн бар орны туршлагаас суралцаж ирсэн нь сайхан санагдаж байна. Нөхдийн ярьж байгаатай санал нэг байна. Азийн сангийн шугамаар хуулийн байгууллагуудын захиалгаар судалгаа хийж үзсэн юм. Судалгааны хүрээнд яг бодит хэргүүд дээр судалгаа хийсэн. Гэхдээ тэр талаар би ярихгээгүй л дээ, Сингапурын туршлагад яригдаад байгаа энэ зүйл маань тэр дотор нилээн хэдэн зүйлс нь тусгалаа олсон юм байна гэж олзуурхаж байна. Тэгэхээр явсан хүмүүсийн яриад байгаа арга туршлагыг Монгол орныхоо нутаг дэвсгэр дээр хэрхэн яж нутагшуулах вэ?, гарж байгаа алдаа оноон дээр холбож ямар арга замаар үр дүнд хүрэх вэ? Эцсийн эцэст, үр дүнтэй байх нь энд байгаа энэ ажлын хянадаг, шалгадаг, шийдвэрлэдэг эдгээр субъектуудын ажиллагаа, явж явж тэдний хүсэл зорилгын нэгдэл гээд байна, улс төрийнхны хүсэл зорилгыг та бүхэн даа� явах хэрэгтэй. Мөн бид өөрсдөө сэтгэлгээний асар том өөрчлөлт хийж байж Сингапурын хэмжээнд очих боломж байгаа байх л даа. Би сая ажиглалаа 1952 оноос эхэлсэн юм байна, хөгжөөд 50-ад жил болж байгаа. Монголын АТГ байгуулгдаад 10 хүрэхгүй жил болж байна, тэр улсын амжилтад хүрнэ хэмээн зорьж ажиллавал үнэхээр олзуурхам. Мөн Сингапурын туршлагын түүхээс илүүг олж мэдээд манай хөрсөнд буулгахад үүнийг анхаарах хэрэгтэй ийм гарц байна гэдгийг гаргасан бол надад үнэхээр таатай байх байлаа.

Нөгөөтэйгүүр, бид том юм луу шуураад байна, авлигын жижиг асуудал бас байсаар байгаа, жижиг юмнаас ч гэсэн айн шүү дээ, жижиг юмнаас том юм гардаг, жижиг зөрчлөөс том хэрэг үүсдэг энэ тал руу анхаарал хандуулах ёстой гэж бодож байна. Яагаад гэвэл, бид зөвхөн эрүүгийн эрх зүйн хүрээнд биш, салбар эрх зүйн механизмуудыг ашигламаар байна, эрх зүйн орчингоо зохицуулах ёстой гэж байгаа юм.

Зөвлөмж, аргачлалын хувьд хуулийн байгууллагуудын удирдлагууд анхааралдаа авмаар байна. Нэг ойлголттой болмоор байна, арга ядахдаа мөрдөн шалгах хэлтсийхэн дээд шүүхийн орчуулж гаргасан номыг тайлбар болгоод өгөөчээ гэж хүссэн байна, арга ядсан арга байна шүү дээ, энэ нь бас л нэг хүний үзэл бодол явж байгаа. Мэдээж УДШ хэзээ ч албан ёсны тайлбар шүү гэж баталгаажуулахгүй, тэгэхээр энэ тал дээр нэгдсэн ойлголттой болох хэрэгтэй. Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нарыг хамруулсан тодорхой нэг хэрэг дээр сургалт уулзалт хийх хэрэгтэй тодорхой тодорхой хугацаанд, ингэвэл арай нэг цэгцрэнэ.

Хэрэг асуудлыг шуурхай шийддэг байх хэрэгтэй байна, удах тусам нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдөг, үүнээс салмаар байна. Шалгадаг газар нь

шалгадаг, хянадаг газар нь хянадаг, шийдвэрлэдэг газар нь шийдвэрлэдэг байх хэрэгтэй. Та бидний нэгдсэн ажиллагааны үр дүн байх ёстой. Өнөөдөр бүх З байгууллагын төлөөлөл байна.

Иргэн гэдэг талаас нь хүлээж аваасай иргэний үүднээс хэлж байгаа юм шүү. Энэ зөвлөмжийг базаад асуудал боловсруулах хэрэгтэй.

**А.Баянмөнх:** Өөр санал хэлэх, асуулт хүн байна уу? АТГ болон прокурорын байгууллагын төлөөллөөс асуумаар санагдлаа. Би Сингапурын сургалтад бас хамрагдсан. Түрүүн илтгэгч нар маань бас дурдлаа 4A гээд эхний З нь бол ойлгомжтой байлаа, дөрөвдөх нь бол Захиргааны чиглэлээр авлигаас урьдчилан сэргийлэх гэдгээ хэлдэг юм байна лээ. Та бүгдэд тараасан материал дээр байгаа, 70, 80-ад онд Сингапур төрийн албатай маш сайн тулж ажилласан, тэрнээс хойш төрийн алба маань маш сайн цэвэрлэгдсэн. Төрийн албаны төлөө яг ажиллах хүсэл эрмэлзэлтэй шударга хүмүүс үлддэг юм гэж багш хэлж байсан. Багш маань өөрөө бас 50,60-аад оноос хойш замын цагдаагаас авахуулаад төрийг алба хашсан. Тэгэхлээр 2 байгууллагаас юу гэж асуух гээд байна вэ? гэхээр хэрэг эрүүгийн болохгүй байгаа асуудлаа аа захиргааны байгууллагуудруу тавьж чаддаг юм байна лээ. Жагсаалтаар нь гаргаад ерөнхий сайддаа өгдөг прокурор нь энийгээ хийдэг гэж би ойлгосон. Манайд ийм зохион байгуулалт байна уу эсвэл хэрэг болгож чадахгүй болхоороо орхичноод байна уу. Ийм боломж манайд хэр байдаг юм бол?

**О.Гэрэл, Нийслэлийн прокурорын газар, хяналтын прокурор:** Энэ бол яг анхаарах гол зүйлүүдийн нэг байгаа. Прокурорын байгууллага дээр бол тухайн хэрэг, үйлдэл, мэдээлэл гэмт хэргийн шинжтэй гомдлыг шалгаад эрүүгийн хэрэг үүсгэх боломжгүй ч гэдгиймуу, гэмт хэргийн бүрэлдхүүнгүй байнаа гэдэгталаасаа хэргийг шийдвэрлэдэг. Энэ тохиолдолд манай талаас тухайн байгууллага руу мэдэгдэл бичдэг, гэхдээ үлэмж хэмжээний хохирол учруулаагүй гэдэг үүднээс тухайн хэрэг хэрэгсэхгүй болдог. Ийм ийм улмаас гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байгаа учир хэрэгсэхгүй болгон шийдвэрлэлээ гээд мэдэгдэл бичиж байгаа. Түрүү нь хүмүүсийн ярьсан дээр хэлэхэд эрүүгийн хэрэг үүсгэхээр хохирол учруулаагүй ч түүнээс доош хэмжээний хохирол учраад байгаа тохиолдолд иргэний журмаар нэхэмжлэл гаргахыг зааж өгвөл дээр юм биш үү гэдэг асуудлыг ярьж байна лээ. Энэ бол бас үнэхээр хэрэгжүүлбэл зохих асуудлын нэг гэж үзэж байна.

Төрийн байгууллагуудтай холбоотойгоор манайхаас авсан мэдэгдлийн хариуг хуулиаараа 30 хоногийн дотор өгөх ёстой байдаг боловч зарим байгууллагуудын хувьд удирдлагууд солигдсонтой холбоотойгоор хойшлогдоод, цаашаа нийтэд энэ талын мэдээлэл хүрч чадахгүй байгаа.

**Э.Амарбат:** Манайх яаж байгаа вэ гэхээр, авлигатай тэмцэе, үр дүнд хүрчье гэсэн цээжиндээ тийм хүсэл зорилготой хүмүүс байгаад байх шиг юм. Зарим ажлаа гүйцэд хийж чадахгүй байгаа ч юм байгаад байх шиг байна. Өнгөрсөн онуудад байнга л авч байсан арга хэмжээний нэг нь энэ зөрчлийг арилгуулья, зөрчил гаргасан хүнд хариуцлага тооцуулья тэгсэн хэрнээ сая өнгөрсөн оны

Энэ чиглэлээр дотооддоо хийсэн ажлыг дүгнэхэд бас сайн уялдаж чадаагүй гэсэн үнэлгээ гарч байна лээ. Энэ оны хувьд энэ асуудал дээр нилээн анхаарч ажиллахаар байгаа. Боломжийн хувьд бол манай хувьд нилээн боломж харагдаад байгаа юм. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг хянаж үзээд бүрэлдэхүүнгүй гэж үзээд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзахын хажуугаар материалын бүгдийг нь хяналт дун шинжилгээний хэлтэс рүү шилжүүлээд давхар хянуулаад явж байгаа юм. 60 хоногийн дотор зөрчлийн асуудлыг хянаад үзчих давхар тийм боломж байгаад байгаа.

Ганц гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй гэхээс илүү ашиг сонирхлын зөрчилтэй, сонирхлын хуулийг зөрчсөн ч гэдэг юмуу ийм үйлдэл дээр давхар хариуцлага тооцуулахаар энэ нэгжээрээ дамжаад арга хэмжээ аваад улмаар авагдсан арга хэмжээний нийт тоонд судалгаа шинжилгээний хэлтсээр дун шинжилгээ хийлгээд үнэхээр ажил хийгдэж үү? гэдгийг урьдчилан сэргийлэх нэгжээр давхар шалгуулаад ингээд нэг иймэрхүү уялдаа холбоотой ажилладаг больё гэж энэ оноос яриад хэрэгжүүлээд явж байгаа.

Мөн прокурортой адил мөрдөн байцаагчийн мэдэгдэл бичээд шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авч байгаа. Энэ жил манай ажилтнууд бүх сумдуудаар явж урьдчилан сэргийлэх ажиллагаа хийж байгаа. Гайгүй үр дун гарах байх.

Бусад хуулийн байгууллагууд энэ чиглэлээр манайхтай хамтраад явбал бас үр дүнтэй юм болов уу, ялангуяа прокурор түрүүчийн бичсэн мэдэгдэлийн дагуу манайхтай хамтраад дүгнэлт хийдэг, шалгадаг ч юмуу, арай илүү амьд харилцаатай болвол илүү сайжрах байх гэж бодож байна.

**Н.Бадамцэцэг:** Хүмүүсийн хэлсэнтэй санал нэг байна. Гэхдээ Сингапурт явж ирсэн туршлагатай холбож үзэх юм бол жижиг байсан ч авлигын шинжтэй гэж шалгадаг, гэмт хэрэг нь нотлогдохгүй тохиолдолд төрийн албан хаагч гэм буруутай л бол заавал хариуцлага хүлээдэг ийм зарчмыг барьж ажиллаж чаддаг учраас төрийн албаны зөвлөл нь хариуцлага тооцдог байна. Манайд бол авлигыг ямар түвшинд авч үзээд байгаагаас шалтгаалаад ялгаа гарч ирээд байгаа. Сингапурт эрх зүйн соёлыг маш багаас нь тавьж өгдөг, манайд өндөр түвшинөөс ярьдаг, учруулсан хохирлоор нь эсхүл өндөр албан тушаалаар нь авлигын гэмт хэргийн субъект болдог. Харьцуулаад үзвэл эрс тэс ялгаатай асуудлууд байгаа.

**Б.Галдаа:** Би нэг зүйл нэмэх гэсэн юм. Үнэхээр авлигатай тэмцие гэж байгаа бол, түүний гарч буй шалтгаан нөхцлийг арилгуулах ямар нэгэн хэмжээгээр нөлөөлсөн албан тушаалтан, тэр хүмүүст гарцаагүй хариуцлагын механизм хэрэгтэй л дээ. Судалгаа хийж байхад нэг сонин юм харагдсан, нэг мэдэгдэл дээр Эрдэнэтийн захирал Ганзоригт мэдэгдэл бичсэн байсан юм. Уг мэдэгдэл бол их хууль зүйн агуулгатай, хэлбэрт нь тохирсон, нөхцөл байдал, хууль заалт, бүртгэл тооцоо гээд бүгдийг хийсэн байна лээ. Би тэрийг их сайхан мэдэгдэл болсон гэж үзсэн гэтэл ирсэн хариуд таны илгээсэн мэдэгдэлийг би албаддаа

танилцууллаа гэсэн байсан, ерөөсөө л энэ. Энэ хүмүүст авлигатай тэмцэх тэр хүсэл зорилго байна уу? Ийм хүсэл алга, ийм нөхцөлд бол ахиц гарна гэж бол байхгүй. Тэгэхээр би юу гэх гээд байна гэхээр ийм хариу өгөөгүй хэлбэрдсэн хүмүүст хариуцлага тооцдог болгох ёстой байхгүй юу. Мөн гэм буруутай л бол жижиг ч бай тохирсон хэмжээний хариуцлага тооцдог л болох хэрэгтэй. Тэгж байж бид хариуцлага тооцдог механизмуу орно. Сингапурт албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэг гэж байдаггүй юм байна гэж ярьсан тэрнийг өөр юугаар орлуулдаг юм бол гэсэн асуулт байна.

**Ц.Туул:** Мэдээлэл өгсөн хүмүүстээ баярлалаа. Хийсэн судалгаатай танилцаа, их боломжийн хийсэн, хийж хэрэгжүүлэх зүйл бас нилээн байна гэж харлаа. Авлигатай тэмцэх энэ асуудал бол хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоотой чухал. Хэдийгээр АТГ-н мөрдөн шалгасан хэргүүдэд хяналт тавьдаггүй ч гэсэн, шүүхээс буцдаг хэргүүдийг байнга уншдагийн хувьд манай байгууллагуудын уялдаа холбоо маш муу байна, хэдэн тийшээ харсан байна, гол асуудлуудаа зангидач чадахгүй байна. Хууль тогтоомжинд өөрчлөлт орохгүй бол авлигатай тэмцэх асуудал энэ байдаараа л байгаад байна, ямар ч эрх зүйн байхгүй байгаад байна. Мөн мэргэшсэн шүүгч прокурорууд байх ёстой. Мөрдөн байцаагч нарын хувьд шалгаж байгаа хэргүүд маш хүнд санхүү, нягтлан бүртгэл, татвар, гаалийн мэдлэг байнга шаарддаг. Прокурорын хувьд гэвэл прокуроруудаа мэргэшүүлэх шинэтгэлийн зүйлүүд гээд байгаа.

Дараагийн асуудлын хувьд бол манай Гэрэл прокурор дэлгэрэнгүй тайлбарлаачих шиг боллоо. Баянмөнх чухал асуулт асуулаа, захиргааны байгууллагууд руу чиглэх ёстой байхгүй юу, Сингапурын туршлагаас хархад бол 4Агийн нэг нь захиргааны байгууллага руу чиглэсэн юм байна, ингэж байж тэр байгууллага дээр ямар нэгэн зөрчил гарахгүй байх гэсэн юм харагдаад байна. Илтгэгч нартаа баярлалаа.

**П.Болд:** Галдаа прокурорын асуултанд хариулья. АТГ дээр хийсэн уулзалтын үеэр тодорхой хэмжээний сургалт танилцуулга хийгдсэн, энэ үеэр манай багийн зүгээс асуусан асуулт гэвэл албан тушаалтан авлигын гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд танай байгууллага хэрхэн ажиллаж байна вэ? Гэсэн асуулт тэдний авлигын хэргийг мөрдөн шалгах товчоо нь зөвхөн авлига буюу хээл хахуулийн гэмт хэргийг мөрдөн шалгадаг, албан тушаалаа урвуулсан, хэтрүүлсэн хэргийг цагдаагийн байгууллага нь шалгадаг гэсэн мэдээлэл өгсөн энэ талаар өөр өгөх мэдээлэл бидэнд алга аа хэмээн хариулсан. Харин авлигын үйлдлийг нилээн задалж үздэг, авлига өгсөн авснаар зогсохгүй авлига өгөхийг шаардсан, амласан, хөнгөлөлт үзүүлсэн, шагнал урамшуулал өгсөн, өмнөөс нь төлбөрийн хаасан, зээл олгосон, зээлийн хөнгөлөлт үзүүлсэн, бэлгийн буюу секс үйлчилгээ авсан буюу үзүүлснийг хүртэл авлига гэж үзэж шийдвэрлэдэг ийм юм билээ. Үүнийгээ авлигын хуулиндаа илүү дэлгэрэнгүй заагаад өгсөн байдаг юм билээ.

**Оролцогч:** Сингапур улсын хувьд бол хүн амын хувьд манайхтай ойролцоо юм шиг сонсогдлоо. Миний хувьд авлигыг танил талаасаа эхэлдэг байх гэж боддог л доо, тэгэхээр Сингапур улсад яг үүнийг зохицуулсан хууль байдаг юм болов уу гэж асуух гэсэн юм.

**П.Болд:** Анхнаасаа Сингапур улс маш их тэмцэл явуулсан, энэ хүчтэй тэмцлийн үр дүнд гол нь шударга байх гэдэг зарчмыг бариад явсан, төрийн албан хаагч шударга байх ёстой гэдэг зүйлийг ухамсарласан байдаг. Жишээ нь, төрийн алба хашиж байгаа хүний нэр дээр байдаг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоодог байгаа, манайд бол одоо гэр булийн гишүүний нэр дээр шилжүүлдэг бол, Сингапурт бүгд зогсоодог. Парламентын гишүүдийн хувьд бол хувийн компани, нэгжийн талаар байнга олон нийтэд мэдээлж байдаг, хэрэв ямар нэгэн тэндерт давуу байдал олж авсан бол үйл ажиллагааг нь зогсоодог, ийм зохицуулалттай юм билээ.

**А.Баянмөнх:** Улс төрийн хүсэл зориг гэж багш маань зөндөө ярисан л даа түрүүн хүмүүс маань бас дурьдлаа, тэгхээр үүнийг улс төрчийн хүсэл зориг гэж битгий ойлгоосой гэж хүсье. Нэг юм сонирхуулж хэлэхэд сургалтын үеэр бид Сингапурын Ардын үйл хэргийн намын байраар очсон. Ардын намын байр нь хотоос нилээн зйттай, 4 давхар хуучны байр байдаг юм билээ. Намын нарийн бичиг нь биднийг утгаж авсан манай нам анхнаасаа эд хөрөнгөгүй байх зарчимтай, энэ байрыг бол ТББ-аас түрээслэж суудаг юм аа гэж хэлсэн. Анхныхаа хурлаар л бид цэвэр гэдгээ харуулнаа гээд цагаан хувцас өмсөж байсан юм билээ. Өнөөдрийг хүртэл ардын намын гишүүд нь цагаан хувцастай байгаа юм билээ. Авлигатай тэмцэх хүсэл зорилго нь шууд харагдахуйц, мэдрэгдэхүйц байдаг юм билээ.

**П.Болд:** Нэмээд юм хэлэхэд, Сингапур нь 32 улс төрийн намтай, эндээс яг парламентад суудалтай нь 16 нам, ардын нам нь бол дийлэнх суудлын авсан, 60-аад жил төр засгийн эрхийг бариад явж байгаа. Улс төрийн намын тухай хуулиараа бол нам өмчтэй байна өмчгүй байна гэсэн заалт бол байхгүй, гэхдээ ардын удирдлагууд бол анхнаасаа өмчтэй больё гэж бодоогүй, улс төрийн нам бол улс төрийн үйл ажиллагаа л явуулах ёстой, түүнээс өмч цуглуулж бизнес хийх ёсгүй гэсэн тайлбар тавьж байсан. Мөн 16 намиас нэг нам нь л өөрийн гэсэн өмчтэй юм билээ.

**Ц.Амаргэрэл, Улсын дээд шүүхийн эрүүгийн танхимиын шүүгчийн туслах:** Сайн байцгаана уу, би өөрт тохиолдсон явдлаасаа ярья гэж бодлоо. Түрүүн хэллээ л дээ жижиг шан харамж, хээл хахуулийг тоохгүй бол цаашид том авлига хээл хахуулийн үндэс суурь болдог гэж. Надад нэг ийм зүйл тохиолдлоолдоо. Мартын 8-ны маргааш нь манай хүүхэд цэцэрлэг рүүгээ явахдаа ээжээ та манай багшид бэлэг авахгүй яасан юм бэ гээд уйлсан. Эндээс харахаар цэцэрлэгийн насны хүүхдийн сэтгэхүйд ямар юм шингэсэн байна, тэндээс нь бид ажиллаж эхлэх ёстой юм болов уу? Багаасаа ингэж байгаа юм чинь ямар хүн болж төлөвших үү гэж санаа зовж байлаа. Сингапурын туршлагаас харахад жижиг гэлтгүй юмыг анхаарч багаас нь төлөвшүүлж өгөх хэрэгтэй байх гэж бодож байна. Үүнийг анхаарах хэрэгтэй байх гэсэн санал хэлж байна.

**А.Баянмөнх:** За баярлалаа, Азийн сангийн зүгээс бол байгууллагуудтай байнга холбоотой байж хэрэгжүүлэх боломжтой ажлуудад хамтран ажиллах болно. Өнөөдрийн уулзалтын материалыг та бүгдэд имэйлээр явуулах болно. Та бүгдэд баярлалаа.

## АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ (БҮЛЭГ 241)

(Анх баталсан: 1960 оны 39 дүгээр шийдвэр)

### 1993 ОНЫ ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

(1993 оны 3 дугаар сарын 15)

Авлигын гэмт хэргээс илүү үр дүнтэй урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн хууль

[1960 оны 6-р сарын 17]

### I ХЭСЭГ ЕРӨНХИЙ ЗААЛТУУД

#### 1. Хуулийн товч нэр

Энэхүү хуулийг Авлигаас урьдчилан сэргийлэх хууль гэж нэрлэж болно.

#### 2. Тайлбар

Агуулга нь өөрөөр ойлгохыг шаардаснаас бусад тохиолдолд энэхүү хуульд дараах үсийг дор дурдсан байдлаар ойлгоно:

“агент буюу төлөөлөх этгээд” гэдгийг бусдад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг эсвэл бусдыг төлөөлдөг этгээд, үүнд итгэмжлэгдсэн этгээд, үүрэг биелүүлэгч болон гүйцэтгэгч, түүнчлэн Засгийн газрын ажилтан эсвэл аливаа корпораци эсвэл нийтийн үйлчилгээний байгууллагын ажилтан гэж ойлгоно. Мөн энэхүү хуулийн 8 дугаар зүйлийн хүрээнд агент гэдэгт туслах гэрээт гүйцэтгэгч болон туслах гүйцэтгэгчийн ажилтан эсвэл төлөөлөгчийг хамруулж ойлгоно;

“АХМТ-ны албан хаагч” гэдгийг Авлигын хэргийг мөрдөх албаны энгийн болон ахлах албаны албан хаагч гэж ойлгоно;

“Дарга” гэдгийг энэхүү хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу Авлигын хэргийг мөрдөх товчооны даргаар томилогдсон этгээд гэж ойлгоно;

“шан харамж” гэдэгт дараах зүйлс хамаарна:

(а) Мөнгө эсвэл аливаа бэлэг сэлт, зээл, хураамж, шагнал, шимтгэл, үнэт цаас эсвэл бусад эд хөрөнгө эсвэл аливаа төрлийн хөдлөх эсвэл үл хөдлөх хөрөнгийн хувь эзэмшил;

(б) Аливаа албан тушаал, ажил эсвэл гэрээ;

(в) Аливаа төлбөр, төлбөрийг хүчингүй болгох, мөн зээл, үүрэг эсвэл аливаа бусад хариуцлагаас бүрэн эсвэл хэсэгчлэн чөлөөлөх;

(г) аливаа бусад үйлчилгээ, туслалцаа эсвэл давуу байдал, үүнд үүссэн эсвэл ногдуулсан аливаа хариуцлага эсвэл хязгаарлалт, эсвэл сахилгын эсвэл эрүүгийн шинж чанартай эхлүүлсэн ба эхлүүлээгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хамгаалах, түүнчлэн аливаа эрх эсвэл албан ёсны эрх мэдэл эсвэл албан үүргээ гүйцэтгэх эсвэл гүйцэтгэхгүй байх үйлдлүүд; болон

(д) (а), (б), (в) ба (г)-д заасан утгын хүрээнд аливаа шан харамжийг санал болгох, хэрэгжүүлэх эсвэл амлах;

“ИНВЕСТ сан” гэдгийг Дотоодын дүрэмт хувцас бүхий албан хаагчдын тэтгэврийн хууль-ийн III Хэсэгт заасанчлан байгуулсан ИНВЕСТ сан гэж ойлгоно;

“гишүүн” гэдгийг энэхүү Хуульд заасны дагуу байгуулсан Тэтгэврийн тогтолцоонд хамрагдагч гэж ойлгоно;

“эрх бүхий этгээд” гэдэгт ажил олгогч, итгэмжлэлийн дагуу эрх хүлээн авагч, болон хувь хүн мэт тооцогдох итгэмжлэлд байгаа эд хөрөнгө болон нас барсан хүний хөрөнгийг шилжүүлэн авах сонирхол бүхий аливаа этгээд болон хувь хүн мэт тооцогдох нас барсан хүний хөрөнгө, түүнчлэн Засгийн газар эсвэл нийтийн үйлчилгээний байгууллагад ажиллаж байгаа хүний хувьд тухайн тохиолдлоос хамаарч Засгийн газар эсвэл нийтийн үйлчилгээний байгууллага хамаарна;

“нийтийн үйлчилгээний байгууллага” гэдгийг нийтийн эрүүл мэнд эсвэл нийтийн ус ба цахилгааны үйлчилгээтэй холбоотой бичгээр гаргасан аливаа хуулийн дагуу болон түүнийг хэрэгжүүлэх хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлэх, эсвэл аливаа бичгээр гаргасан хуулийн дагуу зохих хувь хэмжээгээр ногдуулсан эсвэл хураасан мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий корпораци, зөвлөл, хороо, комисс эсвэл бусад этгээд гэж ойлгоно;

“Тэтгэврийн систем” гэдгийг энэ хуулийн 4А-д заасан журмын дагуу байгуулсан Мэргэжлийн тэтгэврийн систем гэж ойлгоно;

“алба” гэдгийг АХМТ-ны албан хаагчийн энгийн алба (цагийн эсвэл байнгын) гэж ойлгоно;

“тусгай мөрдөн байцаагч” гэдгийг Авлигын хэргийг мөрдөх товчооны тусгай мөрдөн байцаагч гэж ойлгоно.

## II ХЭСЭГ АЛБАН ХААГЧДЫГ ТОМИЛОХ

### 3. Дарга болон бусад албан хаагчдыг томилох

(1) Дараах тохиолдолд Ерөнхийлөгч Авлигын хэргийг мөрдөх товчооны Даргыг томилж болно:

Ерөнхийлөгч нь Засгийн газрын эсвэл Засгийн газраас олгосон бүрэн эрхийн хүрээнд ажиллаж буй Сайдын өгсөн санал эсвэл зөвлөмжтэй санал нийлэхгүй бол бүрэн эрхийнхээ хүрээнд Даргыг томилхоос татгалзах эсвэл томилгоог хүчингүй болгож болно.

(2) Ерөнхийлөгч нь Авлигын хэргийг мөрдөх товчооны дэд дарга, туслах дарга болон тусгай мөрдөн байцаагчдын тоог өөрийн үзэмжээр тогтоож болно.

(3) Энэхүү хуульд заасан Авлигын хэргийг мөрдөх товчооны Даргын бүрэн эрх болон чиг үүргийг Даргын тушаал болон захирамжийг үндэслэн тус товчооны дэд дарга эсвэл туслах дарга эдлэх эсвэл гүйцэтгэж болно.

- (4) Авлигын хэргийг мөрдөх товчооны дэд дарга болон туслах дарга нь энэхүү Хуулиар олгосон бүрэн эрхийг тусгай мөрдөн байцаагч дээр ашиглаж болно.
- (5) Ерөнхийлөгч нь дэд дарга, туслах дарга болон тусгай мөрдөн байцаагчдын ялгаатай зэрэглэлийг өөрийн үзэмжээр тогтоож болно.

#### **4. Дарга болон албан хаагчдыг төрийн албан хаагчид тооцох нь**

- (1) Авлигын хэргийг мөрдөх товчооны Дарга, дэд дарга, туслах дарга болон тусгай мөрдөн байцаагчдыг Эрүүгийн хуульд заасан утгын хүрээнд төрийн албан хаагч гэж үзнэ.
- (2) Дээр дурдсан Авлигын хэргийг мөрдөх товчооны албан хаагч тус бүрт үнэмлэх олгох бөгөөд энэ нь тухайн этгээдийг энэхүү хуулийн дагуу ажилд томилсны нотолгоо болно.

#### **4А. Мэргэжлийн тэтгэврийн систем байгуулах нь**

- (1) Сайд журам гаргаж 2001 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш ажилд томилогдсон АХМТ-ны бүх албан хаагчдад зориулан Мэргэжлийн тэтгэврийн систем байгуулах бөгөөд тэдгээр албан хаагчид нь тус системийн гишүүн байна.
  - (2) Энэхүү зүйлийн 1-д заасан журамд дараах тэтгэвэр тэтгэмжийг олгохыг заасан байна: —
    - (а) Тэтгэврийн системийн гишүүн албанад байх хугацаандаа нас барсан эсвэл албанаас өөрийн хүсэлтээр гарсан, тэтгэвэрт гарсан эсвэл албан үүргээсээ чөлөөлөгдсөн тохиолдолд түүнд, эсвэл түүний хууль ёсны бие төлөөлөгч эсвэл асран хамгаалуулагчид шагнал урамшил, мөнгөн олговор, тэтгэвэр эсвэл үүнтэй төстэй бусад тэтгэмжийг олгоно;
    - (б) Тэтгэврийн системийн гишүүн ажил албаа гүйцэтгэж байх явцдаа эсвэл ажил албатайгаа холбоотойгоор амь насаа алдсан эсвэл гэмтэж бэртсэний улмаас олгох тэтгэвэр, шагнал урамшил, мөнгөн олговор, нөхөн төлбөр эсвэл бусад тэтгэмж; болон
    - (в) Тэтгэврийн системийн хуучин гишүүнийг албаа дуусгаж тэтгэвэрт гарсаны дараа олгохоор зааж болох аливаа мөнгөн олговор, санхүүгийн тусламж эсвэл бусад тэтгэмжүүд
  - (3) Энэхүү зүйлийн 1-д заасан журамд дараах зүйлсийг тусгаж болно:
    - (а) Гишүүн тус бүрийн төлбөл зохих шимтгэлийн төлбөр;
    - (б) Гишүүний тэтгэвэрт гарч болох эсвэл гарах шаардлагатай нас;
    - (в) Тэтгэврийн системээс олгох тэтгэвэр, шагнал урамшил, мөнгөн олговор болон эдгээртэй төстэй бусад тэтгэмжийг үнэлэх, олгох болон төлөх, түүнчлэн Тэтгэврийн системийг захиран зарцуулах тэтгэмж хариуцсан ажилтны томилгоо; мөн
    - (г) Тэтгэмж хариуцсан ажилтны шийдвэрийг давж заалдах, түүнчлэн давж

заалдах нэхэмжлэлийг сонсож тэтгэмж хариуцсан ажилтны шийдвэрийг хянаж үзэх нэг эсвэл түүнээс дээш тооны этгээдийг томилох.

(4) Сайд нь энэхүү зүйлийн 1-д заасан журмыг гаргахдаа дараах зүйлсийг тусгасан байна

(а) 2001 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө томилогдсон, Тэтгэврийн хуулийн дагуу (өндөр насын тэтгэвэрт гарсан эсвэл ажил албаа гүйцэтгэж байгаад эсвэл үүнтэй холбоотойгоор амь нас, эрүүл мэндээрээ хохирсоны улмаас) аливаа тэтгэвэр, шагнал урамшил эсвэл бусад тэтгэмж авах эрх бүхий АХМТ-ны албан хаагч бүрийн мэдээлэл; мөн

(б) 2001 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө гэрээний үндсэн дээр тодорхой хугацаагаар томилогдсон бөгөөд гэрээний дагуу аливаа шагнал урамшил эсвэл үүнтэй төстэй бусад тэтгэмж авах эрх бүхий АХМТ-ны албан хаагч бүрийн мэдээлэл, Системийн гишүүнээр элсэх эрх болон энэхүү эрхтэй холбоотой нөхцөл ба шаардлагууд

(5) Энэхүү зүйлийн 4-д дурдсан АХМТ-ны албан хаагчидтай холбоотойгоор гаргах журамд дараахийг заасан байна:

(а) Энэхүү зүйлийн 4(а)-д заасан албан хаагч Тэтгэврийн системд гишүүнээр элсэх тохиолдолд Тэтгэврийн хуульд заасан тэтгэмжүүдийг авах боломжгүй болох боловч Тэтгэврийн системд гишүүнээр элсэхээс өмнө тэтгэвэрт гарсан эсвэл ажил албаа гүйцэтгэх явцдаа амь нас эсвэл эрүүл мэндээрээ хохирсны улмаас Тэтгэврийн хуулийн дагуу авах байсан аливаа тэтгэвэр, шагнал урамшил, эсвэл бусад тэтгэмжийн хэмжээнээс багагүй хэмжээний тэтгэмжүүдийг Тэтгэврийн системээс авах боломжтой болно; мөн

(б) Энэхүү зүйлийн 4(б)-д заасан албан хаагч нь Тэтгэврийн системд гишүүнээр элсэх тохиолдолд тухайн албан хаагч Тэтгэврийн системд гишүүнээр элсэхээс өмнө гэрээнд заасан албаны хугацаагаа дүүргэсэн нөхцөлд гэрээний дагуу авах байсан аливаа шагнал урамшил эсвэл үүнтэй төстэй бусад тэтгэмжийн хэмжээнээс багагүй хэмжээний тэтгэмжүүдийг авах боломжтой хэвээр байна.

(6) Энэхүү зүйлийн 4-д заасан АХМТ-ны албан хаагчдийн хувьд Тэтгэврийн системд гишүүнээр элсэх эсвэл үл элсэхтэй холбоотойгоор 2001 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө хэрэгжүүлсэн эрхийг энэхүү зүйлийн 1-д заасан журмын дагуу хэрэгжүүлсэнд тооцно.

#### 4Б. Тэтгэмж авах нь эрх биш болох тухай

(1) Гишүүн нь өнгөрсөн хугацаанд гүйцэтгэсэн ажилд нөхөн төлбөр авах эсвэл Тэтгэврийн системээс олгож болох аливаа тэтгэвэр, шагнал урамшил, мөнгөн олговор эсвэл бусад тэтгэмж авах бүрэн (абсолют) эрх эдлэхгүй.

(2) Энэхүү хуулийн аливаа зүйл заалт нь Нийтийн үйлчилгээний зөвлөл эсвэл түүний төлөөлөгчийн АХМТ-ны албан хаагчийг албанаас нь нөхөн төлбөргүйгээр чөлөөлөх эрхийг хязгаарлахгүй.

(3) Үндсэн хуулийн 113 дугаар заалтын шаардлагыг хангасан нөхцөлд гишүүнийг болгоомжгүй болон буруутай үйлдэл эсвэл сахилгын зөрчил гаргасан болохыг тэтгэмж хариуцсан ажилтанд хангалттай нотолсон тохиолдолд тэтгэмж хариуцсан ажилтан тухайн гишүүнд Тэтгэврийн системээс олгогдох байсан тэтгэвэр, шагнал урамшил, олговор эсвэл бусад тэтгэмжийн хэмжээг бууруулах эсвэл бүхэлд нь олгохгүй байж болно.

#### **4В. Тэтгэмжийг үл шилжүүлэх тухай**

(1) Тэтгэврийн системээс олгох (гишүүн нас барсан, тэтгэвэрт гарсан эсвэл огцорсон болон бусад шалтгааны улмаас) аливаа төлбөр, мөнгөн олговор эсвэл бусад тэтгэмж, мөн Засгийн газраас Тэтгэврийн системд оруулах хөрөнгө болон эдгэрээс үүсэх хүүг шилжүүлэх эсвэл дамжуулахыг, түүнчлэн дор зааснаас бусад аливаа өр эсвэл төлбөрийн үүргийг дээр дурдсан мөнгөн олговор болон тэтгэмжээс аливаа байдлаар албадан төлүүлэхийг хориглоно:

(а) Засгийн газарт төлөх өр; эсвэл

(б) Төлбөр, мөнгөн олговор эсвэл бусад тэтгэмж олгохоор заасан гишүүний эхнэр эсвэл хуучин/өмнөх эхнэр эсвэл насанд хүрээгүй хүүхдийн (хууль ёсны эсэхээс үл хамааран) амьжиргаанд зориулан тогтмол мөнгөн төлбөр төлөхийг заасан шүүхийн шийдвэр.

(2) Энэхүү зүйлийн 4(А)-д заасан аливаа журмын заалтуудыг харгалзан, гишүүн нас барснаар Тэтгэврийн системээс олгосон эсвэл олгох бүх мөнгөн төлбөр нь:

(а) нас барсан гишүүний гэрээслэл эсвэл гэрээслэл байхгүй тохиолдолд хуулийн дагуу эрх бүхий этгээдийн итгэмжлэлд очсонд тооцно;

(б) Түүний эд хөрөнгийн нэг хэсэг болохгүй эсвэл түүний өрийг төлүүлэхэд зориулагдахгүй; түүнчлэн

(в) Эд хөрөнгийн татварын хуулийн зорилгоор тухайн этгээд нас барснаар шилжиж буй өмчид тооцогдоно.

#### **4Г. Шаардлага хангаагүй байдлыг үл харгалзан олгосон тэтгэмжийг буцаан авах**

Гишүүнийг тэтгэвэрт гарах эсвэл ажлаасаа огцрохоос өмнө мэдэгдсэн тохиолдолд түүнийг ажил албанаас нь халах эсвэл цалинг нь бууруулах үндэслэл болох материаллаг мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах замаар тэтгэмж авсан эсвэл ийм мэдээллийг үл харгалзан тэтгэмж олгосон тохиолдолд Тэтгэврийн системээс гишүүнд олгосон тэтгэвэр, шагнал урамшил, мөнгөн олговор эсвэл бусад тэтгэмжийг Засгийн газар буцаан төлүүлэх, цуцлах эсвэл хэмжээг бууруулж болно.

#### **4Д. Гишүүн дампуурсан ба ял авсаны улмаас түүнд олгох тэтгэмжид үзүүлэх нөлөө**

(1) Засгийн газраас Тэтгэврийн симтемд оруулах шимтгэл болон түүний хүү нь Тэтгэврийн симтемийн гишүүний өрийг төлөхөд зориулагдахгүй бөгөөд гишүүн

дампуурсан тохиолдолд дээр дурдсан шимтгэл болон хүү нь Албан ёсны эрх үүрэг хүлээн авагчид шилжихгүй.

(2) Шүүхээс гишүүнийг дампуурсан эсвэл төлбөрийн чадваргүй болсныг тогтоосон эсвэл зарласан тохиолдолд Дампуурулын хуулийн хүрээнд дээр дурдсан шимтгэл болон хүүг дампуурсан этгээдийн өмчид хамаарахгүй гэж үзнэ.

(3) Тэтгэврийн симтемийн Гишүүн нь тэтгэвэрт гарах эсвэл албанаас огцрохдоо Сингапур улсын эсвэл бусад улсын харьялагдах шүүхийн шийдвэрээр дампуурсан нь тогтоогдсон бөгөөд ийм тогтоол эсвэл шийдвэрээс чөлөөлөгдөөгүй тохиолдолд тэтгэмж хариуцсан ажилтан тухайн гишүүнд олгогдох байсан аливаа тэтгэвэр, шагнал урамшил эсвэл бусад тэтгэмжийг олгохоос татгалзаж болно.

(4) Энэхүү хуулийн дагуу тэтгэвэр эсвэл бусад тэтгэмж авсан аливаа этгээд нь

(а) Сингапур улсын эсвэд бусад улсын харьялагдах шүүхийн шийдвэрээр дампуурсан нь тогтоогдсон; эсвэл

(б) Сингапур улсын эсвэд бусад улсын харьялагдах шүүхээс аливаа гэмт хэрэг эсвэл зөрчил гаргасны улмаас цаазаар авах эсвэл хорионд хөдөлмөр эрхлүүлэх эсвэл аливаа хорих ял авсан тохиолдолд

Сайд тухайн этгээдийн тэтгэвэр тэтгэмжийг даруй зогсоо шийдвэр гаргаж болох бөгөөд үүний дагуу холбогдох тэтгэвэр тэтгэмжийг зогсооно.

(5) Тэтгэврийн системийн Гишүүн эсвэл гишүүн байсан этгээд дампуурсны улмаас түүнд тэтгэвэр, шагнал урамшил эсвэл мөнгөн олговор олгохгүй болсон эсвэл энэхүү зүйлийн 4(а)-д заасны дагуу тэтгэвэр эсвэл мөнгөн олговрыг зогсоосон тохиолдолд Сайд тухайн этгээд дампуураагүй эсвэл гэмт хэрэгт ял аваагүй байсан тохиолдолд түүний тэтгэвэр, шагнал урамшил эсвэл мөнгөн олговрийн хэлбэрээр авах байсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн дараах бүх эсвэл зарим этгээдүүдийн амьжиргаа болон туслалцаа эсвэл ашиг тусын тулд өөрийн зохимжтой гэж үзсэн хувь хэмжээ болон хэлбэрээр олгох буюу зарцуулж болно:

(а) гишүүн эсвэл хуучин гишүүн өөрөө; мөн

(б) түүний эхнэр/нөхөр эсвэл хүүхэд буюу хүүхдүүд.

(6) Сайд энэхүү зүйлийн 5-д заасан бүрэн эрхээ гишүүн эсвэл гишүүн байсан этгээдийн амьдралын үлдсэн хугацаанд эсвэл өөрийн зохимжтой гэж үзсэн үргэлжилсэн эсвэл үргэлжилсэн бус илүү богино хугацаанд хэрэгжүүлж болно.

(7) Энэхүү зүйлийн заалтуудын дагуу тэтгэвэр эсвэл мөнгөн олговор аваагүй эсвэл эдгээрийг түүнд олгохыг зогсоосон байсан этгээд дампуураас бүрэн бөгөөд зохих байдлаар чөлөөлөгдсөн тохиолдолд тухайн чөлөөлөгдсөн өдрөөс эхлэн түүний тэтгэвэр эсвэл мөнгөн олговрыг сэргээнэ.

(8) Энэхүү зүйлийн 5 дугаар заалтын хувьд гишүүн эсвэл гишүүн байсан этгээдийн өрийг барагдуулахад зарцуулсан мөнгөн хөрөнгийг тухайн этгээдийн ашиг тусд зориулсан гэж үзнэ.

(9) Энэхүү зүйлийн 4-д заасныг үл харгалзан 4(б)-д заасны дагуу зогсоосон тэтгэвэр эсвэл мөнгөн олговрыг тухайн этгээд ял авснаас хойш аливаа хугацаанд өршөөлд хамрагдсан тохиолдолд буцаан хэрэглэх үйлчлэлтэйгээр сэргээж олгоно.

(10) Энэхүү зүйлийн 4(б)-д заасны дагуу аливаа этгээдийн тэтгэвэр эсвэл мөнгөн олговрыг зогсоосон тохиолдолд Сайд түүний тэтгэвэр эсвэл мөнгөн олговрын хэлбэрээр авах байсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн түүний эхнэр буюу нөхөр, хүүхэд эсвэл хүүхдүүд, эсвэл ял эдлэх хугацаа нь дуусгавар болсны дараа түүний өөрийн ашиг тусад нь зориулан энэхүү зүйлийн 5-д заасан дампуурлын тохиолдолтой ижил нөхцөл болон ижил шалгуур ба хязгаарлалттайгаар зарцуулах эсвэл олгож болно.

#### **4F. Тэтгэврийн системийг ИНВЕСТ Сангаас бүрдүүлэх нь**

(1) ИНВЕСТ Сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ

(а) ИНВЕСТ Сангийн энэхүү хуулиар хүлээсэн чиг үүргийг нь хангуулах зорилгоор аливаа бичгээр гаргасан хуулийн дагуу Нэгдсэн Сангаас ИНВЕСТ Санд оруулахыг зөвшөөрсөн хөрөнгө;

(б) Энэхүү хуулийн 4(А)-д заасан журмын дагуу Тэтгэврийн системд хамрагдах эрхээ хэрэгжүүлэх энэхүү хуулийн 4(А)4(а)-д дурдсан АХМТ-ны бүх албан хаагчдад хамаарах Тэтгэврийн Сангийн хэсгийг Сангийн Сайдын тогтоосон хэмжээгээр Тэтгэврийн Сангийн хуулийн дагуу байгуулагдсан Тэтгэврийн Сангаас гаргах хөрөнгө

(2) Энэхүү зүйлийн 1-д заасан мөнгөн хөрөнгөөс бүрдэх ИНВЕСТ Сан нь зөвхөн дараах зорилгыг хангахад ашиглагдана:

(а) Тэтгэврийн системээс зөвшөөрсөн аливаа тэтгэвэр, шагнал урамшил, нөхөн төлбөр эсвэл үүнтэй төстэй бусад тэтгэмжийг олгох; мөн

(б) Тэтгэврийн системээс аливаа тэтгэвэр, шагнал урамшил, мөнгөн олговор, нөхөн төлбөр эсвэл үүнтэй төстэй бусад тэтгэмж олгохтой холбоотой бөгөөд энэхүү хуульд заасан журмын дагуу ИНВЕСТ Сангаас гаргахаар заасан бусад зардлыг төлөх.

(3) энэхүү зүйлийн 1-д заасан мөнгөн хөрөнгө нь ИНВЕСТ Санд хөрөнгө оруулалтын мөнгөн хөрөнгө байдлаар орох бөгөөд Тэтгэврийн системээс аливаа ногдол ашиг төлөх зорилгоор ашиглагдахгүй.

### III ХЭСЭГ ЗӨРЧИЛ БА ХАРИУЦЛАГА

#### 5. Авлигын зөрчлийн шийтгэл

Аливаа этгээд өөрөө эсвэл бусадтай хамтран эсвэл бусдаар дамжуулан – аливаа этгээдэд бодит эсвэл санал болгосон аливаа асуудал эсвэл хэлцэлтэй холбоотойгоор аливаа үйлдлийг гүйцэтгэх эсвэл гүйцэтгэхгүй байхын төлөө эсвэл нийтийн үйлчилгээний байгууллагын хувьд тухайн байгууллагын гишүүн, албан хаагч эсвэл ажилтанд бодит эсвэл санал болгосон аливаа асуудал эсвэл хэлцэлтэй холбоотойгоор аливаа зүйлийг гүйцэтгэх эсвэл гүйцэтгэхгүй байхын төлөө өөртөө эсвэл бусдад аливаа шан харамж хууль бусаар өгүүлэх, авах эсвэл авхаар тохирох эсвэл хууль бусдад өгөх, амлах эсвэл санал болгосон тохиолдолд тухайн этгээдэд 100,000 хүртэл долларын тorgууль ногдуулах эсвэл 5 хүртэл жилээр хорих эсвэл эдгээр хариуцлагыг давхар хүлээлгэнэ.

#### 6. Төлөөлөх этгээдтэй хууль бус хэлцэл хийсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага

Хэрэв:

(а) аливаа төлөөлөх этгээд өөрийн эрх бүхий этгээдийн ажил хэрэг эсвэл бизнестэй холбоотойгоор аливаа үйлдлийг хийх эсвэл хийхгүй байх, эсвэл хийсэн эсвэл хийгээгүйн төлөө, эсвэл өөрийн эрх бүхий этгээдийн ажил хэрэг эсвэл бизнестэй холбоотойгоор аливаа этгээдэдийг харж үзэх эсвэл ялгаварлах үйлдэл, эс үйлдэл гаргасны төлөө аливаа этгээдээс өөртөө эсвэл бусдад хууль бусаар аливаа шан харамж авах эсвэл олж авах, эсвэл авахыг зөвшөөрөх эсвэл олж авахыг завдсан;

(б) аливаа этгээд аливаа төлөөлөх этгээд түүний эрх бүхий этгээдийн ажил хэрэг эсвэл бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор аливаа үйлдлийг гүйцэтгэх эсвэл гүйцэтгэхгүй байх, эсвэл гүйцэтгэсэн эсвэл гүйцэтгээгүйн төлөө, эсвэл түүний эрх бүхий этгээдийн ажил хэрэг эсвэл бизнестэй холбоотойгоор аливаа этгээдийг харж үзэх эсвэл ялгаварлах үйлдэл, эс үйлдэл гаргасны төлөө хууль бусаар аливаа шан харамж өгсөн эсвэл өгөхөөр зөвшөөрсөн, эсвэл санал болгосон; эсвэл

(в) Төлөөлөх этгээд нь эрх бүхий этгээдээ хууран мэхлэх зорилгоор ямарваа нэгэн худал, буруу эсвэл алдаатай мэдээлэл агуулсан төлбөрийн баримт, данс тооцоо эсвэл бусад баримт бичгийг санаатайгаар ашигласан, эсвэл аливаа этгээд ийм баримт бичгийг төлөөлөх этгээдэд санаатайгаар өгсөн бол тухайн этгээдийг зөрчил гаргасанд тооцож түүнд 100,000 хүртэл доллараар тorgох эсвэл 5 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл аль аль хариуцлагыг давхар хүлээлгэнэ.

## 7. Зарим тохиолдолд хариуцлагын дээд хэмжээг нэмэгдүүлэх

Засгийн газар эсвэл түүний аливаа агентлаг эсвэл аливаа нийтийн үйлчилгээний байгууллагатай хийх гэрээ эсвэл гэрээ хийх санал, эсвэл иймэрхүү гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх туслан гүйцэтгэх ажлын гэрээтэй холбоотойгоор энэхүү хуулийн 5 ба 6 дугаар зүйлд заасан зөрчил гаргасан этгээдийг 100,000 хүртэл доллараар торгох эсвэл 7 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл аль аль хариуцлагыг давхар хүлээлгэнэ.

## 8. Зарим тохиолдолд авлигын хэрэг үйлдсэнд тооцох

Энэхүү хуулийн 5 ба 6 дугаар зүйлд заасан зөрчил гаргасан этгээдийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад Засгийн газар, түүний аливаа агентлаг эсвэл нийтийн үйлчилгээний байгууллагатай аливаа ажил хэргийн харилцаатай эсвэл ийм харилцаа тогтоохыг зорьж буй этгээд эсвэл түүнийг төлөөлсөн этгээдээс Засгийн газар, түүний аливаа агентлаг эсвэл нийтийн үйлчилгээний байгууллагын ажилтанд аливаа шан харамж төлсөн, өгсөн эсвэл хүлээн авсан болох нь нотлогдвол тухайн шан харамжийг энэхүү хуульд заасанчлан хууль бусаар шийдвэр гаргуулахын тулд буюу гаргуулсны төлөө төлсөн, өгсөн эсвэл хүлээн авсан гэж үзнэ.

## 9. Шан харамж авсан этгээдийг тухайн зорилгоо гүйцэтгэсэн эсэхээс үл хамааран буруутайд тооцох

(1) Энэхүү хуулийн 6(а)-д заасан зөрчилтэй холбоотойгоор аливаа төлөөлөх этгээдийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад тухайн этгээд ямарваа нэгэн шан харамжийг хууль бусаар хүлээн авсан, олж авсан, авахаар зөвшөөрсөн эсвэл олж авах гэж оролдсон нь нотлогдсон бөгөөд тухайн шан харамжийг түүний эрх бүхий этгээдийн ажил хэрэг эсвэл бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор аливаа үйлдлийг гүйцэтгэх эсвэл гүйцэтгэхгүй байх, эсвэл аливаа этгээдийг харж үзэх эсвэл ялгаварлахын тулд эсвэл ингэсний төлөө санал болгосон гэж үзэх эсвэл сэжиглэх үндэслэлтэй тохиолдолд тухайн этгээдэд ингэж гүйцэтгэх эсвэл гүйцэтгэхгүй байх, харж үзэх эсвэл ялгаварлах бүрэн эрх, эрх мэдэл эсвэл боломж байхгүй, эсвэл тухайн үйлдэл, эс үйлдлийг гүйцэтгэх санаагүйгээр шан харамжыг авсан, эсвэл шан харамж авсан ч тухайн үйлдэл, эс үйлдлийг гүйцэтгээгүй эсвэл тухайн үйлдэл, эс үйлдэл нь түүний эрх бүхий этгээдийн ажил хэрэг эсвэл үйл ажиллагаатай хамааралгүй байсан зэргээс үл хамааран тухайн этгээдийг зөрчил гаргасан гэм буруутай гэж үзнэ.

(2) Энэхүү хуулийн 6(б)-д заасан зөрчилтэй холбоотойгоор аливаа этгээдийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад тухайн этгээд аливаа төлөөлөх этгээдийг өөрийн эрх бүхий этгээдийн ажил хэрэг эсвэл бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор аливаа үйлдлийг гүйцэтгэх эсвэл гүйцэтгэхгүй байх, эсвэл аливаа этгээдийг харж үзэх эсвэл ялгаварлах үйлдэл, эс үйлдэл гаргах зохих эрх мэдэлтэй эсвэл боломжтой гэж үзэх буюу таамаглан аливаа

үйлдэл гүйцэтгүүлэх эсвэл гүйцэтгүүлэхгүй байх эсвэл аливаа этгээдийг харж үзэх эсвэл ялгаварлах үйлдэл, эс үйлдэл гүйцэтгүүлэхээр эсвэл гүйцэтгэсний төлөө түүнд хууль бусаар аливаа шан харамж өгсөн, өгөхөөр зөвшөөрсөн эсвэл санал болгосон нь нотлогдвол тухайн төлөөлөх этгээдэд өөрийн эрх бүхий этгээдийн ажил хэрэг эсвэл бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор зохих эрх мэдэл эсвэл боломж байгаагүй, эсвэл тухайн үйлдэл, харж үзэх эсвэл ялгаварлах үйлдэл нь түүний эрх бүхий этгээдийн ажил хэрэг эсвэл бизнейн үйл ажиллагаатай хамааралгүй байсан эсэхээс үл хамааран тухайн этгээдийг зөрчил гаргасан гэм буруутай гэж үзнэ.

## 10. Сонгон шалгаруулалтаас хууль бусаар татгалзуулах

Аливаа этгээд:

(а) Засгийн газар эсвэл аливаа нийтийн үйлчилгээний байгууллагад ажил үйлчилгээ үзүүлэх эсвэл бараа материал нийлүүлэх гэрээний эрх олж авах зорилгоор сонгон шалгаруулалтанд саналаа өгсөн аливаа бусад этгээдэд тухайн саналыг нь татаж авахуулахын тулд эсвэл ингэж татаж авсных нь төлөө шан харамж санал болгосон бол; түүнчлэн

(б) Сонгон шалгаруулалтанд оруулсан саналаа татаж авах буюу татаж авсныхаа төлөө бусдаас шан харамж нэхсэн эсвэл авсан бол түүнд 100,000 хүртэл долларын торгууль эсвэл 7 жил хүртэл хугацаагаар хорих шийтгэл эсвэл аль аль хариуцлагыг давхар хүлээлгэнэ.

## 11. Парламентын гишүүнд авлига өгөх, авах

Аливаа этгээд:

(а) Парламентын гишүүнд гишүүнийхээ хувьд аливаа үйлдлийг гүйцэтгэх эсвэл гүйцэтгэхгүй байхын төлөө аливаа шан харамж санал болгосон бол; мөн

(б) Парламентын гишүүнийхээ хувьд өөрийн ажил үүрэгтэй холбоотойгоор аливаа үйлдлийг гүйцэтгэх эсвэл гүйцэтгэхгүйн төлөө аливаа шан харамж нэхсэн эсвэл хүлээн авсан бол тухайн этгээдийн буруутайг тогтоосноор түүнд 100,000 хүртэл доллараар тorgох эсвэл 7 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл аль аль хариуцлагыг давхар хүлээлгэнэ.

## 12. Нийтийн үйлчилгээний байгууллагын гишүүнд авлига өгөх, авах

Аливаа этгээд:

(а) Нийтийн үйлчилгээний байгууллагын гишүүнд дараах зорилгоор шан харамж санал болгосон бол:

(i) тухайн гишүүнээр нийтийн үйчилгээний байгууллагын хурлаар шийдвэрлэх аливаа арга хэмжээ, шийдвэр эсвэл асуулгыг дэмжсэн эсвэл эдгээрийн эсрэг санал өгүүлэх эсвэл санал өгөхөөс татгалзуулах;

(ii) тухайн гишүүнээр аливаа албан ёсны акт шийдвэрийг гүйцэтгүүлэх эсвэл гүйцэтгэхээс татгалзуулах, эсвэл ийм акт шийдвэр гаргуулахад туслуулах, түргэвчлүүлэх, удаах, гүйцэтгэлд саад учруулах эсвэл зогсоох;

(iii) тухайн гишүүнээр аливаа нэг этгээдэд зориулан санал гаргуулах, санал өгүүлэхгүй байх, гэрээний эрх эсвэл давуу байдал олгоход туслуулах;

(б) эсвэл тухайн этгээд өөрөө нийтийн үйлчилгээний байгууллагын гишүүний хувьд энэхүү зүйлийн (a)-ийн (i), (ii) болон (iii)-д заасан үйлдэл гүйцэтгэх, эсвэл гүйцэтгэхээс татгалзсныхаа төлөө бусдаас шан харамж шаардах эсвэл хүртэл авсан бол, тухайн этгээдийн буруутайг тогтоосноор түүнд 100,000 хүртэл доллараар торгох эсвэл 7 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл аль аль хариуцлагыг давхар хүлээлгэнэ.

### **13. Бусад хариуцлагаас гадна нэмж торгууль ногдуулах нь**

(1) Шүүхээс аливаа этгээдийг энэхүү хуулийг зөрчин шан харамж авч зөрчил гаргасан гэм буруутайг тогтоосон бөгөөд тухайн шан харамж нь мөнгөн хөрөнгө эсвэл үнэ цэнийг нь тодоройлж болохуйц зүйл байх тохиолдолд шүүх тухайн буруутай этгээдэд бусад хариуцлагыг хүлээлгэхээс гадна заасан хугацаанд тухайн шан харамжийн дүнтэй тэнцэх эсвэл шүүхээс тухайн харамжийн үнэ цэнэтэй дүйцэхүйц гэж үзсэн хэмжээний мөнгөн хөрөнгийг торгууль хэлбэрээр төлүүлнэ.

(2) Энэхүү хуулийг зөрчин шан харамж авч хоёр буюу түүнээс дээш тооны зөрчил гаргасан этгээдийг тэдгээр зөрчлийн аль нэгээр эсвэл заримаар нь гэм буруутайд тооцсон бөгөөд шүүхээс түүнд ялын шийтгэл оногдуулах зорилгоор 2010 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 148 дугаар зүйлд заасанчлан ял ногдуулаагүй бусад зөрчлийг нь харгалzan үзсэн нөхцөлд шүүх энэхүү зүйлийн 1-д заасан торгуулийн хэмжээг харгалzan үзсэн бусад зөрчилд холбогдох шан харамжийн нийт дүн эсвэл түүний үнэ цэнээс илүүгүй хэмжээгээр нэмэгдүүлж болно.

### **14. Нууцаар өгсөн бэлгийн үнийн дүнг эргүүлэн олж авах нь**

(1) Аливаа этгээд энэхүү хуулийг зөрчин ямарваа нэгэн шан харамжийг төлөөлөх этгээдэд өгсөн бол эрх бүхий этгээд нь тухайн шан харамж эсвэл түүний үнэ цэнэтэй тэнцэхүйц мөнгөн хөрөнгийг тухайн төлөөлөх этгээд эсвэл шан харамж өгсөн этгээдээс эргүүлэн олж авч болох бөгөөд хариуцагчид энэхүү хуульд заасан зөрчилтэй холбоотойгоор оногдуулсан ял эсвэл гэм буруугүйд тооцох шийдвэр нь шан харамж эсвэл түүний үнэ цэнэтэй тэнцэхүйц мөнгөн хөрөнгийг эргүүлэн олж авахын тулд шүүхээр шийдвэрлүүлэхэд хориг хязгаарлалт болохгүй.

(2) Энэхүү зүйлийн аливаа заалт нь мөнгөн хөрөнгө эсвэл эд хөрөнгийг эргүүлэн олж авахтай холбоотой эрх бүхий этгээдийн хуулиар олгогдсон аливаа эрхийг хязгаарлахгүй эсвэл түүнд нөлөөлөхгүй.

## IV ХЭСЭГ БАРИВЧЛАХ БА МӨРДӨН БАЙЦААХ БҮРЭН ЭРХ

### 15. Баривчлах бүрэн эрх

- (1) АХМТ-ны Дарга эсвэл тусгай мөрдөн байцаагч нь энэхүү Хуульд заасан зөрчил/гэмт хэрэгт хамааралтай эсвэл өөрийнх нь эсрэг үндэслэл бүхий гомдол гарсан эсвэл итгэл төрүүлэхүйц мэдээлэл хүлээн авсан эсвэл хамааралтай байж болох үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд аливаа этгээдийг зөвшөөрөлгүйгээр баривчилж болно.
- (2) АХМТ-ны Дарга эсвэл тусгай мөрдөн байцаагч нь энэхүү зүйлийн 1-д заасны дагуу аливаа этгээдийг баривчлахдаа тухайн этгээдийг нэгжиж түүнээс олдсон гэмт хэргийн ашиг олз эсвэл бусад баримт нотолгоо гэж үзэх үндэслэлтэй бүх эд зүйлийг хураан авч болох бөгөөд ингэхдээ эмэгтэй хүнд хийх нэгжлэгийг зөвхөн эмэгтэй хүнээр хийлгэнэ.
- (3) Дээр заасны дагуу баривчилсан этгээдийг Авлигын хэргийг мөрдөх товчоо эсвэл цагдаагийн газарт хүргэнэ.

### 15A. Дарга ба албан хаагчдыг зэвсгээр хангах

- (1) Авлигын хэргийг мөрдөх товчооны холбогдох албан хаагч бүрийг албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай байж болох бороохой, зэвсэг, сум болон бусад хэрэгслээр хангана.
- (2) Энэхүү зүйлийн 1-д заасан “Авлигын хэргийг мөрдөх товчооны холбогдох албан хаагч” гэдэгт Авлигын хэргийг мөрдөх товчооны Дарга, дэд дарга, туслах дарга эсвэл тусгай мөрдөн байцаагч хамаарна.

### 16. Батлан даалт эсвэл барьцаагаар суллах

- (1) АХМТ-ны Дарга эсвэл тусгай мөрдөн байцаагчийн баривчилсан аливаа этгээдийг АХМТ-ны Дарга эсвэл тусгай мөрдөн байцаагч эсвэл цагдаагийн албан хаагчийн зөвшөөрсний дагуу батлан даалт эсвэл барьцаагаар суллаж болно.
- (2) 2010 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн VI хэсгийн 5 дугаар зүйлийн заалтууд нь энэхүү зүйлд заасний дагуу зөвшөөрсэн аливаа батлан даалт эсвэл барьцаанд мөн адил үйлчилнэ. Үүнтэй холбоотойгоор -
  - (а) “албан хаагч”, “цагдаагийн албан хаагч” эсвэл “түрүүчээс доошгүй цолтой цагдаагийн албан хаагч” гэдэгт АХМТ-ны Дарга эсвэл тусгай мөрдөн байцаагчдыг хамруулж ойлгоно;
  - (б) 2010 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 92 дугаар зүйлд заасан Цагдаагийн дарга гэдэгт АХМТ-ны Даргыг хамруулж ойлгоно.

## 17. Мөрдөн байцаах бүрэн эрх

(1) Дараах зөрчил үйлдэгдсэн аливаа хэрэгт:

(а) Эрүүгийн хуулийн 165 эсвэл 213-аас 215 дугаар зүйлд заасан зөрчил, эсвэл эдгээр зүйлд заасан зөрчлийг үйлдэхээр үгсэн хуйвалдсан, үйлдэхийг завдсан, эсвэл өдөөн дэмжсэн;

(б) Энэхүү хуульд заасан зөрчил;

(в) Энэхүү хуулийн дагуу гүйцэтгэх мөрдөн байцаах ажиллагааны явцад илэрч болох аливаа бусад хуульд заасан ноцтой зөрчил АХМТ-ны Дарга эсвэл тусгай мөрдөн байцаагч нь Прокурорын тушаалгүйгээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар олгогдсон, цагдаагийн мөрдөн байцаах ажиллагаатай холбоотой бүх эсвэл аливаа нэг бүрэн эрхийг хэрэгжүүлж болно.

Ингэхдээ Эрүүгийн хуульд заасан зөрчлийг мөрдөн байцаах ажиллагааг цагдаагийн мөрдөн байцаах ажиллагаа гэж үзэх бөгөөд үүнд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 23 болон 258 дугаар зүйлийн заалтууд АХМТ-ний Дарга эсвэл тусгай мөрдөн байцаагчид цагдаагийн албан хаагчийн нэгэн адил үйлчилнэ.

(2) 2010 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 20(1) болон 258(2) дугаар зүйлийн хүрээнд АХМТ-ны Дарга эсвэл тусгай мөрдөн байцаагчийг цагдаагийн мөрдөн байцаагчаас доошгүй цолтой албан хаагч гэж үзнэ.

## 18. Мөрдөн байцаах тусгай бүрэн эрх

(1) Прокурор нь, аливаа бусад хуульд заасан ямарваа нэгэн зүйл заалтыг үл харгалзан, энэхүү хуульд заасан зөрчил үйлдэгдсэн гэж сэжиглэх зохих үндэслэл байна гэж үзвэл захирамж гарган АХМТ-ны Дарга эсвэл цагдаагийн офицерээс (assistant superintendent) дээш цолтой цагдаагийн албан хаагч эсвэл тусгай мөрдөн байцаагчийг нэр цохин тухайн захирамжинд заасан хэлбэр байдлаар уг хэргийг мөрдөн байцаах зөвшөөрлийг олгож болно. Тухайн захирамжаар аливаа банкны данс, хувьцааны данс, худалдан авалтын данс, зарлагын данс эсвэл аливаа бусад данс, банкин дахь хадгаламжийн хайрцагийг үзэж шалгах эрх олгож болох бөгөөд уг захирамж нь эрх бүхий мөрдөн байцаах ажилтны шаардаж болох бүх буюу аливаа мэдээлэл, данс, баримт бичиг эсвэл эд зүйлийг задруулах буюу гаргаж өгөх хангалттай үндэслэл болно.

(2) Эрх бүхий мөрдөн байцаах ажилтанд дээр дурдсан мэдээлэл, данс, баримт бичиг эсвэл эд зүйлийг гаргаж өгөөгүй этгээдийг зөрчил гаргасанд тооцож гэм буруутайг нь тогтоосноор түүнд 2,000 хүртэл доллараар торгох эсвэл 1 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл аль аль хариуцлагыг хулээлгэнэ.

## 19. Прокурорын зөвшөөрсөн мөрдөн байцаах ажиллагааны бүрэн эрх

Прокурор нь захирамж гарган АХМТ-ны Дарга эсвэл тусгай мөрдөн байцаагчид хуульд заасан аливаа зөрчлийн хувьд цагдаагийн мөрдөн байцаах ажиллагаатай

холбоотой Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан бүх буюу аливаа бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрх олгож болно.

## 20. Банкны данс бүртгэлийг шалгах эрх олгох Прокурорын бүрэн эрх

(1) Прокурор нь Засгийн газар эсвэл түүний агентлаг эсвэл нийтийн үйлчилгээний байгууллагын ажилтан энэхүү хуульд заасан эсвэл Эрүүгийн хуулийн 161-ээс 165, 213-аас 215 дугаар зүйлд заасан зөрчлийг үйлдсэн эсвэл үйлдэхээр үгсэн хуйвалдсан, үйлдэхийг завдсан эсвэл үйлдэхийг өдөөн дэмжсэнийг нотлох баримт тухайн этгээдэд, түүний эхнэр буюу нөхөр, хүүхэд эсвэл тухайн этгээдийн итгэмжлэгдсэн этгээд эсвэл төлөөлөгч гэж үзэх үндэслэлтэй этгээдэд хамааралтай аливаа банкны данс бүртгэлээс олдож болзошгүй гэж үзвэл захирамж гарган АХМТ-ны Дарга эсвэл нэр заан дурдсан тусгай мөрдөн байцаагч эсвэл цагдаагийн офицер (assistant superintendent) буюу түүнээс дээш цолтой цагдаагийн албан хаагчид аливаа данс бүртгэлийг шалгах эрх олгож болох бөгөөд ийнхүү эрх олгогдсон АХМТ-ны Дарга эсвэл тусгай мөрдөн байцаагч эсвэл цагдаагийн албан хаагч нь захирамжинд нэр дурдсан банкинд зохимжтой ямар ч үед нэвтрэн орж данс бүртгэлийг шалган шаардлагатай гэж үзсэн данс бүртгэлийн мэдээллийг хуулбарлан авч болно.

(2) Энэхүү зүйлийн хүрээнд:

“банк” гэдгийг хуулийн дагуу байгуулагдаж, тусгай зөвшөөрөл авсан, Сингапур улсад банкны үйл ажиллагаа явуулж буй аливаа компани гэж ойлгоно;

“банкны данс бүртгэл” гэдгийг банкны хэвийн үйл ажиллагаанд ашиглагддаг аливаа журнал, данс, бэлэн мөнгөний бүртгэл, дансны бүртгэл болон бусад данс эсвэл баримт бичиг гэж ойлгоно.

## 21. Мэдээлэл авах Прокурорын бүрэн эрх

(1) Засгийн газар, түүний агентлаг эсвэл нийтийн үйлчилгээний байгууллагад ажилладаг этгээдийн энэхүү хууль эсвэл Эрүүгийн хуулийн 161- 165 дугаар зүйл болон 213 – 215 дугаар зүйлд заасан зөрчлийг үйлдсэн эсвэл үйлдэхээр үгсэн хуйвалдсан, үйлдэхийг завдсан болон өдөөн дэмжсэнтэй холбоотой мөрдөн байцаах эсвэл шүүх ажиллагааны явцад Прокурор бусад хуульд өөрөөр заасныг үл харгалзан бичгээр мэдэгдэл гаргаж:

(а) тухайн этгээдээс өөрийн болон түүний эхнэр/нөхөр, хүү болон охины өмчлөл болон эзэмшилд байгаа бүх хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл болон тэдгээрийг худалдаж авсан, бэлгэнд авсан, хандиваар авсан, өвлөн авсан эсвэл бусад байдлаар олж авсан огнооны үнэн зөв мэдээллийг бичгээр гаргаж өгөхийг шаардаж болно.

(б) тухайн этгээдээс өөрийн эсвэл түүний эхнэр/нөхөр, хүү болон охины Сингапураас гадаад улсуу шилжүүлсэн аливаа мөнгөн хөрөнгө эсвэл бусад хөрөнгийн үнэн зөв мэдээллийг мэдэгдэлд заасан хугацаанд гаргаж өгөхийг шаардаж болно.

(в) Прокурор мөрдөн байцаах ажиллагаанд тус болох боломжтой гэж үзвэл тухайн этгээдийн өмчлөл болон эзэмшилд байгаа бүх хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн үнэн зөв мэдээллийг бичгээр гаргаж өгөхийг аливаа бусад этгээдээс шаардаж болно.

(г) Татварын байцаагчаас тухайн этгээд, түүний эхнэр/нөхөр, хүү болон охинд хамаарах бүхий л мэдээлэл, түүнчлэн Татварын байцаагчийн эзэмшил эсвэл мэдэлд байж болох тэдгээрт холбогдох аливаа бичиг баримт эсвэл бичиг баримтын баталгаат хуулбарыг гаргаж өгөхийг шаардаж болно.

(д) Засгийн газрын аливаа агентлаг, газар эсвэл байгууллагын удирдах албан тушаалтнаас эсвэл нийтийн үйлчилгээний байгууллагын ерөнхийлөгч, дарга, менежер эсвэл гүйцэтгэх захирлаас түүний эзэмшил буюу мэдэлд байгаа аливаа бичиг баримт эсвэл бичиг баримтын баталгаат хуулбарыг гаргаж өгөхийг шаардаж болно.

(е) Аливаа банкны менежерээс тухайн этгээд эсвэл түүний эхнэр/нөхөр, хүү болон охины тухайн банкин дахь дансны мэдээллийн хуулбарыг гаргаж өгөхийг шаардаж болно.

(2) Энэхүү зүйлийн 1-д заасанчлан Прокуророос мэдэгдэл хүлээн авсан этгээд аливаа хуульд өөрөөр заасныг эсвэл аливаа нууцлал хадгалах амлалтыг үл харгалзан тухайн мэдэгдэлд дурдсан шаардлагыг заасан хугацаанд биелүүлнэ. Мэдэгдэлд заасан шаардлагыг санаатайгаар үл хайхарсан эсвэл биелүүлээгүй этгээддэд 10,000 хүртэл доллараар торгох эсвэл 1 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл аль аль хариуцлагыг давхар хүлээлгэнэ.

## 22. Нэгжих болон хураах бүрэн эрх

(1) Шүүгч эсвэл АХМТ-ны Дарга шаардлагатай гэж үзсэн мэдээлэлтэй танилцаж эсвэл судалгаа хийсний дараа аливаа нэгэн орон байранд дараахтай холбоотой нотлох баримт, эд зүйл болон эд хөрөнгө байж болох хангалттай үндэслэл байна гэж үзвэл:

(а) энэхүү хууль эсвэл Эрүүгийн хуулийн 161- 165 дугаар зүйл болон 213- 215 дугаар зүйлд заасан зөрчил үйлдэгдсэн;

(б) эдгээр зөрчлийг үйлдэхээр үгсэн хуйвалдсан, үйлдэхийг завдсан болон өдөөн дэмжсэн үйлдэл

Шүүгч эсвэл АХМТ-ны Дарга нь тусгай мөрдөн байцаагч эсвэл мөрдөн байцаагчаас доошгүй цолтой цагдаагийн албан хаагчид зөвшөөрөл олгож тухайн орон байранд шаардлагатай бол хүчээр нэвтрэн орж нэгжлэг хийн холбогдох баримт бичиг, эд зүйл эсвэл эд хөрөнгийг хураан авах болон saatuuлах даалгавар өгч болно.

(2) Тусгай мөрдөн байцаагч эсвэл мөрдөн байцаагчаас доошгүй цолтой цагдаагийн албан хаагч аливаа нэгэн орон байранд доорхтой холбоотой аливаа нотлох баримт бичиг, эд зүйл эсвэл эд хөрөнгийг нуусан эсвэл байршуулсан байх хангалттай үндэслэл байна гэж үзвэл -

(а) энэхүү хууль эсвэл Эрүүгийн хуулийн 161- 165 дугаар зүйл болон 213 – 215 дугаар зүйлд заасан зөрчил үйлдэгдсэн;

(б) эдгээр зөрчлийг үйлдэхээр үгсэн хуйвалдсан, үйлдэхийг завдсан болон өдөөн дэмжсэн үйлдэл, мөн тусгай мөрдөн байцаагч эсвэл цагдаагийн албан хаагч нь нэгжлэг хийх зөвшөөрөл авахтай холбоотойгоор цаг алдсаны улмаас хайж буй бичиг баримт, эд зүйл эсвэл эд хөрөнгийг олох боломжгүй болох магадлалтай гэж үзэх хангалттай үндэслэл байгаа тохиолдолд тухайн мөрдөн байцаагч эсвэл цагдаагийн албан хаагч нь тухайн орон байртай холбогдуулан энэхүү зүйлийн 1-д заасан бүх бүрэн эрхийг тус зүйлд заасны дагуу түүнд зөвшөөрөл олгосон мэт бүрэн хэрэгжүүлж болно.

## V ХЭСЭГ НОТОЛГОО

### **23. Заншил гэж үзэх нотолгоог зөвшөөрөхгүй байх**

Энэхүү хуулийн дагуу гүйцэтгэх аливаа иргэний эсвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэхүү хуульд заасан аливаа шан харамжийг өгч авах нь аливаа ажил мэргэжлийн хувьд заншил болсон тухай нотолгоог зөвшөөрөхгүй.

### **24. Мөнгөн хөрөнгө эсвэл эд хөрөнгийн нотолгоо**

(1) Энэхүү хууль эсвэл Эрүүгийн хуулийн 161 – 165 болон 213 – 215 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн, эсвэл үйлдэхээр үгсэн хуйвалдсан, үйлдэхийг завдсан эсвэл өдөөн дэмжсэн хөргийг шүүхээр хянан шийдвэрлэх эсвэл хянан шалгах ажиллагаанд шүүгдэгч этгээд нь өөрийн мэдэгдэж буй орлогын эх үүсвэртэй нийцэхгүй хэмжээний мөнгөн хөрөнгө эсвэл эд хөрөнгө эзэмшдэг бөгөөд түүнийгээ хуулийн дагуу олж авсан гэдгээ хангалттай баталж чадахгүй байгаа, эсвэл сэжиглэгдэж буй зөрчил үйлдэгдэх үед шүүгдэгч өөрийн мөнгөн хөрөнгө эсвэл эд хөрөнгөө нэмэгдүүлсэн бөгөөд түүнийгээ хуулийн дагуу олж авсан гэдгээ хангалттай баталж чадахгүй байгаа нь шүүгдэгч этгээд бусдаас шан харамж авсан, авахаар зөвшөөрсөн эсвэл олж авахыг завдсан бөгөөд шан харамжыг хууль бусаар авсан, авахаар зөвшөөрсөн эсвэл олж авахыг завдсан болохыг шүүхэд нотолж болох ба гэрчийн мэдүүлгийг баталгаажуулж болно.

(2) Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын хүрээнд аливаа бусад этгээдийн мэдэлд байгаа эд хөрөнгийг тухайн этгээд болон шүүгдэгч этгээдийн хоорондын харилцаа эсвэл аливаа бусад нөхцөл байдлыг харгалзан тухайн этгээд шүүгдэгчийн өмнөөс өөрийн мэдэлд байлгаж байгаа эсвэл аливаа нэмэгдэл хөрөнгийг түүний итгэмжилснээр олж авсан эсвэл шүүгдэгч этгээдээс авсан бэлэг хэлбэрээр өөрийн эзэмшилд байлгаж байгаа гэж үзэх үндэслэлтэй тохиолдолд шүүгдэгч этгээдийг тухайн эд хөрөнгийг эзэмшдэг эсвэл нэмэгдэл хөрөнгө олж авсан гэж үзнэ.

## 25. Хамтрагчийн нотолгоо

Аливаа хуульд өөрөөр заасныг үл харгалзан 24 дүгээр зүйлд заасан аливаа хэрэг хянан шийдвэрлэх эсвэл шалгах ажиллагаанд аливаа гэрчийг төлөөлөх этгээд эсвэл нийтийн үйлчилгээний гишүүнд шан харамж төлсөн, хүргэж өгсөн эсвэл түүний өмнөөс өгсөн гэдэг шалтгаанаар найдваргүйд тооцож болохгүй.

### VI ХЭСЭГ БУСАД

## 26. Нэгжлэг үзлэг хийх ажилд саад учруулах

Аливаа этгээд:

- (а) орон байранд нэвтрэх эсвэл нэгжлэг хийх зөвшөөрөл бүхий АХМТ-ны Дарга эсвэл албан хаагчийг нэвтрүүлэхээс татгалзсан;

(б) АХМТ-ны Дарга эсвэл албан хаагчийг энэхүү хуулиар олгогдсон нэвтрэх эрхээ хэрэгжүүлэхэд эсвэл аливаа бусад чиг үүрэг болон бүрэн эрхээ гүйцэтгэхэд нь эсэргүүцсэн, саад болсон эсвэл саатуулсан;

(в) АХМТ-ны Дарга эсвэл албан хаагчийн зүгээс энэхүү хуульд заасан ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэгүй;

(г) өөрийн эрх мэдлийн хүрээнд гаргаж өгөх боломжтой мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан эсвэл гаргаж өгөөгүй бол тухайн этгээдийг зөрчил гаргасан гэм буруутайд тооцож түүнд 10,000 хүртэл долларын эсвэл 1 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл аль аль хариуцлагыг давхар хүлээлгэнэ.

## 27. Мэдээлэл гаргаж өгөх хуулиар хүлээсэн үүрэг

АХМТ-ны Дарга эсвэл аливаа албан хаагч нь энэхүү хуульд заасан шалгаж судлах ажил үүрэгт нь хамаарах асуудлаар аливаа этгээдээс мэдээлэл гаргаж өгөхийг шаардаж болох бөгөөд ийнхүү шаардсаны дагуу мэдээлэл гаргаж өгөх боломжтой этгээд тухайн мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

## 28. Худал мэдүүлэг, мэдээлэл өгөх

Аливаа этгээд зориудаар:

(а) энэхүү хуульд заасан эсвэл Эрүүгийн хуулийн 165, 213, 214, болон 215 дугаар зүйлд заасан зөрчилтэй холбоотой аливаа худал мэдээлэл өгөхөд нөлөөлсөн мэдээлэл өгсөн эсвэл өгөхөд нөлөөлсөн;

(б) АХМТ-ны Дарга эсвэл тусгай мөрдөн байцаагчид аливаа бусад худал эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн эсвэл өгөхөд нөлөөлсөн бол, түүнд 10,000 хүртэл доллараар торгох эсвэл 1 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл аль аль хариуцлагыг давхар хүлээлгэнэ.

## 29. Зөрчил гаргахад өдөөн дэмжих

Эрүүгийн хуульд заасанчлан дараахийг өдөөн дэмжсэн этгээдийг—

- (а) Энэхүү хуульд заасан зөрчил үйлдэхийг;

(б) Сингапур улсад үйлдсэн тохиолдолд энэхүү хуулийн дагуу зөрчилд тооцогдох аливаа үйлдлийг Сингапурт байрлах буюу оршин суух эрх бүхий этгээдийн ажил хэрэг эсвэл бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор гадаад улсад үйлдэхийг, зөрчил гаргасан гэм буруутайд тооцож тухайн зөрчилд нь харгалзах хариуцлагыг хүлээлгэнэ.

### **30. Зөрчил үйлдэхээр завдах**

Энэхүү хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх зөрчлийг үйлдэхээр завдсан аливаа этгээдийг тухайн зөрчлийг үйлдсэнд тооцож түүнд тухайн зөрчилд харгалзах хариуцлагыг хүлээлгэнэ.

### **31. Үгсэн хуйвалдах**

Энэхүү хуульд заасан зөрчлийг үйлдэхээр Эрүүгийн хуульд заасанчлан үгсэн хуйвалдсан аливаа этгээдийг зөрчил үйлдсэнд тооцож түүнд тухайн зөрчилд харгалзах хариуцлагыг хүлээлгэнэ.

### **32. Зөрчил ноцтой болох нь**

- 1) Энэхүү хуульд заасан зөрчил бүрийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хүрээнд **ноцтой** зөрчил гэж үзнэ.
- (2) Төрийн албан хаагч нь түүнд хууль бусаар аливаа шан харамж өгсөн эсвэл санал болгосон этгээдийг баривчилж хамгийн ойр байрлах цагдаагийн газар хүлээлгэж өгнө. Энэхүү заалтыг аливаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй тохиолдолд тухайн этгээдийг зөрчил гаргасан буруутайд тооцож түүнд 5,000 хүртэл долларын тorgууль ногдуулах эсвэл 6 сар хүртэл хугацаагаар хорих эсвэл аль аль хариуцлагыг давхар хүлээлгэж болно.

### **33. Ялыг прокурорын зөвшөөрлөөр оногдуулах нь**

Энэхүү хуулийн дагуу оногдуулах ялыг зөвхөн прокурор эсвэл түүний зөвшөөрлөөр оногдуулна.

### **34. Энэхүү хуульд заасан зөрчлийг дүүргийн шүүхээр хянан шийдвэрлэх нь**

Аливаа бичгээр гаргасан хуульд өөрөөр заасныг үл харгалзан энэхүү хуульд заасан аливаа зөрчлийг хянан шийдвэрлэх болон холбогдох бүрэн шийтгэлийг ногдуулах ажиллагаа Дүүргийн шүүхэд харьяалагдана.

### **35. Хэрэгтнийг байцаан шалгах**

- (1) Энэхүү хууль эсвэл Эрүүгийн хуулийн 161 – 165 болон 213 – 215 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн, эсвэл үйлдэхээр үгсэн хуйвалдсан, үйлдэхийг завдсан эсвэл өдөөн дэмжсэн хэрэгт хоёр эсвэл түүнээс дээш тооны этгээд яллагдаж байгаа тохиолдолд шүүхээс тэдгээрийн нэг эсвэл түүнээс дээш тооны этгээдийг гэрчийн хувиар нотолгоо өгөхийг шаардаж болно.

(2) Тангараг өргөн хууль ёсны асуултанд хариулахаас татгалзсан дээр дурдсан этгээдэд ингэж татгалзсан гэрчид хуулийн дагуу авах арга хэмжээний нэгэн адил арга хэмжээг Хотийн эсвэл Дүүргийн шүүх авч болно.

(3) Энэхүү зүйлийн 1-д заасны дагуу нотолгоо өгөх шаардлагатай этгээд шүүхийн үзэж буйгаар байцаан шалгасан бүхий л зүйлд үнэн зөв бөгөөд бүрэн мэдээлэл өгсөн тохиолдолд тухайн этгээд үнэн зөв ба бүрэн мэдээлэл өгсөн бөгөөд тухайн мэдээлэлд дурдсан аливаа зүйлтэй холбоотойгоор түүний эсрэг үүсгэж болох бүхий л хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хамгаалсныг дурдсан хариуцлагаас чөлөөлөх гэрчилгээг Шүүгчээс авах эрхтэй болно.

### **36. Мэдээлэгчийг хамгаалах**

(1) Энд зааснаас бусад тохиолдолд энэхүү хуульд заасан зөрчилтэй холбоотой аливаа гомдлыг аливаа иргэний эсвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотолгоо болгон авч үзэхгүй бөгөөд аливаа гэрчид мэдээлэгчийн нэр эсвэл хаягийг задруулах, эсвэл тухайн мэдээлэгчийг илчлэхэд хүргэж болзошгүй аливаа зүйлийг мэдүүлэхийг үүрэг болгохгүй эсвэл зөвшөөрөхгүй.

(2) Шүүхэд иргэний эсвэл эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт болон ашиглагдах эсвэл шалгагдах аливаа баримт бичигт мэдээлэгчийн нэрийг дурдсан эсвэл түүнийг тодорхойлсон эсвэл мэдээлэгчийг илчлэхэд хүргэж болзошгүй аливаа бичилт, тэмдэглэгээ агуулагдсан тохиолдолд шүүх мэдээлэгчийг хамгаалах үүднээс шаардлагатай гэж үзсэн хэмжээнд ийм бүхий л бичилт, тэмдэглэгээг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас өмнө нуун далдуулах эсвэл арилгуулна.

(3) Шүүх энэхүү хуульд заасан зөрчилтэй холбоотой хэргийг бүрэн хянаж үзээд мэдээлэгчийг өөрийн гомдолдоо худал гэдгийг нь мэдэж байсан эсвэл худал гэж итгэж байсан эсвэл үнэн бус гэж итгэж байсан ноцтой мэдээллийг санаатайгаар оруулсан гэж үзвэл, эсвэл аливаа бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдээлэгчийг илчлэхгүйгээр хэргийг шударгаар шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл шүүх гомдлийн эх хуулбарыг ашиглахыг шаардаж болох бөгөөд мэдээлэгчид холбогдох шалгалт явуулах болон мэдээллийг бүрэн задруулахыг шаардаж болно.

### **37. Сингапур улсын иргэдийн гадаадад үйлдсэн гэмт хэрэгт хүлээх хариуцлага**

(1) Энэхүү хуулийн заалтууд нь Сингапур улсад болон гадаадад оршин суугаа Сингапур улсын иргэдэд хүчин төгөлдөр үйлчилнэ; түүнчлэн энэхүү хуульд заасан гэмт хэргийг Сингапур улсын иргэн Сингапураас бусад аливаа улсад үйлдсэн тохиолдолд тухайн гэмт хэргийг Сингапур улсад үйлдсэнтэй нэгэн адил үзэж тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэж болно.

(2) Энэхүү зүйлийн дагуу аливаа этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн этгээдийн эсрэг Сингапураас бусад улсад үйлдсэн тухайн хэрэгтэй холбоотойгоор дахин хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахаас хамгаална.

## Сургагч багшийн товч намтар

Нэр:	Чуа Чер Яак
Төрсөн он, сар, өдөр:	1947 оны 6 дугаар сарын 21
Академик зэрэг:	Бакалавр, Сингапурын их сургууль, 1970 он
Мэргэжил дээшлүүлэх сургалт:	Умард-өмнөдийн их сургууль, АНУ, 1977 Брамшил цагдаагийн коллеж, ИБУИНВУ, 1984
Хаяг:	22 Жалан Ченгам, Сингапур 578305
Электрон шуудан:	<a href="mailto:cheryak@gmail.com">cheryak@gmail.com</a>

Ажил эрхлэлтийн байдал:

- Мөрдөн байцаагч, 1970-1972
- Ахлах офицер, 1972
- Цагдаагийн нөөц ангийн хэргийг түр хамарагч, 1973-1974
- Төлөвлөлт хариуцсан офицер, 1974-1976
- Умард-өмнөдийн их сургуульд сургалтад хамрагдсан, 1976-1977
- Замын цагдаагийн газрын дарга, 1977-1978
- "Б" дивизийн захирагч, 1978-1979
- "Г" дивизийн захирагч, 1979-1980
- Сургалтын төвийн дарга, 1980-1985
- Хүний нөөц, тамгын хэлтсийн дарга, 1985-1987
- Эрүүгийн мөрдөн байцаах газрын дарга, 1987-1991
- Хорих байгууллагуудыг хариуцсан газрын орлогч дарга, 1991-1994
- Авлигын хэргийг мөрдөх товчооны дарга, 1994-2005
- Цагдаагийн академийн тэргүүн дарга, 2005
- Засаглал болон авлигатай тэмцэх олон улсын зөвлөх, 2005 оноос өнөөг хүртэл
- Төрийн албаны коллежид багш, 2005 оноос өнөөг хүртэл
- Төрийн албаны бодлогын Ли Куан Их сургуулийн боловсрол хариуцсан захирал, 2005 оноос өнөөг хүртэл
- Сингапурын үндэсний их сургуулийн Бизнесийн сургуулийн профессор, 2010-2011
- Сингапурын үндэсний их сургуулийн профессор, 2010

Удирдан явуулсан сургалтууд:

- Авлигатай тэмцэх сургалт, НҮБ-ын Ази, Алс Дорондын Институт, 2003
- Мөрдөн байцаалтыг удирдан явуулах ба ажлын үр дүнгийн шалгуурын тогтолцоо, Бруней, 2005

- Авлигатай тэмцэх сургалт, Австралийн үндэсний их сургууль, 2005
- Хамтын нөхөрлөлийн орнуудад зориулсан авлигатай тэмцэх сургалт, Сингапурын төрийн албаны коллеж, 2005-2010
- Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаах, хяналт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, Бутан, 2007
- ACEAH-ы орнуудад зориулсан авлигатай тэмцэх сургалт, Сингапурын төрийн албаны коллеж, 2007
- Стратегийн менежмент ба авлигатай тэмцэх хөтөлбөр, Малайзын авлигатай тэмцэх коллеж, 2007
- Номхон далайн арлын орнуудад зориуосан авлигатай тэмцэх сургалт, Малайзын авлигатай тэмцэх коллеж, 2007
- Авлигатай тэмцэх сургалт, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Вьетнам, 2005-2006
- Авлигатай тэмцэх сургалт, Малайзын авлигатай тэмцэх коллеж, 2007-2008
- Авлигатай тэмцэх сургалт, Хонгконгийн их сургууль, 2007-2010
- Казакстаны төрийн албан хаагчдад зориулсан авлига ба сүүдрийн эдийн засгийн тухай сургалт, Төрийн албаны бодлогын Ли Куан Ив сургууль, 2010
- Үр дүнтэй хянан шалгалт ба төрийн хяналт шалгалтын байцаагчдын сургалт, Вьетнам, 2007-2008
- Сингапурын туршлагыг танилцуулах сургалт, Бээжин, 2008
- Авлигаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй механизм, стратеги төлөвлөлт ба менежмент, Филиппин, 2009
- Авлигатай тэмцэх сургалт, Ботсвана, 2009
- Авлигатай тэмцэх сургалт, Замби, 2009
- Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны ажилтан албан хаагчдад зориулсан авлигатай тэмцэх сургалт, Монгол, 2009
- БНСВУ-ын төрийн албан хаагчдад зориулсан авлигатай тэмцэх сургалт, Вьетнам, 2009
- Авлигатай тэмцэх олон улсын туршлага, арга барил, Казакстан, 2010
- БНСВУ-ын төрийн албан хаагчдад зориулсан авлигатай тэмцэх сургалт, Вьетнам, 2010

Зөвлөхөөр ажилласан төсөл хөтөлбөрүүд:

- Камбожийн авлигын эсрэг хууль, 2005
- Бангладешийн авлигатай тэмцэх байгууллага, 2005
- Нигерийн эдийн засаг, сэнхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хороо, 2006
- Вьетнамын хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн яамны албан хаагчдын сургалт, 2005-2006


- БНСВУ-ын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, 2006
- Бутан Улсын авлигатай тэмцэх үндэсний стратеги, 2006
- Бутан Улсын Авлигатай тэмцэх газарт зориулсан сургалт, 2006-2007
- Шри-Ланкын авлигатай тэмцэх газрын стратегийг төлөвлөх, 2007
- Камбожийн авлигатай тэмцэх газрыг байгуулах, 2007
- Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, ёс зүйн дүрэм боловсруулах, 2009

Авлигатай тэмцэх чиглэлээр хийсэн судалгааны ажууд:

- “Спортын салбар дахь авлига”, Хонгконгийн авлигатай тэмцэх газар, 1995
- “Сайн хүн. Сайн хууль”, Хонгконгийн авлигатай тэмцэх газар, 1999
- “Авлига: Хяналт: Арга зам”, 2002
- “Төрийн албаны шударга ёс ба авлигатай тэмцэх”, БНХАУ, 2002
- “Авлигыг хянах: зөвхөн тогтолцоо, дэг, үйл ажиллагаанаас хамаарахгүй”, 2003
- “Авлигыг хянах: Сингапурын чиг хандлага”, Малайз, 2004
- “Авлигаас ангижирсан Сингапур жор: номонд бичигдээгүй зүйлс”, 2005
- “Авлигыг хянах: хөгжил дэвшил ба өнгөрснөө эргэн харах”, Монгол Улс, 2005
- “Авлигатай тэмцэх Сингапурын арга зам”, Австрали, 2005
- “Сингапурын цагдаагийн газрын авлигын эсрэг тэмцэл”, Малайз, 2006
- “Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам дахь авлига: авлигат өртөмхий байдал”, 2010

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

ТЭМДЭГЛЭЛ



## ТЭМДЭГЛЭЛ



ТЭМДЭГЛЭЛ

